



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Прокурорын байгууллагын 90 жилийн ойд зориулав.

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ОЛСОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫГ БУЦААН АВАХ АЖИЛЛАГАА ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2020 он

ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН:

М.ГАНТУЛГА	Улсын Ерөнхий прокурорын газрын ахлах прокурор, Хууль цаазын шадар зөвлөх, Хууль зүйн ухааны доктор /Ph.D./
Г.ЦЭЦЭГМАА	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн прокурорын газрын ахлах прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх, Хууль зүйн магистр
Б.БАТ-ОРШИХ	Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, ХШҮС-ынн хэлтсийн дарга, Хууль цаазын тэргүүн зөвлөх, Хууль зүйн магистр
Ц.АРИУНБОЛД	Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, ХБМБАХТХ-ийн дарга, Хууль цаазын тэргүүн зөвлөх, Хууль зүйн магистр
Ж.БОЛОРПҮРЭВ	Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга, ахлах прокурор, Хууль цаазын шадар зөвлөх, Хууль зүйн магистр
Д.ДУЛАМСҮРЭН	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Хууль зүйн магистр
С.ГАЛБАДРАХ	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар

ХЯНАЖ, РЕДАКТОРЛАСАН:

М.ГАНТУЛГА	Улсын Ерөнхий прокурорын газрын ахлах прокурор, Хууль цаазын шадар зөвлөх, Хууль зүйн ухааны доктор /Ph.D./
------------	---

Цаасны хэмжээ: В5

Хэвлэлийн хуудас: 11.5

Хэвлэсэн тоо: 500

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

ГАРЧИГ

НЭГ. ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	4
1.1. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай ойлголт	4
1.2 Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хэрэгцээ, тавигдах шаардлага	6
1.3. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хамтын ажиллагаа	11
1.4 Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд авлигын гэмт хэргийн замаар бий болсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь	19
 ХОЁР.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХЭД ПРОКУРОРЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО	23
2.1 Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн үндэслэл	23
2.2 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр прокурорын гүйцэтгэх үүрэг	29
 ГУРАВ.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛУУД	36
3.1 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл түүнийг шийдвэрлэх арга зам	36
3.2 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт боловсруулахад анхаарах асуудлууд	40
 ДӨРӨВ: ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ОЛСОН ОРЛОГО, ЭД ХӨРӨНГИЙГ ШАЛГАЖ ТОГТООХ, БИТҮҮМЖЛЭХ, БУЦААН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ	47
4.1. Урьдчилсан дүн шинжилгээ	47
4.2. Хөрөнгийг олж тогтоох, хамгаалах	51
4.3. Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөлт	55
4.4. Хугацаа	59
4.5. Шаардагдах мэдээлэл цуглуулах	62
4.6. Холбоо барих	63
4.7. Харилцаа холбоо	68
4.8. Зэрэгцсэн мөрдөн шалгах ажиллагаа	71
4.9. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөл	75
4.10. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх	80
 ТАВ: ХАВСРАЛТ	84

НЭГ. ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай ойлголт

Дэлхийн улс орнууд хилийн чанад дахь өөрийн иргэдийг хамгаалах, улсынхаа ашиг сонирхлыг хангахын тулд бусад улстай энэ талаарх харилцаагаа өргөтгөх, гүнзгийрүүлэх шаардлага улам бүр өссөөр байгаа билээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг ганцхан тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх төдийгүй илүү зохион байгуулалттай бөгөөд хил дамнасан шинжтэй болж байна.

Энэ утгаараа зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах, нотлох ажиллагаа зөвхөнтухайн улсын хууль, тогтоомж, хуулийн байгууллагын үйл ажиллагаа, хүчин чармайлтаар шийдвэрлэгдэх боломжгүй нөхцөл байдал бий болж байна.

Иймд бусад улс орны ижил төрлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байжтухайн гэмт хэргийг нотлох, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх тул улс орнууд хоёр талын болон олон талт эрүүгийн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд нэгдэн орох шаардлага бий болдог.

Дипломат шугамаар бусад улстай харилцах нь цаг хугацааны хувьд удаашралтай байдаг хэдий ч хүсэлт хүлээн авагч гадаад улс орон бүр өөрийн гэсэн онцлог бүхий эрх зүйн тогтолцоотой тул хүсэлтийг боловсруулахдаа тухайн улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг мөрдлөг болгохоос гадна Монгол Улс болон тухайн улс хооронд тогтсон дипломат харилцааг хүндэтгэн үзэх шаардлагатай юм.

Гэвч улс орон тус бүр өөр өөрийн улсын хууль тогтоомжид заасны дагуу харилцан адилгүй шаардлагыг тавьдаг тул эрх зүйн туслалцаа хүсэх эрх зүйн үндэслэл, шаардлагын талаарх нөхцөл бүрийг нэг бүрчлэн дурдах боломжгүй юм.

Эрдэмтэн, судлаачид эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг онолын хувьд өөр өөрөөр томъёолдог хэдий ч “мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан үндэслэл, журмын дагуу гадаад улсын нутаг дэвсгэрт шаардлагатай нотлох баримтыг

цуглуулах, бэхжүүлэхэд чиглэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгүүлэх тухай хүсэлт үйлдэх, илгээх, эрх зүйн туслалцаа үзүүлэх цогц үйл ажиллагаа”-ааг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэж тодорхойлжээ.

Эрх зүйн туслалцааны эх сурвалжуудыг дараах байдлаар авч үздэг.

1. Хатуу бүтэц:

- Олон улсын гэрээ конвенцууд, (жишээ нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенци, НҮБ-ын Үндэстэн дамнасан гэмт хэргийн тухай конвенци)
- Бүс нутгийн гэрээ конвенциуд,
- Улс хоорондын гэрээ,
- Дотоодын хууль тогтоомж,

2. Зөөлөн бүтэц:

- FATF/ФАТФ байгууллагаас гаргасан зөвлөмжүүд,

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын хамтын ажиллагааны чухал хэлбэр бол Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудал бөгөөд олон улсын түвшинд хоёр талт, олон талт гэрээгээр зохицуулдаг.

Олон талт олон улсын гэрээнээс тухайлбал, Авлигын эсрэг НҮБ-ын конвенци болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын /Палермогийн/ конвенци түүний нэмэлт 3 протоколыг дурдаж болох ба Монгол Улс эдгээр конвенцид нэгдэн орсон байна.

Дээрх конвенциудад нэгдэн орсноор гишүүн орнууд авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль бусаар олсон орлого, эд зүйл, хөрөнгийг буцаан авах ажиллагааны асуудлаар улс орнууд холбогдох байгууллагаараа дамжуулан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх салбарт хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн юм.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын / Палермогийн/ конвенцид хуулийн этгээдийн хүлээх хариуцлага, албадлагын арга хэмжээ авах, хэрэг хянан шийдвэрлэх эрх, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргууд, гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах болон хууль бусаар олсон орлого, эд зүйл, хөрөнгийг буцаан авах ажиллагаа, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа, техникийн туслалцаа үзүүлэх зэрэг асуудлууд тусгагджээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар зүйлд “гадаад

улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг нэгжлэх хийх, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх болон олон улсын бусад гэрээ хэлэлцээрийн дагуу хийж гүйцэтгэнэ” гэж заасны дагуу Монгол Улс Авлигын эсрэг конвенцид 2005 онд нэгдэж орсон байна.

Энэ конвенцийн хүрээнд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу олж авсан баримтыг нотлох баримтыг нотлох баримтаар үнэлэх боломжтой юм.

Иймд уг конвенц болон олон улсын байгууллагын гэрээний шугамаар авч цуглуулсан бусад мэдээ, мэдээллүүдийг хэрхэн үнэлж, ял шийтгэл ногдуулах талаар нэгдсэн ойлголтыг бий болгох нь зүйтэй юм.

Улс гүрнүүд олон улсын эрх зүйн үндсэн субъектын хувьд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулдаг бөгөөд уг гэрээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх хэлэлцэн тохирогчэрх бүхий байгууллагыг тогтоож өгдөг учраас гэрээнд тогтоосон байгууллагуудаар дамжуулан эрх зүйн туслалцаа үзүүлэх олон улсын үүргээ хэрэгжүүлэхэрх зүйн үндэс нь бүрдсэн байна.

Энэ утгаараа төрийн байгууллагууд хоорондын харилцааг журамлан зохицуулсан шинжийг агуулдаг бөгөөд холбогдох байгууллагуудтай эрх зүйн туслалцааны гэрээ байгуулах замаар шууд харилцах нь шуурхай бөгөөд үр дүнтэй байдаг.

Захиргааны харилцан туслалцаа нь нотлох баримт цуглуулахын тулд өөр бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагагүй бөгөөд тухайн тохиолдолд тодорхой нэг улсад хандаж баримт материал авах талаар хүсэлт илгээхэд ашиглаж болдог онцлогтой юм.

1.2 Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хэрэгцээ, тавигдах шаардлага

Аливаа улс орон газар нутгийн зарчмыг үндэслэн өөрийн нутаг дэвсгэрт болсон гэмт хэрэг, маргааныг шийдвэрлэж болох боловч улс орон дамнасан, өөр бусад улсын эрх ашгийг хөндсөн, гадаадын иргэн, хуулийн этгээд оролцсон, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт үүссэн хууль зүйн факттай хэрэг маргааныг дангаар шийдвэрлэхэд багагүй бэрхшээл тулгардаг байна.

Учир нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлт нь зөвхөн

мэдээлэл хүсэхээс илүүтэйгээр эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх зорилготой мөрдөн шалгах тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхэд чиглэгддэгтэй холбоотой юм.

Иймд улс орнууд нэг талаас өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хангах, нөгөө талаас нутаг дэвсгэр дээрээ бусад улсын шүүх эрх мэдлийн эрх ашгийг хангах шаардлагын улмаас эрх зүйн туслалцаа харилцан үзүүлдэг байна.

Энэ нь оролцогч улсуудын хувьд харилцан ашигтай байх, өөрийн эрх ашгийг хангуулахын тулд нөгөө улсын нийтлэг болон иргэний хувийн эрх ашгийг хүндэтгэх зарчим болон тогтжээ.

Эрх зүйн харилцан туслалцааг зарим тохиолдолд шүүхийн харилцан туслалцаа хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нь улс орнууд нөгөө улс оронд буй баримт нотолгоог олж тогтоох замаар эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүсэмжлэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх албан ёсны арга зам юм.

Олон улсын эрх зүйн салбар дахь хамтын ажиллагааны чухал хэлбэр улс гүрний хамтын ажиллагаа бөгөөд гол хэлбэр нь өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, шүүх эрх мэдлийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал байдаг.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх харилцаанд хүсэлт хүргүүлсэн буюу гаргасан улсыг **“хүсэлт гаргагч улс”**, туслалцаа хүссэн хүсэлтийг хүлээн авч буй улсыг **“хүсэлт хүлээн авагч улс”** гэж нэрлэдэг бөгөөд 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 398 дугаар зүйлд гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгүүлэх **“даалгавар”** гэж заасан байсныг өөрчилж, олон улсын практикт хэрэглэдэг **“Mutual legal assistance request”** гэсэн нэр томъёонд нийцүүлэн 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт **“хүсэлт”** гэж өөрчилсөн байна.

Мөн хуулийн 42 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийголон улсын гэрээ, хэлэлцээрт байгууллагаар дамжуулан явуулж болох тухай заасан бөгөөд энэхүү харилцааг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ гэж заажээ.

Авлигын эсрэг конвенцид эрх зүйн туслалцаа үзүүлэх үндсэн шаардлагуудыг дараах байдлаар тодорхойлжээ.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг дараах зорилгоор гаргаж болно.

Үүнд:

- Хувь хүнээс баримт нотолгоо, эсхүл тодруулга гаргуулан авах,
- Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх,
- Нэгжлэг хийх, эд зүйл хураан авах, битүүмжлэх,
- Холбогдох баримт сэлт, мэдээлэл болон шинжээчийн дүгнэлтийг гарган өгөх,
- Хамаарах баталгаажсан баримт бичгийн эх хувийг гарган өгөх,
- Гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгийг шалгаж тогтоох,
- Хүсэлт гаргаж буй улсад тухайн хамаарах хүн сайн дураараа туслахад дэмжлэг үзүүлэх,
- Хүлээн авсан дотоодын хууль тогтоомжийг зөрчөөгүй бусад ямар нэгэн тусламж дэмжлэг,
- Гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгийг битүүмжлэх,
- Эд хөрөнгийг буцаан шилжүүлэх,

Эрх зүйн туслалцааны хүсэлт нь дараах зүйлүүдийг багтаасан байх шаардлагатай байдаг. Үүнд:

Тодорхойлолт.

Хүсэлт гаргаж (дамжуулж буй байгууллага) эрх бүхий байгууллагын мэдээлэл, хүсэлт гаргагч улс дахь мөрдөн шалгах, эсхүл бусад арга хэмжээ авч буй эрх бүхий байгууллага, Үүнд: хүсэлтийг дамжуулж буй газрын холбоо барих хаяг, шаардлагатай тохиолдолд тухайн хэргийг мөрдөн шалгаж байгаа ажилтны мэдээлэл,

Албан ёсны шаардлага.

Баримт бичгийн баталгаажилт, орчуулгын үйлчилгээ, хамаарах улс орнуудын эрх зүйн талаар мэдлэг чадвар бүхий орчуулагч ашиглах шаардлагатай эсэх,

Урьдчилан холбоо тогтоох.

Хүсэлт гаргаж буй болон хүсэлт хүлээн авсан улсын тухайн асуудал хариуцсан ажилтнуудтай урьд нь харилцсан харилцаа, холбооны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл,

Бусад сувгуудыг ашиглах.

Гаргаж буй хүсэлт нь тухайн хүсэлтийн хуулбарыг өөр бусад сувгуудаар давхар илгээсэн эсэхийг дурьдсан байх,

Цаг хугацааг тогтоох.

Тухайн хүсэлтийг хангахад шаардлагатай цаг хугацааг тодорхойлж,

яаралтай эсэхийг дурьдах,

Нууцлал.

Нууцлалыг хангах талаар мэдэгдэх, хэрэв нууцлалыг хангах боломжгүй бол энэ талаар хүсэлт гаргасан улстай урьдчилан зөвлөлдөх,

Хүсэлтийн эрх зүйн үндэслэл.

Тухайн хүсэлтийг гаргаж буй эрх зүйн үндэслэлийг тодорхой бичих, Тухайлбал: гэрээ, олон улсын конвенци, эсхүл хамтын ажиллагааны баримт бичгийн талаар тодорхой тусгах,

Хамаарах баримт бичиг.

Хэрэгт хамаарах баримт материал, шаардлагатай бол тухайн хэрэгт холбогдуулан сэжиглэж буй үндэслэлийг бичих,

Оногдуулах хариуцлагын талаар.

Тухайн гэмт үйлдэлд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээ, хүсэлт гаргасан улсын холбогдох хууль тогтоомжийн зүйл хэсгийг дурьдах,

Шаардлагатай мэдээлэл.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн зорилго, нэмэлт мэдээлэл шаардлагатай эсэх,

Хүсэлтийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага.

Тухайн хүсэлтийн дагуумөрдөн шалгах ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бусад шаардлагатай нэмэлт мэдээлэл нь хэрэгт ямар хамааралтай болох,

Хүсэлтийг биелүүлэхэд баримтлах журам.

Хүсэлт хүлээн авсан улсуудын эрх бүхий төв байгууллагын зүгээс хүсэлтийг биелүүлэхэд удирдлага болгох хууль тогтоомж, шаардлагатай бусад баримт нотолгоог гаргуулан авахад баримтлах тусгайлсан журам, түүний үндэслэлийг тодорхойлох,

Хүсэлтийг биелүүлэхэд хүсэлт гаргасан улсын албаны ажилтан байлцах.

Хүсэлт гаргаж буй улс нь өөрийн ажилтан, эсхүл бусад томилогдсон албан хаагчийг тухайн хүсэлтийг биелүүлэхэд оролцуулах зайлшгүй шаардлага байгаа эсэхийг тодруулах,

Хэлний шаардлага.

Эрх зүйн туслалцаа хүссэн бүх хүсэлтийг тухайн хүлээн авагч улсын хэлэнд орчуулсан баталгаат орчуулга дагалдана.

Эрх туслалцаа харилцан үзүүлэх бичиг баримт бэлтгэх талаар:

Баримт бичиг бэлтгэн ирүүлэх хүсэлтийн хувьд гаргаж буй хүсэлт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Бэлтгэн ирүүлэх баримт бичгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл. Энэ нь мөрдөн шалгах ажиллагаанд чухал ач холбогдолтой эсэх,
- Шаардлагатай баримт бичгийн эх сурвалжийг заах болон, эсхүл тухайн түүнийг эзэмшиж буй хүний талаар,
- Баримт бичгийн хуулбар, эсхүл баталгаажсан хуулбарын алиныг авах, эх бичиг баримт шаардлагатай бол шалтгааныг дурьдах,
- Хэрэв баталгаажсан баримт бичгийн хуулбар байж болох бол ямар байдлаар баталгаажсан байхыг хавсралтад тодорхойлон заасан байх,
- Ямар баримт бичиг болохыг нэрлэн заасан мэдээллийг тодорхой өгөх,
- Хүсэлт хүлээн авагч улс тухайн баримт бичгийг бэлтгэхэд нэмэлт шаардлага бий эсэхийг сайтар шалгах хэрэгтэй.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 43.2 дахь хэсэгт үүнийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: “Тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж 2 тал тогтоосон байх зарчмыг шаардаж буй тохиолдолд, хэрэв туслалцаа үзүүлэхийг хүссэн тухайн гэмт хэргийг бүрдүүлж буй үйлдэл нь ал аль оролцогч улсын хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог бол хүсэлт хүлээн авагч оролцогч улсын хуулиар уг гэмт хэргийг хүсэлт гаргагч оролцогч улсын хуульд заасан адил гэмт хэргийн ангилалд багтаадаг буюу адил нэр томъёогоор нэрлэдэг эсэхээс үлхамааран уг зарчмыг хангаж байна гэж олон улсын хамтын ажиллагаанд үзэхээр заажээ.

Эрх зүйн туслалцаа харилцах үзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч үзэхэд дараах зүйлүүдийг давхар анхаарах хэрэгтэй. Тухайлбал:

-Ирсэн хүсэлтийг нэн даруй эрэмбэлж, хүсэлтийг биелүүлэх эрх бүхий байгууллага, эсхүл бусад албан ёсны механизмыг ашиглан ирсэн хүсэлтийг дамжуулах болон гүйцэтгэх,

-Хүсэлтийг хангах чиглэлээр гарч буй ажиллагаанд мониторинг хийх,

-Эрх зүйн туслалцаа хүсэж ирүүлсэн хүсэлтэд агуулагдсан мэдээллийн нууцлалыг хадгалах.

Түүнчлэн дараах байдлаар тавигдах шаардлагуудыг нэмэгдүүлсэн байна.

Үүнд:

Өндөржүүлсэн шаардлага:

- Ирсэн хүсэлтийг ямар нэгэн саадгүйгээр зохион байгуулалттай үр дүнтэйгээр биелүүлэх,
- Хүсэлтийг биелүүлэх тодорхой үр ашигтай үйл явцыг хэрэгжүүлж цаг тухайд нь гүйцэтгэх,
- Ямар нэгэн тодорхой үндэслэл шалтгаангүйгээр хүсэлтийг хүлээн авахаас татгалзах байдал гаргахгүй байх,
- Эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлэх,

Нэмэлт шаардлага:

- Урьдчилан зөвшөөрөл авах,
- Харилцан мэдээлэл солилцох найдвартай суваг болон механизмыг ашиглан аюулгүй арга замыг хэрэглэх,
- Хүсэлт илгээж буй эрх бүхий байгууллага нь харилцан солилцож буй баримт бичгийн нууцлалыг хангахгүй бол татгалзах зэрэг болно.

Харин эрх зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай нотолгоог гаргаж өгөх шаардлага нь Олон улсын гэрээ конвенци, эсхүл хүлээн авагч орны дотоодын хууль тогтоомжид тусгагдсан байдаг учраас тавигдаж буй шаардлагууд нь ялгаатай байх бөгөөд тэдгээрийн эрх зүйн уламжлал, систем болон хоёр талын гэрээгээр заагдсан тусгай шаардлагуудаас хамаардаг байна.

1.3. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хамтын ажиллагаа

Эрүүгийн хэрэгт гадаад улсаас эрх зүйн туслалцаа хүсэхийн өмнө эрх зүйн туслалцаанаас хүлээж буй үр дүн шаардагдах цаг хугацаа, эрх зүйн туслалцааны зардал, өөрт байгаа нөөц болоомжоо тооцоолон, ямар хэлбэрийн хамтын ажиллагаа нь илүү үр ашигтай болохыг судалж үзсэний үндсэн дээр эрх зүйн туслалцаа хүсэх эсэхийг шийдвэрлэх хэрэгтэй болдог байна.

Ихэнх тохиолдолд мөдөн шалгах ажиллагааны явцад гадаад улсаас эрх зүйн туслалцаа хүсэхээс өмнө хүсэлт хүргүүлэх улсын холбогдох хууль

сахиулах байгууллагатай албан бус байдлаар \урьдчилан\ харилцаа тогтоож нээлттэй эх сурвалжуудыг ашиглах нь үр дүнтэй.

Эрх зүйн туслалцаа хүсэх хүсэлтийг илгээхээс өмнөх хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба, Интерпол, StAR, ARIN, CARIN гэх зэрэг байгууллагаас зохих этгээдийн байгаа газар, хуулийн этгээд, үл хөдлөх хөрөнгө, ял шийтгэлийн тухай зэрэг олон төрлийн мэдээллийг авч болно.

Уг мэдээлэл нь эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд гол ач холбогдолтой нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй боловч эрх зүйн туслалцаа авахаар төлөвлөж буй гадаад улсын хууль тогтоомж, дүрэм, журам болон тодорхой мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгүүлэх онцлог, тэдгээрт шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулан, судлаж мэдэхэд тустай болно.

Хүсэлтийг боловсруулахын өмнө олон төрлийн сувгийг ашиглан гадаадын улс орнуудаас мэдээлэл авах боломжтой ба эдгээр арга хэрэгслүүдийг судалж, шаардлагатай мэдээлэл, материалыг авсаны үндсэн дээр гадаад улсаас эрх зүйн туслалцаа хүсэх шаардлагатай эсэхийг тодорхойлох нь зүйтэй.

Шаардлагатай мэдээллийг дараах сувгуудаар авч болно. Үүнд:

Санхүүгийн мэдээллийн алба

Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албанаас бүх төрлийн санхүүгийн байгууллагуудаар дамжин хийгдэж байгаа 20 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй гүйлгээний утга, оролцогч талууд нь тогтмол, эсхүл тогтмол бус харилцаатай эсэхийг тогтоох болон бусад мэдээллийг авах боломжтой. Мөн тус албанаас Монгол Улсад гүйцэтгэж буй гадаад төлбөр тооцоо, харилцагч нарын дансны хуулга гэх мэт мэдээллийг авч болно.

Сэжигтэй гүйлгээний талаархи мэдээллийг гүйлгээний үнийн дүнгээс үл хамааран шалгуулах боломж байдгийг анхаарах нь зүйтэй. Харилцагчийг таньж мэдэх үүргийнхээ хүрээнд гадаад улсын Санхүүгийн мэдээллийн албад¹ хоорондын харилцааг ашиглан гадаад улсад байгаа хүлээн авагч талын тухай шаардлагатай бүхий л мэдээллийг авах боломжтой.

Монгол улсын хувьд энд дурьдсан санхүүгийн байгууллагуудад үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, үл хөдлөх хөрөнгийн арилжаа эрхлэгч байгууллага, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын байгууллага, нотариат орно.

1 Эгмонт нь санхүүгийн тагнуулын албадын олон улсын сүлжээ юм. Уг байгууллага нь 2013 оны байдлаар өөр өөр улс оронд орших 139 гишүүн санхүүгийн тагнуулын албадтай байна. Гишүүн орнуудын мэдээллийг энэхүү хаягаар авна уу: <http://www.eamontgroup.org/membership/list-of-members>

Монгол Улсын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо:

Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа, түүнд хяналт тавих, үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах, арилжих, бүртгэх, төлбөр, тооцоог гүйцэтгэх, хадгалах, бусад зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой асуудлаар мэдээлэл цуглуулж хуримтлуулдаг. Эдгээр байгууллагуудаас эрх зүйн туслалцаанаас бусад хэлбэрийн хамтын ажиллагааны хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид заасан гадаад улсын хөрөнгийн бирж, үнэт цаас гаргагч нарын талаархи мэдээллийг авах боломжтой.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос Хувьцаат компаний үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайлан, ногдол ашиг хувиарласан шийдвэр, ногдол ашгийн лавлагаа, хувьцаа эзэмшигчдийн талаарх лавлагаа, мэдээлэл, хорооноос гарсан албан бичиг, улсын байцаагчийн албан шаардлага, хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой асуудлаарх журам, компаний дүрэм, санхүүгийн тайлан, Улсын байцаагчийн гэрчилгээ, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо хүчинтэй эсэх, үйл ажиллагаа явуулж байсан эсэх зэрэг мэдээллийг авч болно.

Цагдаагийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа /ИНТЕРПОЛ/

Интерполын² үндэсний төв товчоогоор дамжуулан гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдүүд, гадаад улсад эрэн сурвалжлагдаж байгаа болон саатуулагдсан түүх, соёлын үнэт дурсгалт зүйлс, тээврийн хэрэгслүүд, галт зэвсэг, олон улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж буй гэмт этгээдүүд, хуурамч мөнгөн тэмдэгтүүдийн талаархи мэдээллийг авах боломжтой.

Олон улсын байгууллага

“Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачлага” (СтАР) нь³ Дэлхийн банк болон Нэгдсэн үндэстний байгууллагын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын хамтарсан түншлэл бөгөөд улс орнуудад хулгайлагдсан хөрөнгөө буцаан авах ажиллагаанд арга зүй болон бусад эх сурвалжийн

2 Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага (Интерпол) нь цагдаагийн байгууллага хоорондын хил дамнасан хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг олон улсын хэмжээний цагдаагийн байгууллага юм. Уг байгууллага нь 190 гишүүн оронтой байна. Дэлгэрэнгүй мэдээлэл авахад ашиглана уу. <http://www.interpol.int/Member-countries/World>

3 Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах санаачлагын талаарх бусад мэдээллийг: <http://www.worldbank.org/star>

туслалцаа үзүүлдэг байна.

СТАР нь хөгжиж буй орнууд, санхүүгийн төвүүдтэй хамтран авлига, албан тушаалын гэмт хэргүүд, олон нийтийн буюу улсын хөрөнгийг хувьдаа завших, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөхөд тусламж үзүүлэх, гэм буруутай этгээдүүдийн гадаад орнуудад нуун дарагдуулсан хууль бус аргаар олсон хөрөнгийг хурааж, буцаан авчрах, алдагдсан хөрөнгийг буцаан авахаар ажиллаж буй орны Эрх бүхий байгууллагыг шаардлагатай арга зүйн туслалцаагаар хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж, олон улсын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилладаг байна.

Олон Улсын хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах мэргэжилтнүүдийн сүлжээ

Монгол Улс нь Олон улсын хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах мэргэжилтнүүдийн сүлжээнд⁴ нэгдэн орсон ба энэхүү сүлжээний мэдээлэгчээр Авилгатай тэмцэх газрын (АТГ) Мөрдөн шалгах хэлтэс, Гадаад харилцааны мэргэжилтнүүд ажилладаг. Энэхүү сувгийг авлига болон бусад холбогдох гэмт хэрэгтэй хамаарал бүхий хөрөнгийг мөрдөх, битүүмжлэх, хураах даалгавар, хүсэлттэй холбоотой асуудлаар ашиглаж болно.

Ази-Номхон Далайн Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах сүлжээ /АШМ-АР/

Монгол улс нь уг Ази-Номхон Далайн Хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах сүлжээний⁵ гишүүн орон юм. Энэхүү сүлжээний зорилго нь гишүүн улс орнууддаа гэмт этгээдүүдийн хууль бусаар буюу гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг битүүмжлэх, хураан авах үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоход оршдог.

Мөнгө угаахын эсрэг Ази-Номхон Далайн групп /APG/

Монгол улс нь Мөнгө угаахын эсрэг Ази-Номхон Далайн Группийн гишүүн (APG)⁶ уг групп нь гишүүн улс орнууддаа сэжиг бүхий гүйлгээг тайлагнах, дотоодын системийг бүрдүүлэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хэргийг мөрдөн шалгах чадавхи бүрдүүлэхэд

4 Олон улсын хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах мэргэжилтнүүдийн сүлжээний вэбсайт: <http://www.interpol.int/Crime-areas/Corruption/International-asset-recovery>

5 Албан ёсны вэбсайт, гишүүн орнуудын жарсаалт: <http://www.arin-aD.org/main.do> юм.

6 Мөнгө угаахын эсрэг Ази-Номхон Далайн Группийн вэбсайт: <http://www.apaml.org/about-us/paae.aspx?p=-91ce25ec-db8a-424c-9018-8bd1f6869162>

дэмжлэг үзүүлдэг байна.

Гишүүд нь мөнгө угаах, терроризмын санхүүжилттэй тэмцэх Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/-ийн мөнгө угаахтай тэмцэх, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх тусгай зөвлөмжүүд зэрэг олон улсын хүлээн зөвшөөрсөн нийтлэг стандартыг биелүүлж, сахиулах үүрэг хүлээдэг.⁷ Монгол улс дахь уг сүлжээг Монгол банкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба төлөөлж байна.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хамтын ажиллагааны хүрээнд дараах зүйлүүдийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Эрх зүйн туслалцаа хүссэн албан ёсны хүсэлтийг гаргах шаардлагатай эсэхийг юуны өмнө тодорхойлох. Албан ёсоор хүсэлт гаргалгүйгээр үндсэн зорилгоо хангах өөр бусад альтернатив боломж байгаа эсэх,
- Конвенцид хамаарах хүсэлт дээр хамаарах веб сайтар, эсхүл бусад арга замаар дамжуулан хүсэлт гаргаж болох, хандан гаргаж буй улс нь тухайн конвенцид нэгдэн орсон болохыг баталгаажуулах,
- Эрх бүхий байгууллагаар дамжуулан конвенцийн зүйл заалтуудыг өөрийн улсын хууль тогтоомжинд тусгасан болохыг баталгаажуулах. Өөрийн улс дахь эрх бүхий багууллагаар дамжуулан тухайн хүсэлтээ хандан гаргаж буй улсдаа хийгдэх олон улсын харилцаанд тэргүүн эгнээнд баримтлах бусад хоёр талын, эсхүл олон улсын гэрээ хэлэлцээр байхгүй болохыг тодруулах,
- Хүсэлт гаргаж буй гэмт хэргийн төрөл нь конвенцийн хүрээнд хамрагдаж буй эсэх,
- Хүсэлт хандан илгээхээр бэлтгэж улс орны албан ёсны вебсайт, эсхүл бусад олон улсын вебсайтуудыг ашиглан хүсэлтийг хүлээн авах боломжийг хангах эрх зүйн уламжлал, систем болон улс орнуудын хууль тогтоомжуудийг судлах,
- Хүсэлт хандан илгээж буй улсын эрх бүхий байгууллагатай аль болох эрт харилцаа холбоо тогтоож тухайн гаргахаар бэлтгэж буй хүсэлтэд хамаарах шаардлагатай мэдээллийг олж авсаны дараа тухайн хүсэлтийн талаар уг эрх бүхий байгууллагатай харилцах,
- Хэрэв боломжтой бол хүсэлт хандан гаргаж буй улс орны эрх бүхий байгууллагад өөрийн хүсэлтийг төсөл байдлаар хэлбэрээр илгээн энэ

⁷ ФАТФ-ийн вэбсайт: <http://www.fatf-aafi.org/>; ФАТФ-ийн тусгай зөвлөмжүүд (2003): <http://www.fatf-aafi.org/media/fatf/documents/FATF%20Standards%20-%2040%20Recommendations%20rc>.

нь тухайн улсын шаардлагаад нийцэж буй эсэхийг магадлан шалгах,

- Тухайн улстай үргэжлүүлэн хэлэлцэх замаар гаргах гэж буй хүсэлтээ сайжруулах. Хүсэлт гаргах процессын шатанд шаардагдах хугацаа зардлыг тооцоолох,
- Хүсэлт гаргахаас өмнө хүсэлт хандан гаргаж буй улстай харилцаа холбоотой байж хүсэлт гаргасан болон дараах шатуудад харилцаа холбоогоо үргэлжлүүлэх нь зүйтэй бөгөөд энэ нь энэ чиглэлийн ажлын туршлага хуримтлуулах нөхцлийг бүрдүүлдэг байна.

Мөн Монгол Улсын төрийн байгууллага, яам, тусгай газраас гадаад орны ижил төрлийн байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээрийн хүрээнд холбогдох журмын дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг авах боломжтой байдаг нь бусад хэлбэрийн хамтын ажиллагаанд орно.

Дээрх шугамаар цуглуулсан мэдээ, мэдээлэл нь хэргийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой ч нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх эсэх нь эргэлзээтэй байдгийг анхаарах нь зүйтэй.

Жишээлбэл: Монгол Улсын нутаг дэвсгэрээс олдсон гэх түүх соёлын үнэт зүйл гуравдагч орны нутаг дэвсгэрээр дамжин дөрөвдөгч орны нутаг дэвсгэрт илэрчээ. Дээрх түүх соёлын дурсгалт зүйлийг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн хэрэг гарсан байна.

Дээрх тохиолдолд уг гуравдагч болон дөрөвдөгч улстай байгуулсан Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ байхгүй тохиолдолд дээрх улсуудын гаалийн болон түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудтай Монгол Улсын адил чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран ажиллах тухай ямар нэгэн гэрээ хэлцэл байгуулсан эсэх, Монгол Улс энэ төрлийн олон улсын гэрээнд нэгдэн орсон эсэхийг тогтоож, тийм бол дээрх байгууллагуудын энэхүү эрх зүйн актыг ашиглан гэмт буруутай этгээдүүдийн талаархи мэдээллийг цуглуулах боломжтой.

Монгол Улсын олон улсын гэрээний албан ёсны орчуулга, гэрээний жагсаалт, тэдгээрийн хүчинтэй байх хугацаа, хүчин төгөлдөр болсон хугацаа, Монгол Улсын нэгдэн орсон огноо, албан ёсоор хэвлэн нийтлэгдсэн байдал зэрэг асуудлаар Хүний эрхийн Үндэсний комисс, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газар, Хууль зүйн яамнаас, харин байгууллага хоорондын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн талаар тухайн асуудлыг эрхлэх төрийн захиргааны төв байгууллагуудаас мэдээлэл авах боломжтой.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газар нь Тайландын Вант Улсын Авлигатай тэмцэх комисс, БНХАУ-ын Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний товчоо, БНСУ-ын Авлигын эсрэг хүний эрхийн комисс зэрэг байгууллагуудтай албан ёсны хамтын ажиллагаатай болно.

Тухайн улс хариу өгөхгүй тохиолдолд авах арга хэмжээ

1. Шалгах

- Хоёр орны засгийн газрын зохих сувгаар дамжуулан, тухайн хүсэлт ямар шатанд яваа тухай мэдээлэл хайж хүсэлт тавих,
- Хүсэлт хандан гаргасан улс руу шаардлагатай бол нэмэлт мэдээлэл хүргүүлэх,
- Мөн харилцаа холбооны албан бус сувгуудыг ашиглаж, хариу өгөхгүй байгаа шалтгааныг олж тогтоох. Үүнд: Стар, Интерпол олон улсын эд хөрөнгийг олж тогтоох сүлжээ зэрэг.

2. Бусад орнуудаар шахалт үзүүлэх

Жишээ нь аль нэг улс нь хоёр өөр улсаас тусламж авахаар хичээж буй бол аль нэг улсад нь хандаж нөгөөдөө шахалт үзүүлэх хүсэлтийг гаргаж болно.

3. Харилцан судлах механизмыг ашиглах

- Санхүүгийн үйл ажиллагааны ажлын хэсгийн хүрээнд үнэлгээнд хамрагдаж буй, эсхүл дагаж мөрдөж буй боломжийг ашиглах,
- Эрх зүйн харилцан туслалцааны чанар болон цаг хугацаат байдлын талаарх яриа хэлэлцээр нь НҮБ-ийн авмлын эсрэг конвенци болон Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх конвенцийн хүрээнд байнга яригддаг асуудал юм.

Иймд үнэлгээний механизмын хүрээнд энэ чиглэлээр гарч буй саад бэрхшээлийн талаар мэдээлэл гаргаж өгөх нь тухайн улсын FATF-аас хийж буй үнэлгээгээр олон улсын хамтын ажиллагааны хувьд доогуур рейтингтэй гарахад нөлөөлнө.

4. Гаргаж буй хүсэлт нь үндэслэл сайтай байх

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтэд дурдагдсан зарим мэдээллийг (Жишээ нь эд хөрөнгийн байршил, гэмт хэрэгт хамаарах холбоо гэх мэт) Олон нийтэд нээлттэй баримт бичгүүд болон бусад хууль сахиулах байгууллага, СМА-наас олж үзэж болно. Тухайлбал, аливаа этгээдийн эзэмшилд байгаа газар, үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээд тэдгээртэй холбоотой ихэнх мэдээлэл нь олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр интернет орчинд байршуулсан байдаг.

Мөн бусад төрлийн мэдээллийг олон улсын Санхүүгийн мэдээллийн албад, Цагдаагийн байгууллага хоорондын сүлжээгээр дамжуулан авах боломжтой. Энэхүү сүлжээг ашиглахын давуу тал нь шаардлагатай мэдээллийг харьцангуй хурдан авах боломжтой бөгөөд мэдээлэл авах тухай хүсэлтэд тавигдах шаардлага нь бага байдаг болно.

Хэрэв эдгээр байгууллагууд нь олон улсын сүлжээний гишүүд бол (Жишээ нь интерпол, СМА-ны эгмонтын бүлэг, Стар, Интерпол зэрэг олон улсын эд хөрөнгийг олж тогтоох сүлжээ) хамаарах эдгээр сувгаар харилцан шаардлагатай мэдээлэл олж авч болно.

5. Өөрийн ирүүлсэн хүсэлт дээр холбоо баримт этгээдийн холбогдох хаягийг оруулах

Ирүүлсэн олон тооны хүсэлт нь төрийн олон байгууллагаар дамждаг тул (Жишээ нь: Олон улсын харилцаа, мөрдөн шалгах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд) шийдвэр гаргах этгээд дээр очих хүртэл олон шатыг дамждаг байна.

Тиймээс холбоо барих мэдээлэл тодорхой байх нь цаг алдахгүй, шууд хандан мэдээлэл авах боломжоор хангана.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн биелэгдэх хугацаа нь олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд хүсэлт илгээгдсэнээс баримт нотолгоог хүлээн авах хүртэл олон сар ч шаардагдаж болдог.

Ямар ч тохиолдолд гадаадын мэргэжилтнүүдтэй (жишээ нь Олон улсын хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах мэргэжилтнүүдийн сүлжээг ашиглан) шууд холбоо тогтоон тэднээс хүсэлт хүргүүлсэн улс дахь үйл явцын өнөөгийн байдал, үе шатыг тогтмол лавлах боломжтой. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн хариуг хүлээн авах эсэх нь хүсэлтийн чанар, хэлбэр нь эрх зүйн бүх шаардлагыг хэрхэн, эсхүл хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрийн шаардлага хангах нь хүсэлтийг илгээхээс өмнөх зөвлөгөө авсан байдлаас ихээхэн хамаардаг бөгөөд олон улс орнууд нь албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхээс өмнө албан бусаар даалгаврыг хянаж, зөвлөмж өгөхөд бэлэн байдаг байна.

1.4 Монгол Улсын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд авлигын гэмт хэргийн замаар бий болсон хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь

Шунахайн сэдэлтэй гэмт хэргийг бодит утгаар нь таслан зогсоохын тулд гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгсэл, олсон хөрөнгийг хураан авахтай холбоотой хууль сахиулах ажиллагаанд анхаарах шаардлагатай болохыг улс орнууд хүлээн зөвшөөрсөн билээ.

1988 онд батлагдсан Мансууруулах бодис худалдаалахтай тэмцэх Венийн конвенц зэрэг олон улсын хэрэгсэл мансууруулах бодис худалдаалахтай холбоотой хураан авах ажиллагаанд олон улсын стандарт нэвтрүүлж, хээл хахууль, авлигатай холбоотой шунахайн сэдэлтэй бүх төрлийн гэмт хэрэгт хөрөнгө хураан авах ажиллагаа явуулахыг нэмж тусгасан олон улсын өөр бусад конвенцийн замыг тавьж түүчээлсэн юм.

Өнөөгийн байдлаар НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци болон Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийг хураахтай холбоотой олон улсын арга ажиллагааг маш өргөн хүрээнд тусгаад байна. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 5 дугаар бүлэгт (51-59 дүгээр зүйл) хөрөнгө буцаан олгох арга хэмжээний талаар өгүүлсэн байдаг.⁸

Монгол Улсын хувьд Авлигатай тэмцэх анхны үндэсний хөтөлбөрийг 2002-2010 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн ба Улсын Их Хурлаас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2016 оны 51 дүгээр тогтоолоор, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор тус тус баталсан болно.

Ингэснээр Монгол Улс нь 2017-2023 оныг хүртэл улсын хэмжээнд баримтлах авлигын эсрэг бодлогын баримт бичигтэй болж, өнөөгийн байдлаар үндэсний хөтөлбөрийн 1 дэх үе шат дуусаад байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр бүлгийн 4.1.11 дэх хэсгийн 4.1.11.1-д “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцааны гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлэх, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах” чиглэлийг тус хөтөлбөрийн үндсэн зорилгын нэг болгон тогтоосон байдаг.

⁸ Авлигатай тэмцэх гарын авлага, 2016 он, 252-253 дахь тал

Үүнтэй уялдуулан Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.11.1.(1) “Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэгжүүлэх”, 4.1.11.1.(2) “Гадаад орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулах, өмнө байгуулсан гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх”, 4.1.11.1.(3) “Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх”, 4.1.11.1.(4) “Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт, даалгавар, бусад материалыг орчуулахад шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Мөн арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.11.3.(1) “Гадаад улсын авлигатай тэмцэх, хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх, санамж бичиг байгуулах, харилцан туршлага судлах, солилцох ажлыг зохион байгуулах”, 4.1.11.3.(2) “Гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг судлан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн үзэл баримтлалд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох” арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр заажээ.

Тэгвэл дээр дурдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газраас олон төрлийн ажлыг зохион байгуулсан байна. Тухайлбал, Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын аливаа конвенцийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах, улмаар Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх арга хэмжээний хүрээнд Авлигатай тэмцэх газраас “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа сэдэвт хэлэлцүүлэг”-ийг 2018 оны 4 дүгээр сард зохион байгуулж, холбогдох байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулж, үйл ажиллагааг нь уялдуулах талаар асуудал дэвшүүлсэн ярилцлага өрнүүлэн, санал солилцжээ.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газартай хамтран ажиллаж, авлигын хэрэгт холбоотой эрх зүйн туслалцааны хүсэлтийг нууцын зэрэглэлтэй болон

энгийн байдлаар хүлээн авч, конвенцийн дагуу холбогдох улсын эрх бүхий байгууллагад хүргүүлж байна.

Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газар сүүлийн 3 жилийн байдлаар Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нэгдэн орсон 9 улсад 17 хүсэлт илгээсэн байна. Тухайлбал, 2018 оны байдлаар 4 эрх зүйн туслалцааны хүсэлтийг 7 улс (Англи, Панам, Сингапур, Хонгконг, Австри, Канад, БНХАУ)-д, 2019 оны байдлаар улсын хэмжээнд гадаадын нэр бүхий (Швейцарь, Мэн Арал, ОХУ, БНХАУ, БНСУ, ХБНГУ, Канад, Засаг захиргааны онцгой бүс Хонконг, Франц, Швейцарь, АНУ, Сингапур зэрэг) улсуудад авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг үндэслэл болгосон 26 эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүргүүлжээ. Үүнээс Хонконг, Сингапур, Швейцарь зэрэг улсаас эрх зүйн туслалцааны хүсэлтийн хариу ирсэн байна.

Гадаад улс орнуудтай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээний хүрээнд гадаадын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 168 эрх зүйн туслалцааны хүсэлт, даалгаварт холбогдох ажиллагааг гүйцэтгэсэн ба Монгол Улс, БНХАУ-ын Хууль зүйн яамдын Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, Ялтан шилжүүлэх тухай асуудлаарх II дугаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, уулзалтын протоколд гарын үсэг зуржээ.

Гэмт этгээдүүдийн гадаад улсад гаргаж нуусан авлигын гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг олж тогтоон улмаар буцаан авсанаар гэмт хэрэг үйлдэгсдэд хүчтэй цохилт болдог. Түүнчлэн энэ нь хувийн ашиг сонирхлын үүднээс авлигын гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэн зэхэж байгаа этгээдүүдэд хүчтэй анхааруулга болдог чухал ач холбогдолтой арга хэмжээ юм. Жишээ:

Тунисын Ерөнхийлөгч асан Бен Али 2011 онд албан тушаалаасаа огцорсны дараа Европын холбооны зөвлөл “Тунисын төсвийн хөрөнгийг шамшигдуулж завшсан хэргээр хариуцлага хүлээх” бүх этгээдийн хөрөнгийг битүүмжлэх шийдвэр гаргасан. Гэвч Бен Алигийн хоёр хүргэн болон түүний эхнэрийн үеэл шүүхэд зарга мэдүүлсний дараа Европын холбооны Дээд шүүхээс 2013 оны 5 дугаар сарын 28-нд эл гурван хүнд холбогдох хязгаарлалтыг цуцалжээ. Шүүхийн шийдвэр ёсоор дээрх гурван хүнийг мөнгө угаах үйл ажиллагаатай холбогдуулан Тунисын эрх бүхий байгууллага мөрдөн шалгаж байсан учир ЕХ-ны хар жагсаалтад оруулжээ. Гэхдээ Тунисын хуулиар “төрийн өмчийг хууль бусаар шамшигдуулах”-ыг мөнгө угаах гэмт хэрэг гэж тооцдоггүй болохыг Шүүх олж тогтоосон байна.

Түүнчлэн Тунис дахь мөрдөн байцаалтын ажиллагаа нь хувийн өмч хөрөнгө гэхээс илүүтэй төсвийн хөрөнгө угаасан ажиллагааг олж тогтоогоогүй байна. Бен Алитай холбоотой хувь хүмүүсийг төрийн өмч хөрөнгө хууль бусаар ашигласан гэж үзэх хангалттай үндэслэл байгаагүй тул тэдгээр гурван хүний нэр дээр байдаг хөрөнгийн битүүмжлэлийг цуцлах шийдвэр гаргажээ.⁹

Өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг эргүүлэн авахад нэлээдгүй бэрхшээл тулгардаг бөгөөд хөрөнгө эргүүлэн өгөх олон улсын шинжтэй үйл ажиллагаанд хууль тогтоомжийн ялгаатай байдал, мэргэшсэн техник ур чадвар хангалтгүй байх, эргүүлэн өгөх үйл явцыг удирдан зохион байгуулах улс төрийн хүсэл зориг сул байх, авлигын асуудалд нэрвэгдсэн, улс төр, эдийн засаг, нийгэм нь тогтворгүй байгаа улс оронд хөрөнгө эргүүлэн өгөхтэй холбоотой зовнил түгшүүр зэрэг техникийн болон улс төрийн янз бүрийн саад бэрхшээл тулгарч байна.

Авлига, мөнгө угаах, хөрөнгө буцаан олгох ажиллагаанд хоёр өөр улсын шүүх өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураан авах, эргүүлэн өгөх асуудалд өөр өөр өнцгөөс ханддаг нь ихээхэн бэрхшээл учруулж байгааг улс орнууд анхааралдаа авч энэхүү сорил бэрхшээлийг арилгахад хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагатай байна.¹⁰

Иймд гэмт хэргийн гаралтай хөрөнгө, орлогыг буцаан авах ажиллагааг эрчимжүүлж, бодит үр дүн гаргах чиглэлээр бодлогын түвшинд тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гадаад улсын хууль сахиулах байгууллагуудтай гэмт хэргийн гаралтай хөрөнгө, орлогыг буцаан авах асуудлаар харилцахаас өмнө дотоодын хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог уялдуулан зохицуулах шаардлага зайлшгүй урган гарч байдаг. Тэгвэл энэхүү ач холбогдол бүхий арга хэмжээг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнтэй уялдуулан гаргасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд зохицуулан хэрэгжүүлж байна.

9 Авлигатай тэмцэх гарын авлага, 2016 он, 258 дахь тал

10 Мөн тэнд

ХОЁР.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХЭД ПРОКУРОРЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

2.1 Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн үндэслэл

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцах үзүүлэхэд прокурор, мөрдөгч нар эрх зүйн туслалцаа харилцах үзүүлэх ажиллагааны эрх зүйн үндэслэлийн талаарх тодорхой ойлголттой байх шаардлагатай юм.

Улс орнуудын эдийн засгийн болон хууль эрх зүйн хөгжлийг дагаж гэмт хэрэг үйлдэх арга, хэрэгсэл, нарийсаж, зохион байгуулалтад орохын хирээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн үндэслэл нь зайлшгүй өргөжих, боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.

Иймд прокурор, мөрдөгч нар Монгол Улсын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн үндэслэл болох үндэсний хууль тогтоомж (ЭХХШТХ), Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенци, олон талт болон хоёр талт гэрээ хэлэлцээрүүдийг нэг бүрчлэн, нарийвчлан судлах зайлшгүй хэрэгтэй.

“Олон улсын гэрээ” гэж Монгол улс, Монгол Улсын Их хурал болон Монгол улсын засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ¹¹ хэмээн тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл, олон улсын хоёр болон олон талт гэрээ байгуулах, биелүүлэх, хяналт тавих, цуцлах, хүчин төгөлдөр олон талт гэрээнд нэгдэн орох, гарах, хэлэлцээ хийх зэрэг төслийг тохиролцохоос эхлэн түүнийг ёсчлон гүйцэтгэх хүртэл процессийн бүхий л харилцааг зохицуулна. Гэвч бүх харилцааг хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээрээр зохицуулна гэвэл өрөөсгөл ойлголт болох юм.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д¹² Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заажээ.

11 Олон улсын гэрээний тухай хууль 1993 он УБ хот.

12 Монгол Улсын Үндсэн Хуулийн 10 дугаар зүйл.

Хэдийгээр олон улсын эрх зүй нь дотоодын хууль тогтоомжоос давуу боловч Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээг Монгол Улс дагаж мөрдөхгүй юм.¹³

Иймд зарим гадаад улс орнуудын нийтлэг хандлагыг харгалзан эрх зүйн туслалцааны гэрээг байгуулдаг байна.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ нь дараах хэм хэмжээг агуулдаг байна.

- материаллаг хэмхэмжээ,
- процессын хэмхэмжээ,
- зөрчилдөөний хэм хэмжээ,

Материаллаг хэм хэмжээ нь иргэн, хуулийн этгээдийн эрх мэдэл, эрх, үүргийг тодорхойлдог хэм хэмжээ юм. Тухайлбал, БНМАУ, БНХАУ-ын хооронд “Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай” 1989 оны гэрээний 8 дугаар зүйлд: “Хэлэлцэн тохирогч хоёр Талын төв байгууллага харилцахдаа англи хэлийг хэрэглэнэ. Түүнчлэн хэлэлцэн тохирогч хоёр тал монгол, хятад, англи хэлээр үйлдсэн хэвлэмэл хуудас хэрэглэж болох бөгөөд түүний загварыг харилцан солилцоно” гэж зааснаар гэрээнд оролцогч 2 талд эрх, үүргийг бий болгосон байна.

Процессын хэм хэмжээ нь иргэн, хуулийн этгээдийн эрх мэдэл, эрх, үүргийг хэрэгжүүлэх журмыг тогтоодог бөгөөд тэдний эрхийг шүүхээр хамгаалах журмыг тогтоосон хэм хэмжээ байна.

Жишээ нь: Дээр дурдсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний 28 дугаар зүйлд: “Хэлэлцэн тохиролцогч хоёр Тал энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад бэрхшээл тохиолдвол дипломат шугамаар буюу энэхүү гэрээний 3 дугаар зүйлд заасан төв байгууллагаар дамжуулан харилцаж шийдвэрлэнэ”, “Хэлэлцэн тохирогч хоёр Тал эрүүгийн хэргийн талаар холбогдох этгээдийг шилжүүлэн өгөх, дамжуулан өнгөрүүлэх асуудлыг оролцуулан хоёр Талын эрх зүйн туслалцаа үзүүлэх хэмжээ хязгаарыг өргөжүүлэх болон хоёр Талын эрх бүхий байгууллага эрх зүйн туслалцааны талаархи харилцаанд тус дэмжлэг үзүүлэх асуудлыг дипломат шугамаар зөвлөлдөж болно” гэж тус тус заасан байна.

Зөрчилдөөний хэм хэмжээ нь гэрээ байгуулагч хоёр улсын хооронд үүссэн харилцааг зохицуулах баталгаа болох бөгөөд энэхүү хэм хэмжээ нь өөрөө харилцааг зохицуулдаггүй, зөвхөн хэрхэн зохицуулах зааврыг тогтоож өгсөн байдаг.

¹³ Олон улсын гэрээний тухай Монгол улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар 2011 он УБ хот.

Тухайлбал, дээр дурдсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний 10 дугаар зүйлд:

Даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Даалгаврыг хүлээн авсан байгууллага өөрийн улсын хууль тогтоомжид харшлахгүй бол даалгавар илгээсэн байгууллагын хүсэлтээр тухайн улсын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.

Өөрөөр хэлбэл даалгавар хүлээн авсан тал тухайн харилцааг зохицуулах хууль тогтоомжийг сонгох боломжтой байдаг.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нийтлэг гэрээнд дараах үндсэн асуудлуудыг тусгасан байдаг. Үүнд:

- Гэрээний дагуу харилцах эрх бүхий байгууллагаа хэлэлцэн тохирогч улсууд тодорхойлох. Учир нь зөвхөн гэрээнд тодорхойлсон эрх бүхий байгууллагаараа дамжуулан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт, түүний хэрэгжилтийг хангахыг хэлэлцэн тохирогч улсууд бие биенээсээ шаарддаг.
- Тухайн гэрээний үйлчлэх хүрээ буюу эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлын хүрээг тодорхойлж өгдөг. Үүнд: тухайн гэрээ нь эрүүгийн хэргийн талаар ямар туслалцааг хэрхэн харилцан үзүүлэхийг тодорхойлсоныг ойлгож болно.

Тухайлбал: гэрээний дагуу шаардах бичиг баримт, мөрдөн шалгах ямар ажиллагаа явуулах, ямар ажиллагааг явуулахгүй байх, шүүхийн шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрч биелүүлэх эсэх зэргийг тусгах,

- Эрх зүйн туслалцаа хүссэн хүсэлтийн шаардлагыг тодорхой заахаас гадна эрх зүйн туслалцаа үзүүлсэн тухай хариу мэдэгдэх, эрх зүйн туслалцааг үзүүлэхээс татгалзах үндэслэл, эрх зүйн туслалцааг биелүүлэхтэй холбогдон гарах зардал, хүсэлтийг ямар хэл дээр үйлдэж харилцах зэрэг асуудлуудыг тусгасан байвал зохино.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны үндсэн арга хэрэгсэл нь улс орнуудын илгээж буй хүсэлт юм.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийн эрх зүйн үндэслэл нь хоёр талт, эсхүл олон талт гэрээ хэлэлцээр, гэрээ байхгүй тохиолдолд харилцан туслалцах амлалт /Promise of Reciprocity/ байдаг байна.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтэд заасан ажиллагааг гүйцэтгүүлэх замаар нотлох баримтыг олж авахын тулд хүсэлтийн

“эрх зүйн үндэслэл” хэсэгт тухайн хүсэлтийг илгээх, биелүүлэх үндэслэл болж буй нэг буюу боломжтой тохиолдолд хэд хэдэн эрх зүйн арга хэрэгсэл, үндэслэлийг дурьдах хэрэгтэй.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх эрх зүйн үндэслэл нь гадаад улсад эрх зүйн туслалцаа үзүүлэх үүрэг хүлээлгэдэг ба хамгийн үр дүнтэй нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хоёр талт гэрээ, хэлэлцээр юм.

Хоёр талт эрх зүйн харилцан туслалцааны гэрээ нь хүсэлт гаргаж буй болон хүлээн авч буй улс орнуудын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хуульчилсан гол баримт бичиг бөгөөд эрүүгийн хэргийн талаар баримт, нотолгоо, мэдээлэл авахаар хандах гэж байгаа улс нь Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улстай хоёр талт гэрээ, хэлэлцээр байгуулсан эсэхийгюуны түрүүнд тодруулах шаардлагатай юм.¹⁴

Эрх зүйн харилцан туслалцааны өөр нэгэн найдвартай үндэслэл нь олон улсын олон талт гэрээ хэлэлцээр юм. Тухайн гэрээ, хэлэлцээрээр тогтоосон журмын дагуу, зөвхөн гэрээнд заасан Эрх бүхий байгууллагаар дамжуулан эрх зүйн туслалцаа авах бүхий л ажиллагааг явуулна.

Олон талт эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ нь оролцогч талуудыг харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэхийг шаарддаг онцлогтой юм. Эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхдээ тухайн гэмт хэргийн шинж, хэргийн нөхцөл байдлаас хамааран нэг буюу түүнээс дээш олон улсын конвенци болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн алиныг нь хэрэглэж болох, аль нь илүү үр дүнтэй болохыг анхаарах нь чухал юм.

Өөрөөр хэлбэл, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхийг хүсэхээр төлөвлөж буй улс нь Монгол улсын нэгдэн орсон конвенцийн гишүүн эсэхийг тодруулах хэрэгтэй.

Дээр дурдсанаар хоёр талт, эсхүл олон талт гэрээ хэлэлцээр, гэрээ байхгүй тохиолдолд “харилцан туслалцах амлалт”-ыг улсуудын талаас өгөх боломжтой юм. Тухайлбал, Монгол Улс нь нөгөө улс эрх зүйн хүсэлт тавьсан тохиолдолд ижил төрлийн туслалцаа үзүүлнэ гэсэн баталгаа юм.

Эрх зүйн туслалцааны хүсэлт гаргагч улс нь “Харилцан туслалцах амлалт” өгөх буюу Promise of Reciprocity гэдэг нь хүсэлт хүлээн авагч улсад ижил төрлийн эрх зүйн туслалцаа шаардагдсан тохиолдолд хүсэлт гаргагч улс нь адилхан туслалцаа үзүүлнэ гэсэн амлалт юм.

Өөрөөр хэлбэл, ийм зорилгоор эрх зүйн туслалцааны хүсэлтэнд “Монгол

14 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны гарын авлага 2015 он УБ хот.

улсын засгийн газар нь ижил төрлийн эрх зүйн туслалцааг танай Засгийн газарт харилцан үзүүлэхийг амлаж байна” гэж дурьдахад хангалттай байдаг байна.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг илгээж буй тохиолдолд хүлээн авагч улс нь эрх зүйн нэг үндэслэлийг хүлээн зөвшөөрч, нөгөөгөөс татгалзаж болох боломжтой тул хүсэлтэд байж болох бүх эрх зүйн үндэслэлүүдийг дурьдаж явуулах нь чухал ач холбогдолтой бөгөөд Олон улсын гэрээ, хэлэлцээрт эрх зүйн туслалцаа хүсэхийг эрүүгийн хэрэг үүсгэсний дараа илгээх боломжтой байдгийг анхаарах хэрэгтэй.

Хэрэв гэрээ, хэлэлцээр болон өөр ямар нэгэн эрх зүйн эх сурвалж байхгүй тохиолдолд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлж болох бас нэг арга бол хүсэлтийг дипломат шугамаар гэрээ хэлэлцээрийн бус аргаар тавих явдал юм. Үүнийг “Хүсэлт тавих захидаг” буюу Letter Rogatory гэж нэрлэдэг.

Хэдийгээр энэхүү шугамаар авсан баримт, материал нь дангаараа шүүн таслах ажиллагааны явцад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй байх боловч урьд өмнө хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудыг дэмжих, бататгах болон цаашдын мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Дээр дурьдсан хоёр талт болон олон талт гэрээ хэлэлцээрт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхийг зөвшөөрөх үндэслэлээс гадна туслалцаа үзүүлэхээс татгалзах нөхцлийг тусгадаг байна. Ингэхдээ татгалзах эрх зүйн үндэслэлүүдийг ихэвчлэн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ, хэлэлцээрт заасан байдаг байна.

Гадаад улсын эрх бүхий байгууллага нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ, эсхүл дотоодын хууль тогтоомжид заасан эрүүгийн хэргийн талаарх олон улсын хамтын ажиллагааны хүрээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх шаардлагыг биелүүлээгүйн улмаас хүсэлтийг биелүүлэхээс татгалзах тохиолдол цөөнгүй гардаг байна.

Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах түгээмэл үндэслэлүүд:

Үүнд:

1. Хүсэлт илгээгч тал болон хүлээн авагч талд гэмт хэрэг гэж тогтоогоогүй байх:

Тухайн үйлдлийг гэмт хэрэг гэж хоёр тал тогтоосон байх зарчмыг шаардаж буй тохиолдолд, хэрэв туслалцаа үзүүлэхийг хүссэн тухайн гэмт хэргийг бүрдүүлж буй үйлдэл нь оролцогч улсын хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэгт

тооцогддог бол хүсэлт хүлээн авагч оролцогч улсын хуулиар уг гэмт хэргийг хүсэлт гаргагч оролцогч улсын хуульд заасан гэмт хэргийн адил ангилалд багтаадаг буюу адил нэр томъёогоор нэрлэдэг эсэхээс үл хамааран энэ зарчмыг хангаж байна гэж олон улсын хамтын ажиллагаанд үзнэ¹⁵.

Гэмт хэргийн үйлдэл нь хоёр улсад адилхан гэмт хэргийн зүйлчлэлтэй байх шаардлагагүй. Энэ нь хүсэлт илгээж буй улсад гэмт хэрэгт тооцогдох үйлдэл байх шаардлагатай. Иймээс эрх зүйн туслалцааны хүсэлтэд гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүний хийсэн үйлдлийг нарийвчлан дурьдах хэрэгтэй байдаг¹⁶.

2. Хүсэлт нь *de minimis* шинжтэй байх:

Туслалцаа үзүүлэх хүсэлт нь *de minimis* шинжтэй асуудалтай холбоотой тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. Үүнд бусдын эд хөрөнгийг бага хэмжээгээр хулгайлах, ашиглах, завших, үрэгдүүлэх зэрэг орж болно.¹⁷

3. Хэлмэгдүүлэлтийн шинжтэй байх:

Мөрдөн шалгагдаж буй хэрэг нь тухайн хүний хүйс, арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, яс үндэс, гарал үүсэл буюу улс төрийн итгэл үнэмшлийнх нь улмаас яллах буюу шийтгэх зорилготой байна гэж үзсэн, эсхүл тухайн хүсэлтийг биелүүлбэл тухайн хүний байдалд эдгээр шалтгааны аль нэгний улмаас хохирол учирна гэж үзэх баттай үндэслэл байгаа бол.¹⁸ Ижил гэмт хэрэгтэй холбоотой яллан шийтгэгдэх /нэг гэмт хэрэгт хоёр удаа ял шийтгэх/ (*double jeopardy/ne bis in idem*):

Зарим улсад хэрэв эрх зүйн туслалцаа авахыг хүссэн эрүүгийн хэрэгт хэргийн холбогдогч нь хүсэлт хүлээн авагч улсад ижил гэмт хэрэгт шалгагдаж байгаа, эсхүл ял шийтгэгдсэн, цагаатгасан шийдвэр гарсан тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах боломжтой байдаг байна. Үүнийг нэг гэмт хэрэгт хоёр удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрсдэл¹⁹/*double jeopardy/* буюу *ne bis in idem* гэж нэрлэдэг байна.

4. Үндэсний ашиг сонирхолд харшлах:

Хэрэв, хүсэлт хүлээн авагч оролцогч улс хүсэлтийг гүйцэтгэснээр түүний бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, *ordre public*, бусад чухал ашиг сонирхлыг

15 Авилгын эсрэг НҮБ-ын конвенцийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

16 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны гарын авлага 2015 он УБ хот.

17 Авилгын эсрэг НҮБ-ын конвенцийн 46 дугаар зүйлийн 9-ийн ь хэсэг.

18 Авилгын эсрэг НҮБ-ын конвенцийн 44 дүгээр зүйлийн 15 дахь хэсэг.

19 Хууль зүйн Англи-Монгол эх толь, С.Нарангэрэл, 2012 он, Монгол Улс

хөндөх магадлалтай гэж үзэж байгаабол

5.Хүсэлтэд заасан үйл ажиллагаа нь хүсэлт хүлээн авагч улсын дотоодын хууль журамтай нийцэхгүй байх:

Хүсэлтэд заасан гадаад улсын нутаг дэвсгэрт хийгдэх ажиллагааг гүйцэтгэхийг хүсэлт хүлээн авагч улсын хууль тогтоомжоор хориглосон бол уг ажиллагааг хийж гүйцэтгэх, даалгаврыг биелүүлэх боломжгүй болно.

Дээр дурьдаагүй боловч олон тооны хүмүүсээс мэдүүлэг авах, олон хуудас тайлан боловсруулах гэх зэрэг их хэмжээний цаг хугацааны болон хүн хүчний нөөц шаардагдах хүсэлтийг гадаад улсын Эрх бүхий байгууллага хүлээж авахгүй байх магадлал өндөр болдог байна.

Иймд хүсэлтийн үндэслэл буюу түүний зайлшгүй хэрэгцээт байдлыг сайтар боловсруулсан байх нь түүнийг нааштайгаар шийдвэрлэгдэхэд ихээхэн нөлөөлдөг болохыг анхаарах нь зүйтэй.

2.2 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр прокурорын гүйцэтгэх үүрэг

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд тавих хяналтыг чанар, үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд эрх зүйн орчныг цаашид боловсронгуй болгох, мөн шүүх эрх мэдлийн, хууль сахиулах байгууллагын болон гадаад харилцаа, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хооронд харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллах явдал чухал ач холбогдолтой юм.

Эрх зүйн чиглэлээр харилцан туслалцаа үзүүлэх, хамтын ажиллагааны асуудлаар хууль тогтоогч, шийдвэр гаргагч, иргэд олон нийт, хууль сахиулагчид бодитой, үнэн зөв ойлголттой болох шаардлагатай юм.

Ялангуяа мөрдөн шалгах үйл ажиллагааны чиглэлээр сүүлийн үед илрүүлж байгаа гэмт хэргүүдийн арга барил, хэв шинж, оролцооны байдлыг авч үзэхэд нилээд өндөр зохион байгуулалттай, хаалттай, нууцлагдмал хэлбэртэй болж байна.

Улс орон бүр өөрийн улсад гарсан гэмт хэргийг хуулийн байгууллагуудын хүч нөөц, чадавхиар бүрэн дүүрэн илрүүлэх боломжтой байдаг хэдий ч хилийн гадна үйлдэгдсэн болон тэр тусмаа эрх зүйн харилцан туслалцааны гэрээгүй улс орнуудад гарч байгаа гэмт хэргүүдийг илрүүлж, нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэн шүүхээр шийдвэрлүүлэх нь хамгийн бэрхшээлтэй асуудал болж байна.

Дээр дурдсанаар эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг олон улсын конвенци, хоёрт талт болон олон талт гэрээ, хэлэлцээрт тодорхойлсон төв байгууллагаар дамжуулан илгээдэг зохицуулалттай. “Төв байгууллага” буюу “Эрх бүхий байгууллага” нь тухайн гэрээ, хэлэлцээрийг байгуулсан улсуудад хамааран харилцан адилгүй байдаг. ***Ихэнх тохиолдолд Хууль зүйн яам, эсхүл Улсын Ерөнхий прокурорын газарт уг үүргийг хүлээлгэсэн байдаг.***

Прокурорын байгууллагын ажиллах эрх зүйн орчин нь Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газар хороонд байгуулсан хоёр талт гэрээ, Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээгээр зохицуулагддаг.

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 26.1 дүгээр зүйлд “Монгол Улсын Ерөнхий прокурорын газар нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх төв байгууллага болох тул эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх олон улсын гэрээгүй тохиолдолд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг Улсын Ерөнхий прокурорын газарт хүргүүлнэ” гэж хуульчилжээ.

Хэрэв олон улсын гэрээтэй тохиолдолд тухайн хоёр талт болон олон талт олон улсын гэрээнд төв байгууллага байхаар заасан Монгол Улсын холбогдох байгууллагад хүсэлтийг илгээнэ гэсэн зохицуулалттай байна.

Прокурорын байгууллага нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Прокурорын байгууллагын гадаад харилцааг хөгжүүлэх, Монгол Улсын нэгдэн орсон олон талт ба хоёр талт олон улсын гэрээ, гадаад улсын прокурорын байгууллагуудтай байгуулсан гэрээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хариуцан зохион байгуулах, тогтоол биелүүлэх зорилгоор хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх, хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх, Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах ажиллагаатай холбогдсон ажлыг олон улсын гэрээ, хуульд заасан журмын дагуу зохион байгуулж ажиллана.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт нь Монгол Улсын нэгдэн орсон олон талт ба хоёр талт олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх хууль, тэдгээрийн хүрээнд Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан заавар, журмын дагуу явагддаг билээ.

2017 онд шинээр батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуульд Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаатай холбоотой зарчмын хэд хэдэн заалт шинээр орсон. Тухайлбал,

- “Reciprocity” гэрээгүй оронтой эрх зүйн туслалцааны асуудлаар харилцах олон улсын эрх зүйн зарчим;
- Прокурорын байгууллага нь Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хариуцан зохион байгуулах төв байгууллагабайх зохицуулалтуудыг шинээр тусгаж өгсөн байна.

Прокурорын байгууллагын гадаад улсын адил төрлийн байгууллагатай байгуулсан хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээрийн хувьд прокурорын байгууллага нь Засгийн газар хоорондын гэрээ, хэлцлээр нарийвчилсан зохицуулалт хийх эрх олгогдсон заалтыг үндэслэн гадаадын адил төрлийн байгууллагатай тодорхой асуудлаар хамтран ажиллах санамж бичиг, гэрээ, хэлэлцээр байгуулж ажилладаг.

Энэ тохиолдолд олон улсын гэрээнд үндэслэн зохих журмын дагуу байгуулсан Монгол улсын прокурорын байгууллага, гадаад орны прокурорын байгууллага хоорондын гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааны санамж бичигт тулгуурлан цуглуулсан мэдээ сэлт нь шүүхийн шатанд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх боломжтой бөгөөд бусад тохиолдолд уг гэрээ, хэлэлцээрийг зөвхөн мэдээлэл солилцох зорилгоор ашигладаг байна.

Улсын Ерөнхий прокурорын газар нь эрх бүхий буюу төв байгууллагын хувьд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг гэрээ, хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэх, гадаад улсын эрх бүхий төв байгууллагад хүргүүлэх, биелэлтийг хангуулах ажиллагааг зохион байгуулах үүргийнхээ хүрээнд эрүүгийн хэрэгт мөрдөгчийн үйлдсэн эрх зүйн туслалцааны хүсэлт нь олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан эрх зүйн үндэслэл болон тухайн улсын үндэсний хууль тогтоомжоор тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянана.

Прокурор нь тогтоосон шаардлагыг хангасан үндэслэл бүхий хүсэлт үйлдэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт²⁰ заасан болон Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 8дугаар сарын

20 Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он УБ хот

22-ны өдрийн А/96 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”-ын 20 дугаар бүлэг буюу «Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа»-ны хэсгийг баримтлавал зохино²¹.

Хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээд, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөхтэй холбогдсон аливаа ажиллагааг Улсын ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хариуцан зохион байгуулна.

Өмнө дурьдсанчлан эрх бүхий буюу төв байгууллага нь мөрдөгч, прокурорын гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах талаархи хүсэлтийг утга агуулга, хэлбэрийн хувьд олон улсын гэрээ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, хүлээн авагч улсын тухайн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн²² үйлдсэн эсэхийг хянана. Үүнд:

1. Хүсэлтийг олон улсын гэрээ, хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан байдал;

-эрх зүйн туслалцаа авах шаардлага, эрүүгийн хэргийн мөрдөх ажиллагаанд хүсч байгаа туслалцааны хамааралтай байдал,

-шаардлагатай нотлох баримт, мэдээлэл, бичиг баримтыг хавсарган хүргүүлсэн байдал,

2. Хүсэлтийг хууль, гэрээний шаардлага хангасан гэж үзвэл хүсэлт, түүнд хавсарган хүргүүлж буй баримт бичгийг олон улсын гэрээнд заасан хэлээр, эсхүл хүсэлтийг илгээж байгаа улсын хэл, эсхүл англи хэл дээр орчуулахыг мөрдөгчид даалгана.

3. Прокурор хүсэлтийг хянаж үзээд шаардлага хангагдсан гэж үзвэл түүнийг гадаад улсын холбогдох байгууллагад уламжлуулахаар Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст хүргүүлнэ.

4. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүсэлтийг хүлээн авч, олон улсын гэрээ, хууль, энэ зааврын шаардлагыг хангасан тохиолдолд хүсэлтийг гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авна.

21 Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан зааврын 20.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 2017 он УБ хот

22 Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан зааврын 20.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2017 он, УБ хот

Хүсэлт нь шаардлага хангаагүй тохиолдолд нэмж хийх ажиллагааг тодорхой дурьдаж, хүсэлтийг тухайн прокурорын газарт буцаан хүргүүлнэ.

5. Улсын Ерөнхий прокурорын газар нь Монгол Улсаас гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлсэн хүсэлтийн биелэлтийг хангуулах талаар Хууль зүй, Дотоод Хэргийн Яам болон Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнчлэн тухайн гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газартай харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллана.

6. Шаардлагатай тохиолдолд хүсэлт хүргүүлэхтэй холбогдуулан гадаад улсын байгууллага, албан тушаалтантай харилцан мэдээлэл солилцоно.

7. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь гадаад улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан хүсэлтийн хариуг цахим бүртгэлд тусгаж, харьяа прокурорын газарт хүргүүлнэ. Мөрдөгч нь прокурорын байгууллагаар дамжигдан ирээгүй хүсэлтийн хариуг шууд хүлээн авсан, эсхүл мөрдөн шалгах тодорхой ажиллагаа хийгдэлгүй гадаад улсаас буцаасан хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд энэ тухай хяналт тавьж буй прокурорын газарт шуурхай мэдэгдэж, цахим бүртгэлд тусгуулна.

8. Гадаад улсын нутаг дэвсгэрт хийгдэх мөрдөн шалгах тодорхой ажиллагаанд мөрдөгч зайлшгүй оролцох шаардлагатай тохиолдолд энэ тухай хүсэлтийг Улсын ерөнхий прокурорын газраар дамжуулж урьдчилан хүргүүлэх ба тухайн гадаад улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр байлцаж болно.

9. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол улсын хил орчмын нутаг дэвсгэрийг харьяалах прокурорын газар нь мэдээ, мэдээлэл харилцан солилцох зорилгоор Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр гадаад улсын ижил мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж болно²³.

Мөрдөгчийн үйлдэж буй гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах талаархи эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт нь утга агуулга, хэлбэрийн хувьд олон улсын гэрээ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, хүлээн авагч улсын тухайн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байхаас гадна дараах нөхцөлийг хангасан эсэхийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Урьд өмнө нь Монгол Улсаас тухайн гадаад улсын төв байгууллагад хүргүүлсэн хүсэлттэй агуулгын хувьд давхардаагүй, зөрчилдөхгүй байгаад хяналт тавина.

²³ Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан зааврын 20.3 дугаар зүйл, 2017 он, УБ хот.

2. Монгол Улсын баримталж буй гадаад бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай зөрчилдөхгүй байгаа эсэхийг хянавал зохино.

Дээр дурьдсан арга хэмжээ нь Монгол Улсад хэрэг бүртгэх, мөрдөн байцаах Эрх бүхий байгууллагууд нэг утга, агуулга бүхий асуудлаар өөр өөр хоёрдмол байр суурийг илэрхийлсэн хүсэлт, нэг хүнд холбогдуулан харилцан адилгүй, эсрэг агуулгатай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах тухай хүсэлт илгээх, урьд өмнө гүйцэтгүүлсэн ажиллагаа, авсан мэдээллийг дахин давхардуулан авч цаг хугацаа алдахаас урьдчилан сэргийлэх зорилготой болно.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд хяналт тавих үүргийг гүйцэтгэхэд Улсын Ерөнхий прокурорын газрын эрх, үүрэг нь мөрдөгчийн үйлдсэн хүсэлтийг үр дүнтэй, цаг хугацаа хэмнэх, богино хугацаанд биелэгдэх боломжийг нэмэгдүүлэх явдал юм.

Учир нь эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн хариуг ирүүлдэггүй хамгийн түгээмэл шалтгаан бол хүсэлтийг зохих хэлбэрийн дагуу үйлдээгүй байдаг явдал юм.

Прокурорын байгууллага нь эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр олон талын дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Тухайлбал:

1. Гадаад улсын ижил төстэй байгууллагатай шууд харилцах, тэдгээр байгууллага болон олон улсын байгууллагатай чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах санамж бичиг, хэлэлцээрийн төслийг бэлтгэх, байгуулах ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах, хамтран ажиллах;

2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох бусад ажлыг хариуцан зохион байгуулах;

3. Эрх зүйн туслалцааны чиглэлээр гаргасан Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан аргачилсан заавар, журмыг хэрэгжүүлэх;

4. Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, хөрөнгө, орлого хураан авах, шилжүүлэх, буцаан олгох болон мөрдөн шалгах бусад тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай эрх зүйн туслалцааны хүсэлтийг гадаад улсын эрх бүхий байгууллагад уламжлах, гүйцэтгэлийг шаардах, хариуг авч хүсэлт тавьсан зохих байгууллагад хүргүүлэх.

5. Гадаад улсын эрх бүхий байгууллагаас Монгол Улсын нутаг дэвсгэрт тодорхой ажиллагаа хийлгэхээр ирүүлсэн эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг хүлээн авах, эрх бүхий байгууллагад

гүйцэтгүүлэхээр даалгах, гүйцэтгэлд нь хяналт тавих, гүйцэтгэлийг уламжлан хүргүүлэх;

6. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын иргэд эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж, баривчлагдсан, албадан саатуулагдсан, шүүхээр шийтгүүлсэн, осол, гэмт хэргийн улмаас амь нас нь хохирсон иргэдийн талаар болон шаардлагатай бусад эрүүгийн хэргийн талаарх асуудлаар холбогдох улсын Элчин сайдын яамтай харилцах;

7. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлаар Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, гадаад улсын холбогдох байгууллагатай зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллах;

8. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах, илгээхтэй холбоотой асуудлын талаар сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

9. Эрх зүйн туслалцааны хүсэлттэй холбогдсон мэдээллийн сантай байх, бусад хуулийн байгууллагатай холбогдох мэдээллийг харилцан солилцох;

10. Тогтоол биелүүлэх зорилгоор хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх, хорих ял шийтгүүлсэн хүнийг харъяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх, Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах асуудлаарх аргачилсан заавар, журмын хэрэгжилтийг хангах;

11. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдээд гадаад улсад гарсан Монгол Улсын иргэнийг гадаад улсад эрэн сурвалжлах, шилжүүлэн авах болон гадаад Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын харъяат иргэнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийг хүлээн авч хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу шийдвэрлэх;

12. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх ажиллагааг Улсын Ерөнхий прокурорын зөвшөөрлийн үндсэн дээр удирдан зохион байгуулах;

13. Гадаад улсад хорих ял эдэлж байгаа Монгол Улсын харъяат иргэн, эсхүл Монгол Улсад хорих ял эдэлж байгаа гадаад улсын харъяат иргэнээс эх орондоо ялаа үргэлжлүүлэн эдлэх талаар гаргасан хүсэлтийг хүлээн авч, холбогдох гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийн дагуу хянаж, хууль болон олон улсын гэрээнд заасан журмын дагуу шийдвэрлэх зэрэг үүрэг оролцоотой ажилладаг байна²⁴.

24 Улсын Ерөнхий прокурорын А/26 дугаар тушаал, 2018 он, УБ хот .

ГУРАВ.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛУУД

3.1 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам

Мөнгө угаах, авлига, албан тушаал зэрэг эдийн засгийн гэмт хэргүүд даяарчлагдаж эдгээр нь тухайн орондоо үйлдэгдэхээс гадна зохион байгуулалттай, хил дамнансан, бусад улсын байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй холбогдох нь нэмэгдсээр байгаатай холбоотой энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, нотлоход ганц улсын хууль, хуулийн байгууллагын хүчин чармайлт хангалтгүй болж байна.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд практик дээр олон талын бэрхшээлүүд учирдаг байна. Өөрөөр хэлбэл дан ганц дотоодын хууль тогтоомж, олон улсын конвенцид нэгдэн орох, хоёр талт болон олон талт гэрээ хэлэлцээр байгуулснаар бүхий л асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэх боломжгүй юм.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааны хүрээнд хүрэх үр дүнд олон талын нөхцөл байдал, эрх зүйн үндэслэлүүд ихээхэн нөлөөлдөг байна.

Тухайлбал улс хоорондын гадаад харилцаа, барьж буй бодлого, салбар хороондын хамтын ажиллагаа, үндэсний хууль тогтоомжийн ялгаатай байдал, хууль болон гэрээ, хэлэлцээрт заасан эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах шаардлага гэх зэрэг олон нөхцөл байдлаас хамааран эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааны үр дүн шалтгаалдаг байна.

Юуны түрүүнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй улс орнуудын тухайд мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг хүсэхэд бэрхшээлтэй нөхцөл байдал үүсдэг байна.

Иймд тухайн улсууд гадаад улсад тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг тухайн бүс нутагт байрлах улсуудтай байгуулах, олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох асуудалнь чухал ач холбогдолтой юм.

Ингэснээр тухайн улсад гүйцэтгүүлэх мөрдөн шалгах тодорхой ажиллагааг саадгүй явуулах нөхцөл бүрдүүлэх боломжтой байдаг байна.

Тухайлбал олон талт олон улсын гэрээ, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенци

болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын / Палермогийн/ Конвенци түүний нэмэлт 3 протоколыг дурдаж болох юм.

Энэхүү хоёр конвенцид Монгол Улс нэгдэн орсон. Конвенцид заасны дагуу гишүүн орнууд авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар өөрсдийн холбогдох байгууллагаараа дамжуулан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх салбарт хамтран ажиллах боломжтой болжээ.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын / Палермогийн/ конвенцид хуулийн этгээдийн хүлээх хариуцлага, албадлагын арга хэмжээ авах, хэрэг хянан шийдвэрлэх эрх, гэмт этгээдийг шилжүүлэх, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, хамтарсан мөрдөн байцаалт явуулах аргууд, гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа, техникийн туслалцаа үзүүлэх зэрэг асуудлыг тусгагдсан байна.

Гадаад улсын нутаг дэвсгэрт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-д заасан мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах “хүсэлт” боловсруулахад шинэхэн томилогдсон мөрдөгч, прокурор төдийгүй олон жилийн ажлын туршлага хуримтлуулсан мэргэжилтнүүдэд хүртэл багагүй бэрхшээл тулгарч байна.

Учир нь хүсэлт хүлээн авагч гадаад улс орон бүр өөрийн гэсэн онцлог бүхий эрх зүйн тогтолцоотой тул хүсэлтийг боловсруулахдаа тухайн улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг мөрдлөг болгохоос гадна Монгол Улс болон тухайн улс хооронд тогтсон дипломат харилцааг хүндэтгэн үзэж, хоёр орны найрсаг харилцаа ихээхэн ач холбогдолтой болохыг анхаарах хэрэгтэй.

Дээрх асуудалд анхааралтай хандсанаар тухайн улстай харилцах дипломат харилцаанд сэв суух, хүндрэл учрахаас урьдчилан сэргийлэх, улмаар мөрдөгчийн илгээж буй эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа авах хүсэлтийг тухайн гадаад улсын эрх бүхий төв байгууллагаар нааштай шийдвэрлүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлдэг байна.

Гадаад улсын эрх бүхий төв байгууллагатай хамтран ажиллахдаа эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдэд заасан шаардлагыг нэг бүрчлэн хангаж ажиллах нь нэн чухал бөгөөд эрүүгийн хэргийг шүүхэд хянан хэлэлцэх шатанд Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан

үзүүлэх ажиллагааны хүрээнд цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг хэрхэн олж авсанаас хамаарч нотлох баримтыг үнэлэх, цаашид гэмт этгээдийн хууль бус үйлдлийг хөдлөшгүй нотолж, хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх ач холбогдолтой юм.

Түүнчлэн улс орнуудын эрүүгийн хууль тогтоомж, эрх зүйн системийн ялгаатай байдлаас шалтгаалан багагүй бэрхшээл хүдрэлүүд үүсдэг байна. Тухайлбал эрх зүйн үг хэллэг, томъёолол, (жишээ нь батлан даалт, эсхүл шүүхэд хүргүүлэх affidavit or writ of habeas corpus) хууль зүйн ойлголтын зөрүүний улмаас өөр өөр эрх зүйн системтэй хуульчдад өөрөөр ойлгогдож болно.

Жишээ нь: commission rogatory буюу “хүсэлт бүхий захидал”, эсхүл “бичгэн мэдэгдэл” зэрэг үгсийг хоорондоо ялгаатай эрх системтэй улс орнуудад өөрийн улсын хууль тогтоомжид заасны дагуу ойлгогдохоор байна.

Мөн эрх зүйн өөр системтэй орнуудын хууль тогтоомжоор тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулахад цагдаа, прокурор, шүүгч, бусад оролцогчдын эдлэх эрх, үүргийн хувиарлалт нь өөр байх тул эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтэд дурдсан ажиллагааг гүйцэтгэх боломжгүй тохиолдол гарч болно.

Иймд улс орнууд үйл ажиллагааны хамтын ажиллагааг нэмэгдүүлж, эрх бүхий байгууллагуудад мөрдөн шалгах ажиллагааны талаар мэдээлэл солилцох, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ач холбогдлоор нь эрэмблэх болон мөрдөн байцаалтын нөөц бололцоог зүй зохистой хуваарилах явдал чухал юм.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлыг хариуцсан төв байгууллагатай шууд холбоо тогтоож, хандах байдлаар тодорхой асуудлыг шийдвэрлэх боломжтой байдаг.

Эрх бүхий буюу төв байгууллага нь эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт нэг бүрийг /гадаад улсаас болон гадаад улсад илгээж байгаа хүсэлт/ хүлээн авч, холбогдох байгууллагад уламжлах, шилжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий байгууллага, газар, тэдгээр байгууллагын харилцан итгэлцэл дээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүрээний хамтын ажиллагаа сайжирдаг байна.

Тус байгууллага нь эрх зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд олон улсын харилцаанд идэвхитэй үүрэг гүйцэтгэж, өөрийн бий болгосон найрсаг харилцаа, мэдээлэл солилцох сүлжээ, интерпол болон цагдаагийн хамтын ажиллагааны олон улсын харилцааг идэвхитэй дэмжигч байдаг байна.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд тухан шалгаж буй гэмт хэрэг нь нөгөө улсын хуулиар гэмт хэрэгт тооцогдож байх ёстойг анхаарах хэрэгтэй. Иймд эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүсэхдээ шалгуулах гэж байгаа үйлдэл нь тухайн улсын хууль тогтоомжид гэмт хэрэгт тооцогддог эсэхийг урьдчилан судалсан байвал зохино.

Түүнчлэн эрх зүйн туслалцааны хүсэлтийн зүйл нь хүсэлт хүлээн авагч талын туслалцаа үзүүлэх цар хүрээнээс хэтрэхээс сэргийлэх шаардалгыг анхаарах хэрэгтэй байдаг. Хүсэлтийг илгээж буй тал хүсэлт хүлээн авах талтай урьдчилан холбогдож, эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийн талаар санал солилцох, боломжтой бол албан бусаар зөвлөгөө хүсч болох бөгөөд энэ тохиолдолд нууцад хамаарах мэдээ, материал эсэхэд анхаарлаа хандуулна.

Мэдээллийн нууц задруулах болон мэдээллийг хэт эрт задруулах явдал нь цаашид авах арга хэмжээнд саад учруулах эрсдлийг үүсгэж болох тул түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд холбогдох улсууд өөр хоорондоо өөрсдийн хууль тогтоомжоор нууцад хамаарах мэдээлэл, түүний задруулах журмын дагуу, мөрдөн байцаалтын төлөвлөгөөнд саад учруулахгүйгээр үр дүнтэй харилцах нь чухал юм.

Тиймээс хүсэлтэд дурдсан мэдээллийг тухайн этгээдэд болон гуравдагч этгээдэд задруулж болох хэмжээ хязгаар зэрэг асуудлын талаар харилцан тохиролцсон байвал зохино.

Олон улсын хамтын ажиллагааны шаардлагуудын талаар болон хүсэлт хүлээн авсан талын хүчин чадал, нөөц бололцоо, эрх зүйн туслалцааны хүсэлтэд тусгагдсан олон төрлийн туслалцааг үзүүлэхэд шаардагдах хугацааны талаар харилцан ойлголтыг өгч тохиролцох нь ихээхэн ач холбогдолтой байдаг. Учир нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг гүйцэтгэхээр тусгасан хугацаанд хийх боломжгүй, удаашрах, хугацаа алдах явдал олон улсын практикт нилээдгүй гардаг байна.

Иймд хэсэлт гаргаж байгаа болон хүлээн авч буй улс эрх зүйн туслалцааны хүсэлтэд дурдсан ажиллагааг гүйцэтгэх хугацааны талаар харилцан тохиролцож, санхүүгийн болон хууль сахиулагчийн гүйцэтгэх ажиллагааны шугамаар авах мэдээлэлд хэрхэн нөөлөөлж болзошгүй талаар ойлголт авсан байх хэрэгтэй байдаг байна. Хүсэлт гаргасан тухайн улсууд нь тухайн хүсэлтийн биелэлтийг хангуулах талаар байнга анхаарлаа хандуулж, цаашид хэрхэх талаар идэвхитэй ажиллах нь үр дүнтэй юм.

3.2 Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт боловсруулахад анхаарах асуудлууд

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт нь тухайн улсын дотоодын хуульд заасан процесс болон олон улсын хамтын ажиллагаатай шууд холбоотой байдаг тул түүнийг илгээж байгаа болон хүсэлтийг хүлээн авч байгаа талуудын хувьд тавигдах хууль зүйн шаардлагыг харилцан ойлголцсон байх нь чухал юм.

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийн төслийг олон талын асуудлуудыг урьдчилан судалсаны үндсэн дээр боловсруулна.

Юуны түрүүнд эрх зүйн туслалцааны хүсэлт илгээгч болон хүлээн авагч талуудын хооронд эрх зүйн туслалцааны хүсэлтийг төсөл хэлбэрээр солилцож гэрээ, хэлэлцээр, конвенци, дотоодын хууль тогтоомжид заасан бүхий л шаардлагуудыг хангагдсан эсэхийг шалгана.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх ажиллагаа нь хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч талын аль алины дотоодын хууль тогтоомжид нийцсэн байна.

Олон улсын конвенциудад ихэнхдээ эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах стандарт шаардлагуудыг заасан байдаг²⁵бол тодорхой процесс болон хууль зүйн элементууд нь улс орнуудын хувьд харилцан адилгүй байдаг байна.

Мөн эрх зүйн туслалцааны хүсэлтийн хэл, агуулга, хэлбэр, мөн нотолгооны стандартууд улс бүрт ялгаатай.

Нэг оронд гарсан гэмт хэрэг өөр оронд гэмт хэрэгт тооцогддоггүй нь хүндрэл бэрхшээл үүсгэж байдаг учраас харилцан гэмт хэрэгт тооцсон байх шаардлага нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх гол нөхцөл болдог.

Харилцаж буй талууд эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөл боловсруулахдаа дээрх мэдээллээс гадна шаардлагатай тохиолдолд тусгайлсан мэдээллийн талаар ойлголттой байх хэрэгтэй.

Харилцаж буй талууд хоорондоо эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнө холбоо тогтоож нөгөө талын стандарт болон тохиромжтой шаардлагыг шалгаж, тодорхой түвшинд харилцан итгэлцэл болон ойлголцол бий болгож,

²⁵ Авилгын эсрэг НҮБ-ын конвенцийн 46 дугаар зүйлийн 15 дугаар хэсэг, Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ийн конвенцийн 18 дугаар зүйлийн 14 болон 15, Мансууруулах эм, сэтгэгдэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн 7 дугаар зүйлийн 9 болон 10-т ЭЗТ-нй хүсэлтэнд тавих шаардлагыг заасан

эрх зүйн туслалцааны процессын үр дүнг бүхэлд нь нэмэгдүүлэхэд чухал юм.

Урьдчилж холбоо тогтоосноор авах арга хэмжээг хамгийн сайн тодорхойлдог ба тодорхой хэргүүд дээр эрх зүйн туслалцааны хүсэлтийг албан ёсны сувгаар хэрэгжүүлэхээс өмнө төслийг талаар хоорондоо санал солилцох хэрэгтэй юм.

Ингэснээр илүү сайн стратегийг боловсруулах бололцоог олгох бөгөөд хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлт илгээгч талд эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд гарч болох хүндрэл болон бэрхшээлийн талаар сэрэмжлүүлж болох ба тодорхой ажиллагаа гүйцэтгэхэд илүү сайн туслалцаа үзүүлэх ач холбогдолтой байдаг.

Мөн урьдчилж холбоо тогтоосон нь хүсэлт хүлээн авагч талд хүсэлт илгээгч талын эрүүгийн хэрэгт явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагааны онцлог байдлыг мэдэрч, ойлгох бололцоог олгохоос гадна тухайн хүсэлтийн ач холбогдол болон яаралтай эсэх, албан ёсоор хүргүүлэхээс өмнө урьдчилж хүсэлтийг хянуулах хугацаа байгаа эсэх зэргийг тодорхойлох давуу талтай юм.

Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны онцлог байдлыг тодорхойлоход, тухайн хэргийн ноцтой байдал, мөрдөн шалгах ажиллагааны үе шат болон нийтийн ашиг сонирхлыг анхаарах шаарддлагатай.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг хүсэлт хүлээн авагч тал урьдчилж хянаснаар цаг хугацаа болон нөөц бололцоог хэмжиж, хүсэлт илгээгч талд эрх зүйн туслалцааны хүсэлтийг эрүүгийн хэргийг үргэлжлүүлэн шалгахад үр дүнтэй стратегийн хэрэгсэл болгон ашиглах боломж, бололцоог бий болгодог байна. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг хүсэлт хүлээн авагч тал шалгах шаардлагагүй тохиолдолд, хүсэлт илгээгч талын төв байгууллага нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг хянадаг байна.

Хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч талууд нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн гүйцэтгэлийг яаралтай хангуулахын тулд дотооддоо гарч байгаа процессын ахиц, үр дүнгийн талаар зөвлөлдөж байнгын хяналт тавьж үр дүнтэй ажиллахаас гадна хүсэлт илгээгч болон хүлээн авач талууд нь бүхий л үе шатанд тогтмол холбоотой байснаар хүсэлтийг гүйцэтгэх хугацааны талаар бодитой ойлголт авах, ажиллагааны явцад саад үүсэхээс урьдчилан сэргийлэх боломжийг олгодог байна.

Түүнчлэн талуудын хоорондын үргэлжилсэн харилцаа холбоо нь хүсэлтийг хэрэгжүүлэхэд дараагийн үйл ажиллагааг урьдчилж төлөвлөх бололцоог олгодог сайн талтай юм.

Хүсэлт хүлээн авагч тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөлд дүгнэлт

хийж, хүсэлт илгээгч талд бичгэн хэлбэрээр санал, дүгнэлт хүргүүлэх, эсхүл эрх зүйн туслалцааны хүсэлтэд дурдсан ажиллагааг хийхэд шаардлагатай нэмэлт мэдээлэл яагаад шаардагдаж байгааг хариу мэдээлэх нь хүсэлтийг үр дүнтэй гүйцэтгэх ажиллагаанд ихээхэн ач холбогдолтой.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтэд туслалцаа авах гэж байгаа асуулын бүхий л холбоотой мэдээллийг багтаах шаардлагатай. Үүнд:

Хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч эрх бүхий байгууллага, хүсэлтийн зорилго, хуулийн зүйл заалт (шийтгэлийн дээд хэмжээг бичих), хүсч байгаа туслалцааны төрөл, нууцлалын асуудлууд, яаралтай гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд түүний шалтгаан зэрэг мэдээллүүд багтана.

Эрх зүйн туслалцааны хүсэлт илгээгч тал нь хүсэлтийн төсөлд дараах зүйлсийг тусгасан байвал зохино. Үүнд:

1. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн эрх зүйн үндэслэл,
2. Хүсэлт илгээж буй эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал, холбоо барих мэдээлэл, холбогдож болох хэл,
3. Хүсэлтийг биелүүлэхтэй холбоотой хуулийн заалт зөвлөмж,
4. Тухайн мөрдөн шалгах ажиллагаанд байгаа гэмт хэргийн талаарх хуулийн заалт, хэсэг,
5. Хэрэгт холбогдуулан шалгаж байгаа хүмүүсийн нэр болон хувийн байдал,
6. Хэргийн факт, үйл баримтууд,
7. Хүсч буй туслалцаа,
8. Дагаж мөрдөх процесс зэрэг мэдээ, мэдээллүүд багтана.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны талаар хуульчилсан ба 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт **“Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийн агуулга”**-д дараах зүйлсийг тусгахаар зааж өгсөн байна. Үүнд:

1.Мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах тухай хүсэлтийг бичгээр үйлдэж, түүнд дараахь зүйлийг тусгана:

- 1.1.Хүсэлт гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг;
- 1.2.Хүсэлт хүлээн авах байгууллагын нэр, хаяг;
- 1.3.Хүсэлтийн утга;
- 1.4.Хэргийн агуулга, мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон нөхцөл

байдал, эрх зүйн туслалцаа авах зорилго;

1.5. Эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэслэл;

1.6. Хүсэлтэд заасан хүний иргэний харьяалал, эрхэлдэг ажил, оршин суугаа газрын, эсхүл байрлаж байгаа газрын талаархи мэдээлэл, хуулийн этгээдийн хувьд түүний нэр, хаяг;

1.7. Эд мөрийн ба бусад нотлох баримт;

1.8. Зүйлчлэлийн тухай мэдээлэл, шаардлагатай бол учирсан хохирлын хэмжээ;

1.9. Тухайн улсын нутаг дэвсгэрт хийгдэх мөрдөн шалгах тодорхой ажиллагаа.

2. Хүсэлтэд хавсаргаж байгаа баримт бичиг, нотлох баримтыг хүлээн авах улсын албан ёсны хэлээр орчуулж, холбогдох албан тушаалтан гарын үсэг зурж, шаардлагатай бол тэмдэг дарна²⁶

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг боловсруулж хүргүүлэхэд анхаарвал зохих асуудлыг дэлгэрүүлэн авч үзэхэд дараах зүйлсийг сайтар судалсан байх хэрэгтэй.

Тухайлбал, Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт боловсруулахдаа хүсэлтэд дурдсан ажиллагааг гүйцэтгэсний үр дүнд олж авсан мэдээлэл, нотлох баримтыг зөвхөн тухай хэргийг хуулийн хүрээнд тал бүрээс нь, бүрэн дүүрэн хянан шийдвэрлэхэд ашиглах бөгөөд мэдээлэл өгсөн талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулахгүй тухай баталгаа өгөх ойлголт байдаг.

Үүнийг **“rule of specialty”** гэх бөгөөд энэхүү журмыг хангахад “Монгол улсын засгийн газар нь энэхүү хүсэлтийн хүрээнд хүлээн авсан аливаа мэдээллийг зөвхөн уг хүсэлтийн дагуу ашиглах болно” гэж дурьдах шаардлагатай юм.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцааны хүсэлт нь үндсэндээ загвар /хэлбэр/ болон агуулга гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх ба хамгийн чухал хэсэг нь **агуулга** юм.

Нэгдүгээрт: Хүсэлтэд тухайн улсын эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэгдсэн байх магадлалтайг ойлгомжтой, өгүүлэмж хэлбэрээр баримт нотолгоотой бичих шаардлагатай.

Хоёрдугаарт: хүсэлтэд дурьдсан баримт нотолгоо нь хүсэлтийн агуулгатай шалтгаант холбоотой байх.

Гуравдугаарт: шаардлагатай нотлох баримт, гэмт хэргийн холбогдолтой

26 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, УБ хот

асуудал нь хүсэлт хүлээн авагч оронд явуулах шаардлагатай болохыг тодорхой бичих хэрэгтэй юм.

Хэрэв хүсэлт боловсруулахдаа хангалттай үндэслэл, баримт нотолгоо, зохих мэдээллийг дурдахгүй бол хүсэлт хүлээн авагч улс нь илгээсэн хүсэлтийг тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг хүссэн бус, мэдээлэл цуглуулах гэсэн ерөнхий (fishingexpedition) зорилготой гэж үзэн биелүүлэхээс татгалзах магадлалтай болохыг анхаарах нь зүйтэй.

Эрх зүйн туслалцааны хүсэлт нь ихэнх тохиолдолд тухайн улсын албан ёсны хэл дээр, эсхүл хүсэлт хүлээн авч буй улсын хүлээн зөвшөөрсөн өөр хэл дээр орчуулж хүргүүлдэг. Хүсэлтийг боловсруулахдаа хууль зүйн үндэслэл бүхий тодорхой, энгийн ойлгомжтой өгүүлбэрүүдийг сонгож бичих нь тохиромжтой байдаг байна.

Түүнчлэн хүсэлтэд хэрэглэх хуулийн үг хэллэгийг боломжит хэмжээгээр хүсэлт хүлээн авагч талд ойлгожтой байдлаар хэрэглэх нь зохимжтой байдаг. Учир нь улс орнуудын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалт нь өөр өөр байдаг тул хуулийн үг хэллэгийг орчуулахад ойлголтын зөрүү үүсэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай юм.

Тухайлбал, эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлт илгээгч талын хууль тогтоомж, эрх зүйн системийн талаар ойлголт дутмаг байх боломжтой учир хэргийн утга болон ямар туслалцаа хэрэгтэй байгааг аль болох энгийн үг хэллэгээр тайлбарлах нь чухал байдаг байна.

Түүнчлэн эрх зүйн үндэслэл, хүсэлтийн ач холбогдлоор нь эрэмлэн жагсаан бичих нь чухал юм. Хэрэв эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтэд хэтэрхий их зүйл тусгасан тохиолдолд хүсэлт хүлээн авагч улсын нөөц бололцоо хязгаарлагдмал байх боломжтой тул хүсэлтийн хэрэгжилт төдийлөн ач холбогдлоо өгч чадахгүй байх магадлалтай юм.

Иймд хүсэлт гаргагч тал нь хүсэлт хүлээн авагч талтай эрх зүйн туслалцааны хүсэлтийг нэн тэргүүнд тавих чухал шалтгаануудын талаар шууд холбоо тогтоон хэлэлцэж, гүйцэтгүүлэхэд анхаарах шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, хүсэлт гаргагч тал нь тухайн эрх зүйн туслалцааны хүсэлтийг гэмт хэргийн хөнгөн, хүнд, хохирлын хэмжээ, мөрдөн шалгах ажиллагааны үе шат, нийтийн ашиг сонирхлыг хамарсан түвшин зэрэг нөхцөл байдалд тулгуурлан ач холбогдлоор нь эрэмбэлж, тэргүүн ээлжинд шийдвэрлүүлэх асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Зарим тохиолдолд олон ажиллагаа бүхий эрх зүйн туслалцааны хүсэлтийг

хэсэг хэсгээр нь шат дараалалтай гаргах нь илүү үр дүнтэй байдаг байна.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийн эрх зүйн үндэслэлд хоёр талын эрх зүйн харилцан туслалцааны гэрээ хэлэлцээр байгаа тохиолдолд тухайлбал “Монгол Улс болон тухайн улс хооронд байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”, түүний үндэслэл болгож буй зүйл, заалтыг тодорхой зааж өгнө. Хүсэлт үйлдсэн, мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэж байгаа газар болон хүсэлтийг хүлээн авч буй байгууллагын нэр, хаяг, холбоо барих мэдээлэл, эрх бүхий төв байгууллага, тэдгээр байгууллагад холбогдох эрхийг олгож байгаа хуулийг тус тус тодорхой дурьдана.

Энгийн үг хэллэгийг ашиглан, мөрдөн шалгагдаж байгаа тухайн гэмт хэрэг, түүний зүйлчлэл, түүнд хүлээлгэх хариуцлага, ял шийтгэлийг тайлбарлаж, хохирлын хэмжээ нь тогтоогдсон тохиолдолд учирсан хохирлын хэмжээг тодорхой дурьдаж холбогдох хуулийн зүйл, хэсгийг иш татаж бичих нь зохимжтой.

Хэрэв төдийлөн ойлгомжтой биш тохиолдолд уг хэрэг асуудал нь тухайн улсад ямар үндэслэлээр харьяалалтай байгааг тайлбарлах хэрэгтэй. Тухайлбал: хэргийн холбогдогч нь Монгол Улсын иргэн биш, гэмт үйлдэл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдээгүй тохиолдолд тухайн гэмт хэргийн мөрдөн байцаалтын харьяалалыг тайлбарлах хэрэгтэй болдог байна.

Тухайн хэрэгт мөрдөн шалгагдаж байгаа хүний хувийн мэдээллийг тодорхой дурдахаас гадна тухайн эрүүгийн хэрэгт хэн нэг этгээдэд сэжигтэн, яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан эсэх тухай мэдээллийг давхар тусгасан байх нь чухал байдаг.

Түүнчлэн хүсэлтэд хэргийн мөрдөн шалгах ажиллагааны оролцогч болох шаардлагатай гэрч, хохирогчийн хувийн мэдээллийг тодорхой дурдаж өгөх нь хүсэлтийн гүйцэтгэлийн хугацаа, үр дүнд ач холбогдолтой юм. Ингэхдээ гэрч, хохирогчоос ямар мэдээлэл авах талаар, асуух асуултыг жагсааж өгөх нь зүйтэй юм.

Тодорхой хугацаанд үргэлжилсэн үйл явдлын талаарх тайлан тооцоо, баримт материал авах хүсэлт тавьсан тохиолдолд хамрах хугацааг хязгаарлаж өгөхөд анхаарах шаардлагатай байдаг. Учир нь хүсэлт хүлээн авагч тал нь ямар хугацааны асуудлыг шалгахаа тодорхойлох шаардлага бий болдог тул хугацаа тодорхойгүй илгээсэн заалтыг гүйцэтгэх боломжгүйд хүрэх юм.

Эрх зүйн туслалцааны хүрээнд эд хөрөнгийг түр хураах, битүүмжлэх хүсэлт

гаргаж байгаа тохиолдолд холбогдох гэрээний шаардлагуудыг маш тодорхой бичих ёстойг анхаарах шаардлагатай.

Ихэнх хэргийн хувьд тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн объект, хэрэгсэл, эсхүл гэмт хэргээс олсон орлогын аль нь болохыг зааж өгч, гадаад улсад байгаа тухайн эд хөрөнгийг эрүүгийн хууль зөрчсөн гэж үзэж байгаа гэмт хэрэгтэй холбоотой болох үндэслэлээ тодорхой дурдах шаардлагатай юм.

Гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээд нь гадаад улсад эд хөрөнгөтэй бөгөөд уг эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлахыг хүсэх нь энэ тохиолдолд хангалтгүй.

Эрх бүхий төв байгууллага нь хүсэлтийн төсөлд агуулга, хэлбэрийн хувьд өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд хүсэлтийг боловсруулсан газар, албан тушаалтанд тодорхой заавар, зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд хамтран эцэслэн боловсруулж ажилладаг байна.

Улмаар эрх зүйн туслалцааны хүсэлтийн эцсийн хувилбарыг гадаадын эрх бүхий төв байгууллагад илгээнэ. Хэрэв их хэмжээний өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд эрх бүхий төв байгууллага нь төслийг дахин хянахыг хүсээд буцаана.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг хянаж, зохих шаардлагыг хангасан гэж үзвэл эрх бүхий төв байгууллага нь гадаад улсын эрх бүхий байгууллагад Монгол хэл дээрх хүсэлтийг холбогдох хэл дээрх орчуулгын хамт илгээхээр зохицуулсан байдаг байна.

ДӨРӨВ: ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ОЛСОН ОРЛОГО, ЭД ХӨРӨНГИЙГ ШАЛГАЖ ТОГТООХ, БИТҮҮМЖЛЭХ, БУЦААН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ

4.1. Урьдчилсан дүн шинжилгээ

Эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа эхлэхийн өмнө улс орнууд аливаа гэмт үйлдлийн шинжийг бүхийл шаардлагатай эх сурвалж (санхүүгийн, мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажлынмэдээ баримт, нээлттэй эх сурвалж болон холбогдох Санхүүгийн мэдээллийналбадтай мэдээлэл солилцож)-ийг ашиглан хувь хүн, түүний хамаарал бүхий этгээдүүдийн талаар шаардлагатай мэдээлэл, тэдгээрийн санхүүгийн боломж, уялдаа холбоо зэрэг дотооддооболомжтой байгаа мэдээллийг шуурхай олж авч, урьдчилсан дүн шинжилгээг хийж байх нь чухал юм.

Мөрдөн шалгах ажиллагаагаар тухайн гэмт хэргийн шинжийг илрүүлж болох бүхий лшаардлагатай арга хэмжээг авч дотоодын болон гадаад улсын санхүүгийн мэдээллийн албадтай гэмт хэргийн талаарх мэдээллийг түргэн шуурхай солилцох явдлыг хангах зорилгоор аливаа мэдээлэл, санхүүгийн шинжилгээ хийсэн дүгнэлт зэргийг нэгтгэн дүгнэсэн байх ёстой.

Хөрөнгийг үрэгдүүлэхээс сэргийлэх зорилгоор гадаад улсын эрх бүхий байгууллагатай мэдээлэл, санхүүгийн шинжилгээ хийсэн дүгнэлтийг урьдчилан, шуурхай байдлаар боломжтой тохиолдолд санхүүгийн мэдээллийн алба /СМА/-ны шугамыг ашиглаж солилцохыг анхаарах хэрэгтэй.

Алхам -1. Гэмт хэргийн талаарх мэдээллийг олж авах

Гэмт хэргийн талаарх мэдээллийн эх сурвалж ньсэжигтэйгүйлгээний мэдээлэл, шүгэл үлээгч, гэрч, мэдээлэгч, хохирогч нарын мэдүүлэг, сонин хэвлэлийн мэдээ, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт, эсхүл гадаадын хууль сахиулах байгууллагын хүсэлт зэрэг болно.

Албан ёсны мөрдөн байцаалтын ажиллагаа эхлүүлэх болон стратеги төлөвлөгөө боловсруулах, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэххүсэлтийг гаргахаас өмнө хүсэлт гаргаж буй улс гэмт хэрэгт холбогдсон хүн, тэдгээрийн хамааралбүхий этгээдийн талаарх шаардлагатай баримт, сэлт, мэдээллийг дотооддоо цуглуулсан байвалзохино.

Тухайлбал: Хууль сахиулах байгууллага боломжтой бол санхүүгийн мөрдөн

шалгах ажиллагаа тухайлбал санхүүгийн мэдээллийн албанаас сэжигтэй гүйлгээний мэдээлэл, мөнгөн гүйлгээний мэдээлэл болон бусад мэдээ, мэдээллийг авч шинжилгээ хийх боломжтой. Санхүүгийн мэдээллийн алба нь бусад улсын Санхүүгийн мэдээллийн албанаас санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг Эгмонт сүлжээ болон харилцан ойлголцлын санамж бичгийн үндсэн дээр бусад улсаас хүсэх боломжтой.

Мөн бүртгэлийн мэдээллийн сан (үл хөдлөх хөрөнгө, авто машин, хөлөг онгоц, нисэх онгоцны өмчлөл, бүртгэлийн мэдээлэл), гааль, татвар, хуулийн этгээд, эрүүгийн болон иргэний хянан шийдвэрлэх ажиллагааны, иргэний бүртгэл мэдээлэл, харъяат, харилцаа холбоо болон хэрэглээний зардлын бүртгэл зэрэг нэмэлт мэдээллийг авч үзэж болно.

Төрийн аудитын болон зохицуулагч агентлагууд (тухайлбал, Аудитын газар, Авлигтай тэмцэх газар), эсхүл төрийн албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн асуудлыг эрхлэн хариуцаж байгаа байгууллагуудаас мэдээллийн эх сурвалжийг авах боломжтой.

Түүнчлэн худалдааны мэдээллийн сан (тухайлбал, зээлийн мэдээллийн сан гэх мэт), эсхүл нээлттэй эх сурвалж (олон нийтэд нээлттэй эх сурвалжаас авсан мэдээлэл), мэдээ, мэдээлэл, интөрнет орчинд тавьсан мэдээлэл, блог, шуудан, төрийн эрх бүхий байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас гаргасан судалгаа, тайлан, олон нийтийн сүлжээний хэрэгсэл зэргээс мэдээлэл авч болно.

Интернетээс олж авсан мэдээлэл өөрчлөгдөж, эсхүл устгагдах магадлалтай тул ирээдүйд нотлох баримтад тооцох зорилгоор электрон мэдээллийг бэхжүүлэх арга хэмжээг авсан байвал зохино.

Дээрхээс гадна мэдээлэгч (шүгэл үлээгч), олон нийтийн мэдээллийн утас, олон нийтэд нээлттэй бусад сувгуудаар дамжуулан мэдээллийг олж авч болно.

Алхам-2. Мөрдөн шалгах ажиллагааг явуулбал зохих байгууллага

Мэдээллийг бүхэл нь, эсхүл хэсэгчлэн шалгах болон түүнийг шалгах хамгийн тохиромжтой этгээдийг тодорхойлох шаардлагатай. Гэмт хэргийн талаарх мэдээлэл, бусад үйл ажиллагааг бүхэлд нь болон хэсэгчлэн явуулах талаар түүнийг явуулах илүү тохиромжтой этгээдийг судлаж үзэх шаардлагатай.

Харилцаж буй улсууд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлтэй аль улс, ямар эрх бүхий байгууллага холбоотой шийдвэрлэхийн тулд авах арга хэмжээг хянаж үзсэн байна. Тухайлбал: хөрөнгө байршиж буй улстай харилцах, хамтран ажиллах нь туйлын ач холбогдолтой.

Апхам-3. Мэдээллийг үнэлэх

Үнэлгээний шалгуурт мөрдөн байцаалтыг амжилттай явуулахад шаардлагатай харъяалах улс, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, суурь гэмт хэргийг тодорхойлох, найдвартай байдал, нотлох баримт цуглуулах эх сурвалжийг багтааж болно.

Урьдчилсан дүн шинжилгээний хүрээнд хийсэн сэжиг, таамаглал болон гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд үндэслэж дотоодын хууль тогтоомжийн дагуу байж болох гэмт хэргүүдийг тодорхойж, бусад улсын хуульд (хэрвээ мэдэгдэж байгаа) дээрх гэмт хэргүүд хэрхэн туссан, хөрөнгийг буцаан авах боломжтой арга замууд (шийтгэх тогтоолоор болон ял оногдуулахгүйгээр хөрөнгө хураах, иргэний, гадаад улсын хянан шийдвэрлэх ажиллагаа гэх мэт) нөхцөл байдлыг нэн даруй авч үзэх ёстой.

Апхам-4. Анхдагч мэдээллийг цуглуулж, бэхжүүлэх

Гэмт хэрэгт холбогдсон хүн, тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой шаардлагатай бүх мэдээлэл болон хөрөнгийг боломжит эх сурвалжийг ашиглаж, зохион байгуулалттайгаар цуглуулж, бэхжүүлэх шаардлагатай.

Дотооддоо олох боломжтой мэдээлэлд улсын бүртгэлийн мэдээллүүд, хөрөнгө орлогын мэдүүлэг, санхүүгийн тайлан, болон тухайн этгээдийн амьдралын хэв маяг ч ордог. Нээлттэй эх сурвалжид захиргааны бүртгэлийн мэдээлэл (дотоод болон гадаад), хэвлэл мэдээлэл, худалдааны болон олон нийтийн сүлжээний хэрэгсэлүүдийг хамааруулж болно.

Харилцаж буй улс орнууд нь шаардлагатай мэдээллийг түргэн шуурхай олж авах бололцоо үүсгэхийн тулд хуулийн этгээдийн, газрын болон төрийн бус байгууллагын бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгох асуудлыг авч үзэх нь зүйтэй.

Боломжтой бол эдгээр бүртгэлийг цахим хэлбэрээр төвлөрүүлж, нэмэлт өөрчлөлтийг цаг тухайд нь оруулж, шинэчилж байх нь үр дүнтэй байдаг.

Харилцаж буй улсууд нэг нэгэндээ мэдээлэлд нэвтрэх эрх үүсгэх, мэдээллийг шинэчилж байх асуудлыг техникийн туслалцааны шугамаар ч шийдвэрлэх боломжтой (жишээ нь, интернетийн хурдыг нэмэгдүүлэхэд чиглэсэн техникийн туслалцаа г.м.).

Анхдагч мэдээллийг олон улсын болон бүс нутгийн хэмжээний хамтын ажиллагаатай байгууллага, олон улсын сүлжээ байгууллагуудын тусламжтайгаар олж авах боломжтой юм.

Алхам-5. Хувь хүний болон тухайн хүний санхүүгийн холбоотой хүмүүсийн талаарх мэдээллийг бэлтгэх

Хувь хүний тухайд иргэний бүртгэлийн мэдээлэл, ажлын түүх, гэр бүлийн байдал, хамаарал бүхий этгээдүүд болон санхүүгийн мэдээллүүд багтана. Хуулийн этгээдийн хувьд үндэстэн дамнасан корпорацийн бүтэц, өмчлөл, олон улсын харилцаа, хамаарал (гадаад улсууд дахь салбар, төлөөлөгчийн газар, удирдлага, харилцах данс, үйл ажиллагаа гэх мэт) зэрэг мэдээллийг холбогдох улсаас авах, туслалцаа, мэдээллийн боломжит эх үүсвэрийг олж тогтоосны үндсэн дээр олж авах шаардлагатай.

Энэхүү мэдээлэлд үндэслэн мөрдөн шалгах ажиллагааны субъект болон тэдгээрийн санхүүгийн байдлыг тогтоох боломж бүрдэнэ. Холбогдох улсуудад гаргаж өгөх анхдагч мэдээллийг бэлтгэхдээ нууцад хамаарах мэдээлэл бий эсэхийг анхаарч үзвэл зохино.

Аль болох тодорхой мэдээллээр хангах нь мэдээлэл давхардуулж цаг алдахаас сэргийлж, үүний оронд мөрдөн шалгах ажиллагааны бусад чиглэлийг тодорхойлоход дөхөм болно.

Тухайлбал: Нөгөө улсад гаргаж өгч байгаа мэдээллийн төрсөн огноо, паспортын мэдээлэл, албан тушаалын талаар, харилцаа холбоо зэргээр 2000-2004 онд эрчим хүчнийсайдаар ажиллаж байсан, хуучин Ерөнхийлөгч Х-гийн эхнэр, боловсролын сайдын хүү... гэх мэтийг нэг бүрчлэн, тодорхой зааж өгөхөд анхаарал хандуулах нь зүйтэй.

Алхам-6. Дотоодод авах арга хэмжээ

Ээдрээ, төвөгтэй хэрэгт анхдагч мэдээллийг цуглуулах шатнаас эхэлж дотооддоо уялдаа холбоотой ажиллах шаардлага үүсч болзошгүй бөгөөд ингэхдээ нууцлалын шаардлагыг харгалзан үзэх хэрэгтэй.

Нууцлалыг хангах шаардлага тухайлбал, сэжиглэж буй этгээдэд задруулахаас урьдчилан сэргийлэхэд ээдрээ, төвөгтэй хэргийн тухайд анхдагч мэдээллийг цуглуулах явцад цуглуулах уеэс дотооддоо арга хэмжээ авч ажиллах шаардлагатай. Ингэснээр мөрдөн байцаалт цаашид амжилттай явагдаж, мэдээлэл алдахаас сэргийлнэ

Албан болон албан бус баг, ажлын хэсгийг байгуулах, санхүүгийн мэдээллийн алба /СМА/ болон санхүүгийн шинжээч нараас мөрдөн шалгах ажиллагааны туршид оролцох замаар дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авч болно. Санхүүгийн мэдээллийн алба нь дүн шинжилгээ хийх бүх үе шатад нээлттэй эх сурвалж бүхий мэдээллийг судлах хэрэгтэй.

Алхам- 7. Гэмт хэргийг тодорхойлох

Тухайн үйлдэл, эс үйлдэл нь дотоодын болон гадаадын (хэрэв мэдэгдэж байгаа бол) хууль тогтоомжийн дагуу ямар гэмт хэрэгт тооцогдож болохыг тодорхойлж, хөрөнгө буцаан авч болох арга замуудыг тодорхойлсон байна.

Гэмт үйлдлийг үнэлж, дүгнэх нь нэн чухал хүчин зүйл юм. Учир нь хүсэлт хүлээн авагч улсын хуулийн шаардлагад нийцээгүй бол нөгөө улсын хүсэлтийг гүйцэтгэх боломжгүй юм

Алхам-8. Холбогдох улстай мэдээлэл солилцох

Санхүүгийн мэдээллийн алба (Эгмонтын суваг), хууль сахиулах байгууллага хоорондын хөрөнгийн буцаан авах сүлжээ болон хоёр талт гэрээний үндсэн дээр мэдээллийг холбогдох улстай хуваалцана.

Шаардлагатай тохиолдолд Санхүүгийн мэдээллийн алба бусад холбогдох улсын санхүүгийн мэдээллийн албатай Эгмонтийн сүлжээ гэх мэт сувгийг ашиглан санхүүгийн мэдээллийг хуваалцаж болно. Эгмонтын сүлжээнд нэгдээгүй улсын хувьд бүс нутгийн сүлжээг ашиглах боломжтой бөгөөд харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэж авч болно.

Харилцаж буй улсууд шаадлагатай мэдээллээр харилцан цаг тухайд бие биенээ хангах бөгөөд хүлээн авагч улс мөрдөн байцаалт явуулахад тухайн мэдээллийг ашиглаж, эргэх холбоог сайтар хэрэгжүүлэх нь зүйтэй. Холбогдох улсуудад тухайн асуудал нь гэмт хэрэгт тооцогдохгүй бол хүсэлтийг гүйцэтгэхгүй, хаах эрсдэлтэй.

Хүсэлтийг хаахаас өмнө тухайн асуудал нь өөр хэрэг, эсхүл өөр улсын харъяалалтай холбоотой эсэх, мэдээллийг сайн дураараа дамжуулах боломжтой эсэхийг нягтлан үзэх хэрэгтэй.

4.2. Хөрөнгийг олж тогтоох, хамгаалах

Хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах холбогдох улс хөрөнгийг үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгийг царцаах болон гүйлгээг тодорхой хугацаанд түдгэлзүүлэх арга хэмжээг шуурхай авч байх ёстой.

Гэмт хэргийн замаар олдсон хөрөнгө үрэгдсэн, алга болсон бол хөрөнгө буцаан авах ажиллагаа үр дүнгүй болно. Тухайн богино хугацаанд хөрөнгийг нуух болон бусад улсад шилжүүлэх, эд хөрөнгийг хураах энэ талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь хугацаа шаарддаг ажиллагаа болохыг анхаарч

мөрдөн шалгах ажиллагааны эхний шатанд тухайн эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах нь чухал юм.

Хөрөнгийг үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор боломжтой арга хэмжээг /хөрөнгө царцаах, зөвшөөрөл олгох, бусад шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэр болон гүйлгээг тодорхой хугацаанд түдгэлзүүлэх/ тодорхойлж, ашиглах шаардлагатай. Тухайн улс өөрийн нутаг дэвсгэрт байгаа авлигын гэмт хэргийн замаар олж авсан хөрөнгийг буцаан авах талаар эрх зүйн туслалцааны хүсэлт ирүүлээгүй байхад хөрөнгө хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авсан байвал зохино.

Холбогдох улс хамаарал бүхий бусад улсуудад холбогдох авсан албадлын арга хэмжээний талаар болон түүнд тогтоосон хязгаарлалт /хугацааны хязгаарлалт, мэдэгдэх журам/ болон холбогдох арга хэмжээг үргэлжлүүлэн авахад шаардлагатай арга хэмжээний талаар мэдэгдсэн байвал зохино. Зарим тохиолдолд эд хөрөнгөд хяналт тогтоох замаар өөр бусад сэжүүр олох замыг мөрдөн шалгах ажиллагааны стратегийн хүрээнд, эсхүл албадлагын арга хэмжээ авах нь гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдэд сэжиг төрүүлж өөр улсад байгаа хөрөнгөө шилжүүлэхээс урьдчилан сэргийлж ямар нэг албадлагын арга хэмжээг авахгүй байж болно.

Энэ тохиолдолд холбогдох улсууд авах арга хэмжээгээ тохиролоцж харилцан уялдуулах бусад арга хэлбэрээр гүйлгээг хязгаарлах болон саатуулах боломжтой эсэхийг судлана.

Алхам-1. Хөрөнгийг олж тогтоох болон хамгаалах

Хөрөнгийг олж тогтоон, хамгаалах арга хэмжээг аль болох шуурхай байдлаар дотооддоо зохион байгуулж, олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаатай байгууллага болон сүлжээг ашиглаж байх нь чухал юм. Санхүүгийн байгууллагуудын хооронд болон хууль сахиулах байгууллагууд тэдэнтэй харилцах итгэлцэл бий болгохын тулд хамтын ажиллагааг үнэлж, хөрөнгө илрүүлэх болон гүйлгээг үр дүнтэйгээр түдгэлзүүлэх ажиллагаанд уг хамтын ажиллагааг ашиглах боломж үүснэ.

Албан ёсны эрх зүйн туслалцааны хүсэлтийг ирүүлэхээс өмнө аль болох боломжтой өргөн хүрээнд болон түргэн шуурхай байдлаар түр хугацаанд хөрөнгө царцаах боломжтой механизмийг бүрдүүлсэн байна. Хөрөнгө царцаах арга хэмжээг үргэлжлүүлэн авахад эрх зүйн туслалцааны хүсэлтийг ирүүлсэн байх шаардлагатай.

Эрх зүйн системээс шалтгаалж харьяалах орнууд хөрөнгө царцаах

талаар харилцан адилгүй зохицуулалттай байдаг. Хэдий тийм боловч тухайн хөрөнгө оршин буй эсэхийг тодорхойлох нэн тэргүүний асуудал юм. Зарим оронд зөвшөөрөл шаардагддаггүй бөгөөд үүнд тодорхой хугацаагаар хөрөнгө царцаах, сэжигтэй гүйлгээний тайланг ирүүлэх хүртэл нээлттэй байлгах боломжтой байдаг. Эрх зүйн системээс хамаарахгүйгээр аль болох боломжит хүрээнд хөрөнгийг олж тогтоон, царцаах арга хэмжээг авах хэрэгтэй.

Тухайн мөчид албадлагын арга хэмжээ авах боломжгүй, эсхүл тохиромжгүй байвал, эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлах болон гүйлгээг түдгэлзүүлэх талаар бусад төрлийн арга хэмжээг судалж үзнэ.

Тухайлбал, Олон орны мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, тогтоомжид эд хөрөнгийг хамгаалах талаар төрөл бүрийн арга замыг зааж өгсөн байдаг. Санхүүгийн мэдээллийн алба нь сэжигтэй гүйлгээний мэдээлэл илэрбэл хөрөнгийн шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, хөрөнгө түдгэлзүүлсэнийг чөлөөлөхөөс татгалзах бүрэн эрхтэй байдаг ба энэ нь эрх бүхий байгууллагад энэ талаар шүүхийн шийдвэрийг гаргуулах хугацааг олгож байдаг байна.

Санхүүгийн байгууллагууд нь сайн дурын болон бие даан мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгөд хязгаарлалт тогтоож болдог. Мөн сэжиг бүхий гүйлгээг саатуулах талаар санхүүгийн байгууллагад хүсэлт гаргах, сэжигтэй гүйлгээтэй холбоотой төлбөрийн мэдээллийг үндэслэж хууль сахиулах байгууллагад мэдэгдэх зэрэг бусад арга замууд байдаг.

Энэ нь хэрэг үүсгэх эсэхийг тодорхойлоход мэдээлэл цуглуулах боломжийг олгодог. Хууль сахиулах байгууллага холбогдох санхүүгийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд харилцан итгэлцлийг бий болгох нь ач холбогдолтой байдаг.

Мөн харилцаж буй улсууд зөвлөгөө авах, харилцах сувгийг хялбаршуулах зорилгоор олон улсын байгууллага, мэргэжилтнүүдтэй холбоо тогтоон харилцаж байх нь ач холбогдолтой юм. Энэ утгаараа төв байгууллагуудын харилцах хаягийн мэдээлэл чухал үүрэгтэй бөгөөд мэргэжилтнүүд хооронд шууд харилцаж, зөвлөлдөх албан бус харилцааг тогтоох шаардлагатай.

Алхам-2. Эд хөрөнгийг түр хугацаагаар царцаах арга замууд

Холбогдох улсууд хоорондоо эд хөрөнгийг түр царцаах талаар боломжит арга хэрэгслүүдийг цаг хугацаа, үр дагавар, яллагдах нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр тодорхойлно. Түр хугацаагаар царцаах боломжгүй тохиолдолд, хамгийн үр дүнтэйгээр хөрөнгийг царцаах бусад арга

зам тухайлбал, ял шийтгэл оногдуулахгүйгээр эд хөрөнгийг хураах болон зэрэгцэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах процессыг судлаж үзнэ.

Хурааж болох эд хөрөнгийг олж тогтоосоны дараа холбогдох улсууд цаашид авах албадлагын арга хэмжээний хугацаа, анхаарах нөхцөл байдлын талаар тухайлбал, тухайн хүнд сэжиг төрүүлэх магадлал зэргийг тохиролцоно.

Аль нэг талын зохион байгууллалтгүй байдал нь тухайн хүнийг хөрөнгөө шилжүүлэх боломж олгох, ач холбогдлыг бууруулахад хүргэдэг. Харилцаж байгаа талууд нь харилцах цаг, хугацааны болон хөрөнгийг царцаахад гарч болох эрсдлийг тооцоолсон байх шаардлагатай. Прокурор эрүүгийн хэрэг үүсгэх эсэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг харгалзан үзнэ. Дотоодод авах арга хэмжээ болон эрх зүйн туслалцааны хүсэлтийн талаар ярилцсан байх хэрэгтэй.

Ял оногдуулахгүйгээр эд хөрөнгийг хураах зохицуулалттай улсын хувьд эд хөрөнгийг царцаах, энэ тухай шийдвэрийг сунгах зэрэг нөхцлийг тодорхойлсон байна.

Алхам-3. Харилцаа холбооны дараалал

Талууд шаардлагатай түр зуурын арга хэмжээг авсны дараа тогтмол харилцаж байна. Тухайлбал, албадлагын арга хэмжээ авсан цагхугацааны хязгаар, эдгээр арга хэмжээтэй холбоотой хууль зүйн үр дагавар, бэршээл зэрэг болно.

Авсан албадлагын арга хэмжээний талаар талууд бие биедээ шуурхай мэдэгдэх шаардлагатай. Харилцаж буй талууд өөрсдийн тавьж буй шаардлага болон нөгөө талаас авч болох төрөл бүрийн арга хэмжээний талаар нарийвчлан тохирсон байна. Нууц хамгаалах талаар анхааралтай тайлбарлаж, ялангуяа нөгөө талд нотлох баримтыг шилжүүлэх өмнө мэдээллийг хэрхэн задруулах талаар тайлбарлах байвал зохино.

Алхам-4. Харилцан гэмт хэрэгт тооцогдож байх

Тухайн гэмт хэрэг нь нөгөө улсын хуулиар гэмт хэрэгт тогтоогдож байх ёстой.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн зүйл нь хүсэлт хүлээн авагч талын туслалцаа үзүүлэх цар хүрээнээс хэтрэхээс сэргийлэх үүднээс хүсэлт гаргагч талд гэмт хэрэг тооцогдож байгаа үйлдэл нь хүсэлт хүлээн авсан талын хуулиар гэмт хэрэгт тооцогдож байх шаардлагатай. Хүсэлтийг илгээж буй тал хүсэлт хүлээн авах талтай урьдчилан холбогдож, эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийн талаар санал солилцох, боломжтой бол албан бусаар

зөвлөгөө хүсч болох бөгөөд энэ тохиолдолд нууцад хамаарах мэдээ, материал эсэхэд анхаарал хандуулна.

Алхам-5. Нууц задруулахаас сэргийлэх

Мэдээллийн нууц задруулах болон мэдээллийг хэт эрт задруулах нь цаашид авах арга хэмжээнд саад учруулах эрсдлийг үүсгэж болно. Холбогдох улсууд өөр хоорондоо өөрсдийн хууль тогтоомжоор нууцад хамаарах мэдээлэл, түүнийг задруулах журмын дагуу, мөрдөн байцаалтын төлөвлөгөөнд саад учруулахгүйгээр үр дүнтэй харилцана. Хүсэлт хүлээн авагч талд тухайн хүсэлтийг гүйцэтгүүлэхэд шаардлагатай нууцлал, цаг хугацаа болон бусад процессын асуудлууд холбогдох бүхий л мэдээллийг өгөх хэрэгтэй.

4.3. Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөлт

Мөрдөн шалгах ажиллагаанд оролцогч улсууд холбогдох төрийн байгууллагуудтай зөвшилцөж мөрдөн шалгах болон хууль зүйн иж бүрэн стратеги боловсруулах хэрэгтэй.

Мөрдөн шалгах болон хууль зүйн иж бүрэн стратеги боловсруулах нь хөрөнгө буцаан авах ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх чухал хүчин зүйл юм.

Стратеги нь нөөц бололцоогоо зөв хуваарилж, ач холбогдлоор нь оновчтой эрэмбтэй болгосноор тухайн хэрэгт хөрөнгө буцаах хамгийн үр дүнтэй аргыг хэрэглэхэд туслана. Ээдрээтэй хэрэгт стратегийг холбогдох бүхий л төрийн байгууллагатай зөвлөлдсөний дүнд байгуулах хэрэгтэй.

Дотоодын уялдаа холбоо буюу хууль сахиулах байгууллага, прокурор, татвар, гааль, хууль зүйн болон гадаад харилцааны, сангийн яам, харъяатын газар, санхүүгийн мэдээллийн алба, төрийн хяналт шалгалтын болон бүртгэлийн бусад байгууллагууд зэрэг болно. Энэ нь хулгайлагдсан хөрөнгийг үр дүнтэй буцаах нийтлэг зорилгын хүрээнд үр дүнтэй хамтран ажиллах боломжийг олгодог.

Дээрх стратеги төлөвлөгөөнд удирдан чиглүүлэх байгууллагыг томилж, чиг үүргийг тогтоож, хууль зүйн боломжуудыг судлаж, боломжыг олгодог. Эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн шалгах ажиллагаа явуулах, мэдээлэл солилцох, эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээх зэрэг үйл ажиллагааны дарааллын талаар төлөвлөсөн байдаг. Мэдээллийн дарааллыг тохиролцсон байх хэрэгтэй. Энэхүү төлөвлөгөөг хөрөнгө буцаан авах бүхий л процессын туршид тогтмол хянаж үзэх хэрэгтэй.

Дотооддоо төлөвлөж зохион байгуулалтад орж аль байгууллагаар мөрдөн шалгах ажиллагааны стратегийг удирдан хэрэгжүүлэх эсэхийг тогтоох нь тухайлбал, олон байгууллагаас тухайн асуудлаар эрх зүйн туслалцааны хүсэлт илгээх сонирхолтой байгаа эсэхийг олж мэдэх ач холбогдолтой. Мэдээлэл, гүйцэтгэх аясын дагуу олж авсан мэдээлэл болон нотлох баримт цуглуулах арга барил, авах мэдээллийн дараалал зэргийг мөн тохиролцох хэрэгтэй.

Боломжит албан бус арга хэрэгслүүд гүйцэтгэх ажлын дагуу олж авсан мэдээлэл, бусад мэдээллийн эх үүсвэр зэргийг эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнө ашиглаж мэдээлэл цуглуулсан байвал зохино.

Алхам-1. Мөрдөн шалгах ажиллагааны болон хууль зүйн стратегийн загвар боловсруулах

Өөр орны эрх бүхий байгууллага тодорхой хэргүүд дээр хэрэглэж болохуйц мөрдөн шалгах ажиллагааны болон хууль зүйн стратегийн загвар, шалгах төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй. Мөрдөн шалгах ажиллагааны болон хууль зүйн стратегийг гүйцэтгэхэд улсын эрх бүхий байгууллагууд нь дотоодын зохицуулалтыг шалгаж, бүхэлд нь хамарсан стратеги болон түүнийг хэрэгжүүлэхэд гарч болох үр дүнг тодорхойлох хэрэгтэй.

Мөрдөн шалгах ажиллагааны бүхий л шат болон тодорхой дараалал бүхий эрх зүйн процесс, цаг хугацаа болон талуудын хүлээх хариуцлагын талаар мөрдөн шалгах болон хууль зүйн стратеги төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Чухал үе шатуудын

Тухайлбал: албадлагын арга хэмжээ авах тогтоол, бусдын эрхийг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээ авах шийдвэр, баримт бичиг гаргуулах, нэгжлэг хийх зөвшөөрөл, тухайн хүн, түүний хамтрагч болон гэрчийг байцаах, эрх зүйн туслалцааны хүсэлт, эрүүгийн хэрэг үүсгэх талаар тохиролцсон байх шаардлагатай.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх, хууль зүйн шаардлага, хязгаарлалтыг тодорхойлсон байх хэрэгтэй. Мөрдөн шалгах ажиллагааны хариуцлагуудыг тодорхойлж, хуваарилахын тулд мөрдөн шалгах тодорхой эрх, дотоодын болон гадаад байгууллагуудын хүчин чадал, боломжийг тодорхойлж, боломжтой тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны үүрэг хариуцлагыг хуваалцаж, тохиролцох хэрэгтэй.

Боломжит эх сурвалжаас авах мэдээллийн ач холбогдлын эрэмбийг тогтоох болон тухайн хэрэгт хөрөнгө буцаахад шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлсон байх хэрэгтэй. Ажиллагаанд оролцогч улс орнууд нь тухайн

хэргийг шийдвэрлэхэд нөөц бололцоогоо зарцуулах, нөгөө улсын хүсэл эрмэлзэл болон хүлээлтийн талаар ойлголттой байх хэрэгтэй.

Алхам-2. Байгууллага хоорондын хамтын ажиллагааг аль болох эхэн үед бий болгох

Эрх бүхий байгууллагууд тодорхой хэргийн тухайд өөр хоорондоо хамааралтай үйл ажиллагаа, чиг үүрэгтэй учраас тухайн хэрэгт хууль сахиулах байгууллага болон прокуророос бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллаж болно. Ингэснээр хэргийн талаар мэдээлэл болон туршлагаа солилцож, хэргийг хэлэлцэн дүгнэх боломжийг олгоно.

Үл ойлголцол болон байгууллага хоорондын зөрчилдөөнөөс ангид байхын тулд байгууллагад байгууллага тус бүрийн гүйцэтгэх үүрэг, чиглэлийг нарийн тодорхойлсон байх шаардлагатай.

Дотоодын удирдан зохицуулах байгууллага нь харилцагч улстай мөрдөн шалгах болон хууль зүйн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан чухал шаардлагатай хэсгүүд болон олон улсын хамтын ажиллагаанд хэрхэн тусгагдсан талаар зөвшилцөж байх хэрэгтэй. Ингэснээр олон улсын хамтын ажиллагааны шаардлагуудын талаар болон хүсэлт хүлээн авсан талын хүчин чадал, нөөц бололцоо, эрх зүйн туслалцааны хүсэлтэд тугагдсан олон төрлийн туслалцааг үзүүлэхэд шаардагдах хугацааны талаар ойлголтыг өгдөг.

Алхам-3. Үйл ажиллагааны зохицуулалтын механизмыг бий болгох

Үйл ажиллагааны зохицуулалтын механизмыг бий болгосноор эрх бүхий байгууллагуудад мөрдөн шалгах ажиллагааны талаар мэдээлэл солилцох, чиг үүрэг, ажлаа хуваарилах, ач холбогдлоор нь эрэмбэлэх болон мөрдөн байцаалтын нөөц бололцоогүй зохистой хуваарилах явдал юм.

Хамаарал бүхий байгууллагууд удирдан зохицуулах байгууллага ажлыг хэсгийг томилсон байна. Оролцогч төрийн байгууллагуудын тус тусын үүрэг хариуцлагыг тодорхой тогтоож өгсөн байна. Тогтмол хугацаанд хуралдаж байх шаардлагатай.

1. Мөрдөн шалгах ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх,

2. Боловсон хүчин өөрчлөгдөхөд тухайн хэргийн талаарх мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх. Хамтын үйл ажиллагаа үргэлжлэхгүй байх болон мэдээлэл алдагдах нь хөрөнгийг үр дүнтэйгээр буцаахад саад болдог. Мөн энэ нь дотоод болон олон улс дахь итгэлцэлд саад учруулдаг.

Алхам-4. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг зэрэгцэн явуулах

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь бусад мөрдөн шалгах

ажиллагаатай зэрэгцэн явуулна.

Мөрдөн шалгах ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тухайн гэмт үйлдлийг шалгаж тогтоох ажиллагаатай зэрэгцэн гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийг илрүүлэх ажиллаа нэгэн адил явуулна. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагаатай зэрэгцэн явагдана.

Алхам-5. Нотлох баримт цуглуулах хялбар арга замуудыг судлах

Нотлох баримт цуглуулахад хялбар байх, эсхүл хөрөнгө буцаах хэргийн цар хүрээгтэлэх иргэний болон захиргааны арга замуудыг эрэлхийлнэ.

Дотоодын хууль болон бусад улсын хуулиар /хэрэв мэдэгдэж байвал/ гэмт хэрэгт тооцогдож байх бүхий л боломжтой нөхцөл байдлуудыг тогтоох шаардлагатай. Гэмт хэргийн замаар олж авсан хөрөнгийг /эрүүгийн, иргэний болон ял оногдуулахгүйгээр хөрөнгө хураах, гадаад улсын байцаан шийтгэх ажиллагааны журмаар, г.м/ буцаах олон арга замууд байж болно. Аль ч хууль зүйн арга хэлбэрүүдэд нотлох баримтын болон байцаан шийтгэх ажиллагааны шаардлагууд, хөөн хэлэлцэх хугацааны заалтыг дотоодын болон гадаад улсын хууль тогтоомжийн хүрээнд судалсан байх шаардагатай.

Алхам-6. Мөрдөн шалгах ажиллагааны стратеги төлөвлөгөөг үнэлэн дүгнэх

Мөрдөн шалгах ажиллагааны стратегийг шинээр цугларсан нотлох баримт, сэжигтэн, мэдээллийн эх сурвалж зэргээс шалтгаалан тогтмол дүгнэх шаардлагатай. Мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөө нь ажиллагааны агуулга болон цар хүрээг тодорхойлох, тухайн хэрэг өөрчлөгдөх, өрнөх явцад холбогдох байгууллагууд стратегийг шинэчлэх, тохиролцох, холбоо барих хэрэгтэй. Мөрдөн шалгах ажиллагааг дотооддоо хэрэгжүүлэхэд болон олон улсад хүсэлт илгээхэд холбогдох хууль тогтоомж, эрүүгийн процессын хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны цаг хугацааны хязгаарлалтууд нь ажиллагаанд нөлөөлөх эсэхийг бодолцох хэрэгтэй.

Алхам-7. Олон улсын хамтын ажиллагаан дахь нотлох баримтын шаардлагыг хангасан эсэхийг шалгах

Гадаад улс руу хүсэлт илгээхээс өмнө тухайн орны хууль тогтоомжид заасан нотолгооны шаардлагыг хангасан эсэхийг шалгах хэрэгтэй.

Нотлох баримтуудыг тасралтгүй шалгах нь хөрөнгө буцаах хэрэгт холбогдох улс орнуудыг шалгах ажиллагааны эхэн үед тодорхойлоход тус нэмэр болдог. Энэ нь гадаадын эрх бүхий байгууллагатай хэргийн эхний үе шатад холбоо тогтооход хэрэг болно.

Мөрдөгч аль болох нотлох баримтын шаардлага хангасан баримтыг олж авахад анхаарах ёстой. Иргэний журмаар олж авсан нотлох баримтуудыг эрүүгийн журмаар дахин олж авах шаардлага гарч болно. Нөгөөтэйгүүр, иргэний журмаар олж авсан мэдээлэл нь эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаа гүйцэтгэхэд чиглэл өгөх боломжтой.

4.4. Хугацаа

Хүсэлт хүлээн авах тухай хэд хэдэн төрлийн эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх хугацааны талаар тохиролцох шаардлагатай.

Алхам-1. Мэдээлэл дамжуулах

Хүсэлт хүлээн авч буй талд эрүүгийн хэрэг нээх болон мөрдөн шалгах ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээллийг дамжуулах ёстой. Эрх зүйн туслалцааны хүсэлтэд хариу өгөхөөс өмнө хүсэлтийн хамт шилжүүлсэн мэдээллийг хүлээн авагч тал хянаж, баталгаажуулна. Үүний дараа, хүлээн авагч тал нь хүсэлт илгээсэн улсад тодорхой хариу мэдээлэл илгээх шаардлагатай.

Зэрэгцэн шилжүүлж буй мэдээлэл нь хүлээн авагч талд ил болгож байгаа мэдээлэл байх бөгөөд боломжит, холбогдох нотлох баримтын талаар мэдэгдэх зорилготой. Ийнхүү зэрэгцэн мэдээлэл шилжүүлэх нь гадаадын оронд эрүүгийн процессыг гүйцэтгүүлэх болон өөрсдийн дотоодын эрүүгийн процессыг үргэлжлүүлэх зорилготой. Зэрэгцэн шилжүүлж буй мэдээлэлд нотлох баримт байдаггүй. Энэ нь хүлээн авагч талд нотлох баримт цуглуулуулахаар эрх зүйн туслалцааны хүсэлт /зэрэгцэн шилжүүлж/ тавьж байгаа хэрэг юм. Ийм эрх зүйн туслалцааны хүсэлтэд хүсэлт хүлээн авагч тал дотооддоо мөрдөн шалгах ажиллагаа явуулж тухайн нотлох баримтыг олсон талаарх нэмэлт мэдээлэл агуулсан байх хэрэгтэй, мөн зэрэгцэн шилжүүлсэн мэдээллийг дуурайлгаж бичсэн байх хэрэггүй байдаг. Мэдээллийг тодорхой сувгуудаар дамжуулан зэрэгцэн шилжүүлэх нь холбогдох эрх мэдэлтэй албан тушаалтантай харилцаа холбоо тогтоох нь төгс арга бөгөөд эрх зүйн туслалцааны хүсэлт үр дүнтэй болно.

Алхам-2. Албан бус арга замууд

Хүсэлт тавьж буй тал нь эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнө албан бусаар мэдээлэл авах боломжийг судлах шаардлагатай. Боломжтой бол хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлт тавьж буй талд албан бусаар мэдээлэл олох арга замуудын талаар зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлж байвал зохино.

Хүсэлт тавьж буй болон хүсэлт хүлээн авагч талууд эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхээс өмнө албан хүсэлт илгээх шаардлага бий эсэх, тухайн материал болон мэдээллийг нийтэд ил эх сурвалжаас олж авах боломжтой эсэх, гүйцэтгэх ажлын шугамаар олж авах боломжтой эсэх, шүүхэд нотлох баримтаар ашиглах үүднээс тодорхой хэлбэржилт шаардахгүйгээр хандахыг урьдчилан тохиролцох шаардлагатай. Юуны түрүүнд олон төрлийн мэдээллийн сүлжээ /мэдээлэл солилцох сүлжээнүүд/-г бүрэн ашиглаж дууссан эсэхийг судална.

Алхам-3. Зэрэгцэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах

Мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэж буй улс нь эрэлхийлж буй мэдээлэл нь өөр улсад байгаа тохиолдолд тухайн мэдээллийг идэвхитэйгээр цаг тухайд нь авч байх хэрэгтэй. Үүнээс гадна тус ажиллагаанд оролцогч улс орнууд нь хэрэгт ашиглаж буй мөрдөн шалгах ажиллагааны болон хууль эрх зүйн стратегиа уялдуулах нь эрүүгийн хэрэгт зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагаа хэрэгжүүлэх (суурь болон мөнгө угаах гэмт хэрэг г.м.) боломжийг бүрдүүлнэ.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй улс тухайн мэдээлэл өөр улсын мөрдөн байцаах ажиллагаатай холбоотой гэж үзвэл урьдчилан мэдэгдэж, солилцох боломжтой байна. Түүнчлэн харилцаж буй талууд нь тэдгээрийн мөрдөн шалгах ажиллагаа болон хууль зүйн стратегийг хоорондоо зохицуулах талаар хичээл зүтгэл гаргах хэрэгтэй.

Алхам-4. Ажиллагаанд байгаа эрх зүйн туслалцааны хүсэлтийн чухал хугацааг ойлгох

Эрх зүйн туслалцааны хүсэлтэд дурдсан санхүүгийн болон хууль сахиулагчийн гүйцэтгэх ажиллагааны мэдээлэл олгоход үүсч болзошгүй хязгаарыг тооцоолох шаардлагатай.

Хүсэлт гаргаж байгаа болон хүлээн авч буй улс эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх хугацааны талаар харилцан тохиролцож, эрх зүйн туслалцааны хүсэлт санхүүгийн, гүйцэтгэх ажиллагааны шугамаар авах мэдээлэлд хэрхэн нөлөөлж болзошгүй талаар ойлголт авсан байх хэрэгтэй юм.

Алхам-5. Эрх зүйн туслалцааны хүсэлт илгээснээр мөрдөн байцаалтын ажиллагаанд нөлөөлөх үр дүнг тооцоолох

Нууцлалын шаардлагууд, мэдээллийг ашиглах хязгаарлалт, хөөн хэлэлцэх хугацааны асуудал, эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд шаардагдах хугацаа зэрэг олон асуудлуудыг анхаарах хэрэгтэй байдаг.

Хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч талууд эрх зүйн туслалцааны

хүсэлт, түүнийг гүйцэтгэхтэй холбоотойгоор нууцлалыг хамгаалах шаардлага, хүсэлтэд дурдсан мэдээллийг тухайн этгээдэд болон гуравдагч этгээдэд задруулж болох хэмжээ хязгаар зэрэг олон асуудлын талаар харилцан тохиролцсон байвал зохино.

Алхам-6. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг ач холбогдлоор нь эрэмбэлэх

Тухайн гэмт хэргийн нөхцөл байдал, хөрөнгө, хохиролын хэмжээ, хөрөнгийг устах эрсдэл, гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш өнгөрсөн хугацаа г.м хүчин зүйлд үндэслэнэ. Хүсэлт гаргагч тал нь хүсэлт хүлээн авагч талтай эрх зүйн туслалцааны хүсэлтийг нэн тэргүүнд тавих чухал шалтгаануудын талаар шууд холбоо тогтоон хэлэлцэж, гүйцэтгүүлэхэд анхаарах шаардлагатай.

Хүсэлт гаргагч тал нь тухайн эрх зүйн туслалцааны хүсэлтийг гэмт хэргийн хүнд, хөнгөн, хөрөнгө, хохиролын хэмжээ, мөрдөн шалгах ажиллагааны үе шат, нийтийн ашиг сонирхолыг хамарсан түвшин зэрэг нөхцөл байдалд тулгуурлан ач холбогдлоор эрэмблэж, тэргүүн ээлжинд шийдвэрлүүлэхэд анхаарал тавина. Зарим тохиолдолд олон ажиллагаа бүхий эрх зүйн туслалцааны хүсэлтийг хэсэг хэсгээр нь гаргах нь илүү үр дүнтэй байдаг.

Хүсэлт нь тухайн улсын дотоодын хуульд заасан процесс болон олон улсын хамтын ажиллагаатай холбоотой байдаг тул түүнийг илгээж байгаа болон хүсэлтийг хүлээн авч байгаа талуудын хувьд тавигдах хууль зүйн шаардлагыг харилцан ойлголцсон байх нь зүйтэй. Хөрөнгө буцаах талаар олон улсын хамтын ажиллагаанд тулгардаг бэрхшээл нь эрх зүйн онол, уламжлал, жишиг эрх зүй, хураан авах тогтолцоо болон процессын шаардлагууд байдаг.

Эдгээр бэрхшээлийг даван туулснаар дотоодод процесс амжилттай явагдах боломжтой. Ялангуяа ээдрээ төвөгтэй, хохирол ихтэй хэргүүдэд олон улс хамтран ажиллах болон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд дэмжлэг болохын тулд тодорхой ажилтныг томилон ажиллуулах, харилцан мэргэжилтэн солилцох асуудлыг талууд анхааран үзэх нь зүйтэй юм.

Түүнчлэн талууд харилцан идэвхитэй харилцах, сургалт зохион байгуулах, орчуулга хийх болон бусад асуудлаар зөвлөгөө авах зэргээр олон улсын экспертүүдээс тусламж хүсэх нь процесс ажиллагаанд дэмжлэг болох боломжтой.

4.5. Шаардагдах мэдээлэл цуглуулах

Алхам-1. Талууд эрх зүйн туслалцааны хүсэлтийг явуулахад шаардлагатай мэдээллийг боломжит эх сурвалжийг ашиглан цуглуулах (удирдамж, мэдээллийн сан, вэб хуудсууд, практик ажилтнуудын сүлжээ гэх мэт)

Талууд тус тусын харьяаллын хүрээнд мөрдөгдөх удирдамж, зааврыг боловсруулж хэвлэх нь зүйтэй. Үүнд холбоо барих хүмүүс, мөрдөн байцаалтынүед үзүүлэх дэмжлэг, бусад холбогдох арга хэмжээний талаар болон эрх зүйн туслалцааны хүсэлт үзүүлэх процессын талаархи мэдээлэл, журмуудыг оруулсан байна. Хүсэлт илгээж байгаа тал нь хүсэлтийг хүлээн авагч талтай холбогдохоос өмнө тэдгээр удирдамжийг судлан анхаарах зүйлүүдийг мэдэж авах шаардлагатай.

Алхам-2. Эрх бүхий төв байгууллагууд харилцан идэвхитэй байх

Эрх бүхий төв байгууллагууд нь олон улсын хамтын ажиллагаатай холбогдуулан дотоодын эрх бүхий байгууллагуудад зөвлөгөө өгөхдөө идэвхитэй байр суурьнаас хандах хэрэгтэй. (эрх зүйн туслалцааг хянан үзэх, хүсэлт хүлээн авагч талын зүгээс тавигдах гол шаардлагуудад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зэрэг үед)

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг хянаж, наад захын тавигдах шаардлагууд нь тухайн хэрэг, тохиолдол бүрийн хувьд яригдаж байдаг учраасэрх зүйн туслалцаагхүсэлтийн талаарх удирдамжийн талаархи зөвлөгөө өгөхөөс гадна хүсэлтийг илгээж талын эрх бүхий байгууллага нь хүсэлт хүлээн авагч талтай идэвхитэй холбоо тогтоож, тухайн тодорхой хэргийн талаар тайлбарлах, хүсэлтийг төслөөр илгээн зөвлөгөө авах нь зүйтэй. Тийнхүү урьдчилан хэлэлцэх явцад стратегийн болон техникийн шинжтэй шаардлагуудын талаар хөндөж тодруулсан байх хэрэгтэй юм.

Алхам-3. Нөгөө талын эрх бүхий байгууллагатай холбоо тогтоох

Хүсэлтийг хүлээн авагч талаас тавигдах тусгайлсан хууль зүйн, тактикийн болон практик шаардлагуудыг судлахын тулд тухайн орны эрх бүхий байгууллагатай холбоо тогтоох нь зүйтэй.

Харилцаж байгаа талууд нь бие биенийхээ хууль зүйн шаардлага, процессын талаар бүрэн мэддэг гэсэн дүгнэлтийг урьдчилан хийж болохгүй. Тиймээс тухайн эрх зүйн туслалцааныхүсэлтийг илгээхээс өмнө төслийн шатанд хэлэлцэх, Эрх зүйн туслалцаагхүсэлтийн удирдамжуудаа харилцан

солилцож зөвлөлдөх шаардлагатай. Ингэснээр учрах саадыг арилгаж, олон улсын хамтын ажиллагааны шуурхай байдлыг хангана.

Алхам-4. Хүсэлтийн талаархи хангалттай мэдээлэл

Ихэнхи эрх бүхий төв байгууллагууд нь эрх зүйн туслалцаагны хүсэлттэй холбогдох удирдамжийг боловсруулж мөрддөг. Хүсэлтийг илгээж байгаа улс нь хүсэлт хүлээн авагч орны зүгээс тавигдах шаардлага, бусад мэдээллийг юуны түрүүнд өөрийн орны эрх бүхий төв байгууллагад хандаж авах нь зүйтэй.

Ялангуяа ээдрээ төвөгтэй, хохирол ихтэй хэргүүдэд хүсэлтийг хүлээн авагч тал нь хүсэлтийг илгээж байгаа талд аль болох боломжит өргөн хүрээнд туслалцаа үзүүлэх ёстой. Тухайлбал, хүсэлтэд тавигдах хууль зүйн шаардлагыг нөгөөталдаа ойлгуулах, эрх зүйн туслалцаагны хүсэлтийн эхний төслийг хянан үзэх зэргээр ажиллаж болно.

Алхам-5. Хүсэлтийг илгээсний дараа хүлээн авсан талтай идэвхитэй хамтран ажиллах

Хүсэлтийг илгээсний дараа хүсэлт хүлээн авсан талтай (байнга утсаар холбогдох, видео хурал хийх, нүүр тулан уулзах зэргээр) идэвхитэй хамтран ажиллах замаар олон улсын хамтын ажиллагааг баталгаажуулна.

Хүсэлт илгээж байгаа тал нь хүсэлтийг хүлээн авсан талтай байнга, тодорхой хугацаанд утсаар холбогдох, мэдээлэл, нотлох баримтыг олж авах талаар өөрийн ашиг сонирхлоо илэрхийлж байх нь чухал юм. Мөн хүсэлт илгээж байгаа тал нь ижил төрлийн эрх зүйн туслалцааг үзүүлэхийг хүсч байгаа тохиолдолд хүсэлт хүлээн авагч тал нь мөн тийнхүү туслалцаа үзүүлэхэд бэлэн гэдгээ илэрхийлэх хэрэгтэй.

4.6. Холбоо барих

Хүсэлтийг илгээж байгаа болон хүлээн авагч талууд хоорондоо шууд харилцаж, холбоо тогтоож ажиллах нь зүйтэй юм.

Хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд нөлөөлдөг гол хүчин зүйлүүдийн нэг нь хамтран ажиллаж байгаа талууд шууд, тогтмол харилцаатай байж хамтран ажиллах явдал.

Эрүүгийн болон санхүүгийн тагнуулын, эсхүл мөрдөн байцаалтын мэдээллийг солилцохоос гадна талуудын дотоодын хууль тогтоомжоор хэргийн стратеги, эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах шаардлага, хэргийн стратегийг хамтран хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэлүүдийн талаархи

мэдээллийг харилцан солилцож болно.

Ийнхүү талууд харилцан хамтын ажиллагааг дэмжих явдал нь мэдээллийг шуурхай солилцох, ажиллагааны болон хууль зүйн түвшинд учирч болохуйц хүндрэл саадыг ойлгож, улам нягт хамтран ажиллахад түлхэц болж байдаг. Энэ нь мөн харилцан итгэлцлийг бэхжүүлж, цаашдын хамтын ажиллагааны хөшүүрэг болж өгнө.

Хүсэлтийг илгээж байгаа болон хүлээн авагч талууд олон улсын экспертийн туслалцааг авах нь чухал.

Хууль сахиулах байгууллагууд нь олон улсад тархан байршуулсан томоохон хэрэг дээр хөрөнгө буцаах ажиллагаанд энэ чиглэлээр мэргэшсэн экспертүүдийн туслалцааг авах явдал нэмэгдэж байна. Тухайн мэргэжилтнүүдийг тагнуулын болон хууль сахиулах байгууллагаас, эсхүл тухайн хүсэлтийг илгээж байгаа талын холбогдох байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагаанд дэмжлэг хувь нэмрээ оруулахуйц, гадаад орны зүгээс тавигдах шаардлагыг ойлгодог тийм мэргэжилтнүүдийг бусад байгууллагаас, эсхүл хуулийн фирмүүдээс урьж хамтран ажиллаж болно.

Ялангуяа улс дамнан үйлдэгдсэн, ээдрээ төвөгтэй авлигын, эсхүл мөнгө угаах хэргийг шалгахад хүсэлт илгээж байгаа, эсхүл хүлээн авагч тал туршлага, чадвар дутмаг, эсхүл тухайн хүсэлттэй холбоотой бусад өөр шалтгаан байгаа тохиолдолд тэдгээр мэргэжилтнүүдийн туслалцааг авах нь нэн тустай байдаг нь батлагдсан байна.

Хөндлөнгийн экспертүүдийн зүгээс мөрдөн байцаалтын стратеги, хэргийн төлөвлөлтийг боловсруулахад туслалцаа үзүүлэх боломжтой байдаг. Нэгэнт хөндлөнгийн мэргэжилтний туслалцааг авч байгаа бол цаашид талуудын хоорондын харилцааны үед ч хамтран оролцох боломжтой юм.

Мэдээллийг хуваалцах бүх боломжтой сувгийг олон улсын болон бүс нутгийн түвшинд ашигладаг байх хэрэгтэй бөгөөд хүсэлт илгээж байгаа болон хүлээн авагч тал мэдээллийг аль болох эртхэн, урьдчилан солилцож ажиллах явдал нь мөрдөн байцаалтын ажиллагаанд онцгой түлхэц болж өгдөг байна. Тийнхүү хариуцсан ажилтнууд хамтран ажилласнаар харилцан итгэлцлийг бэхжүүлж, улмаар мөрдөн байцаалтын ажиллагаа, яллах болон олон улсын хамтын ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.

Алхам-1. Бүтээлч харилцаа үүсгэх

Гадаад улсын холбогдох байгууллагатай харилцан итгэлцсэн, тогтвортой, үргэлжилсэн харилцааг үүсгэхийн тулд аль болох эртнээс бүтээлчээр харилцаж,

итгэлцлийг бий болгох асуудал нь шинээр харилцаа тогтоохоос гадна тогтсон харилцааг өргөжүүлэх асуудлын аль алиныг хамаарна. Холбоо барих сувгийг тодорхой болгохоос гадна итгэлцлийг мөн бий болгох харилцааны гол түлхүүр нь итгэлцэл байх учиртай. Итгэлцлийг бий болгох нь тухайн асуудлын талаар буруу ойлголт, төсөөлөлтэй болохоос сэргийлж байдаг.

Шууд харилцааг үүсгэх үр дүнтэй аргын нэг нь ижил түвшний байгууллагуудын үе шаттай харилцаа юм. Энэ харилцааг шууд харилцах боломжтой утсан холбоо скайп байж болно, и-мэйл, видеоконференци, талуудын хууль сахиулах байгууллагуудын биечилсэн уулзалт гэх мэт төрөл бүрийн механизмуудыг ашиглан үүсгэх боломжтой. Энэхүү харилцааг тухайн бодит хэргийн талаар хүсэлтийг илгээхээс өмнө аль болох эртнээс үүсгэсэн байх нь зүйтэй. Элчин сайдын яамд нь мөн үүнд дэмжлэг үзүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Тогтвортой, үргэлжилсэн байдлаар харилцаж цаг хугацаанд нь асуудалд хариу өгөх, нууцлалын шаардлагыг хангах асуудал нь итгэлцлийг тодорхой түвшинд хүргэж бэхжүүлэхэд чухал хүчин зүйлүүд болно. Ямар нэг хязгаарлалт, эсхүл удаашруулсан байдал үүсэх магадлалтай байгаа тохиолдолд шууд нөгөө талтайгаа харилцан мэдэгдэхийг зөвлөдөг байна.

Алхам-2. Сүлжээ үүсгэх, үр дүнгийн талаар мэдээлэх

Холбоо барьж үр дүнгийн талаар мэдээлэл авах боломжтой бүх сүлжээг ашиглаж, тогтсон хариуцсан хүнтэй нь идэвхитэй харилцах, шууд харилцах этгээдийг холбогдох хуулиар тодорхой зааж өгөөгүй тохиолдолд хоёр талт, эсхүл олон талт гэрээг харилцагч талуудын хууль сахиулах байгууллагууд байгуулах замаар тийнхүү шууд харилцааг дэмжих явдал нь харилцааны эхлэх цэг болж өгдөг. Түүнчлэн олон улсын болн бүс нутгийн түвшинд ажилладаг практик ажилтнуудын сүлжээнд нэгдэж, тэднээс тусгайлан зохион байгуулагддаг форум, семинарт оролцох нь холбоо тогтоож, шууд харилцах явдалд чухал ач холбогдолтой байдаг юм.

Сүлжээнд нэгдэж, холбоо тогтоох нь өөрөө үргэлжилсэн үйл явц байдаг ба практик ажилтнууд хэнтэй харилцах талаар мэдээлэл байхгүй байгаа тохиолдолд тухайн сүлжээний нарийн бичгийн даргатай холбогдон энэ талаар тодруулах хэрэгтэй. Зарим сүлжээ байгууллагууд харилцааны болон мэдээлэл солилцооны аюулгүй байдлыг хамгаалах, дэмжих үүднээс тодорхой шалгуурыг тавьдаг байна.

Олон улсын хурал, төрөл бүрийн ажиллагаанууд нь цаашид сүлжээ үүсгэх гол арга хэрэгслийн нэг ба эдгээр ажиллагаанд оролцож байгаа тохиолдолд

өөрийн хэн болох, ямар ажиллагаа хариуцдаг, хэрхэн холбоо барьж хамтран ажиллах боломжтой талаарх мэдээллийг бусад оролцогчидтойгоо хуваалцах хэрэгтэй.

Тухайн асуудлыг хариуцдаг хүн нь байнга солигдох боломжтой тул олж авсан холбоо барих талаарх мэдээллийг хадгалж байх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл тухайн мэдээлэл нь байгууллагын түвшинд байдаг мэдээллийн санд хадгалагдаж, хүмүүс өөрчлөгдсөн талаарх мэдээллийг цаг бүрт нь солилцож байх ёстой.

Алхам-3. Олон улсын мэргэжилтнээс зөвлөгөө авах асуудал

Тусгайлсан дэмжлэг болон зөвлөгөө авах, түүнчлэн олон улсын хамтын ажиллагаанд холбоо тогтоох явдалд тусламжаа авахын тулд олон улсын мэргэжилтний тусламжийн хүсч болно. Тэдгээр мэргэжилтнүүдийн үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтоож өгсөн байх нь нууцлалыг хамгаалах, мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахгүй байх болон зардалтай холбоотой асуудлыг зохицуулахад чухал ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдийн туршлагаас харахад Олон Улсын Хөрөнгө Буцаах Төв, Дэлхийн банк, НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газрын дэргэдэх Хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох санаачилга зэрэг олон улсын тусгайлсан байгууллагуудаас талууд тусламж авах явдал нэмэгдсэн байна.

Эдгээр байгууллага нь янз бүрийн орны төлөөллийн олон жилийн туршлагатай мэргэжилтнүүдээс бүрддэг бөгөөд тухайн холбогдох асуудлаар аль ч улсад хууль зүйн зөвлөгөө өгөх чадвартай, тийм эрхтэй байдаг байна.

Зарим тохиолдолд улс гүрнүүд хүсэлт илгээж байгаа талыг хүсэлтийг хүлээн авагч талд гүйцэтгэх хууль зүйн процесс ажиллагаанд төлөөлүүлэхээр хуулийн фирмүүдээс тусламж авсан байдаг. Энэ тохиолдолд хуулийн нэр хүнд бүхийфирмийг сонгох, ямар үйл ажиллагаанд оролцуулах талаар (мөн төлбөрийн нөхцөл, ажлын хамрах хүрээ зэргийг) нарийвчлан тодорхойлсон байх нь зүйтэй.

Гэхдээ олон улсын мэргэжилтний тусламжаа авахдаа гарах зардал, нууцлалд тавигдах шаардлагууд болон мэдээллийг бусдад задруулах эрсдэлийг тооцсон байх нь чухал юм. Хэдийгээр олон улсын мэргэжилтний тусламжааг авч байгаа ч гэсэн шийдвэр гаргах талаар эцсийн хариуцлага нь эрх бүхий байгууллагын үүрэг гэдгийг ойлгох хэрэгтэй.

Алхам-4. Практик ажилтнуудын сүлжээ байгууллагатай хамтран ажиллах

Практик ажилтнуудын сүлжээ ямар байгууллагууд байгааг судлан, тэдний нарийн бичгийн дарга нарын газраас дамжуулан холбоо тогтоож, мэдлэг, туршлага солилцон хамтран ажиллах боломжтой. Олон улсын болон бүс нутгийн түвшинд ажилладаг практик ажилтнуудын сүлжээ байгууллагууд нь ямар төрлийн практик мэдээллийг солилцох боломжтой талаараа жагсаалт гаргасан байдаг. Гэхдээ энэ нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа биш юм. Тиймээс практикийн ажилтнууд мэдээллийн хуваалцах хуулиар тогтоосон хүрээ, хязгаарыг ойлгож, дагаж мөрдөх хэрэгтэй. Нийтэд ил мэдээллийг практик ажилтнуудын түвшинд солилцож болно. Харин, нийтэд ил биш, эсхүл шүүхийн шийдвэр, захирамжийн дагуу олж авах мэдээллийг уг сүлжээгээр дамжуулан солилцох боломжгүй. Түүнчлэн нотлох баримтыг олж авахыг хүсч байгаа тохиолдолд практик ажилтнуудын сүлжээ ашиглагдахгүй нотлох баримтыг олж авах гэж байгаа тохиолдолд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт бичигдэх шаардлагатай юм.

Зарим тодорхой хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан талууд харьяа тагнуул, хууль сахиулах болон прокурорын байгууллагын ажилтнуудыг нэгтгэсэн форумыг байгуулж холбогдох, биечлэн уулзалт хийж болдог. Ингэснээр мэдээллийг хамгийн боломжтой өргөн хүрээгээр солилцох боломжтой. Иймэрхүү практик ажилтнуудыг оролцуулсан сүлжээ нь дотоодод ажиллаж байгаа бусад сүлжээний үйл ажиллагаанд ч дэмжлэг үзүүлэх боломжтой.

Хууль сахиулах байгууллагууд ялангуяа улс дамнасан хэрэгт хөрөнгө буцаах ажиллагаанд олон улсын болон бүс нутгийн түвшинд ажилладаг практик ажилтнуудын сүлжээ байгууллагуудын туслалцааг авсан практикууд маш амжилттай хэрэгжсэн байдаг. Иймэрхүү сүлжээ байгууллагууд цаашилбал Санхүүгийн тагнуулын албад болон хууль сахиулах зэрэг байгууллагуудтай мэдээллээ хуваалцах боломжтой. Тэдний зүгээс өгч байгаа тодорхой хэрэгтэй холбогдолтой мэдээлэл нь нотлох баримтаар тооцогддогүй тул яг мөрдөн байцаалтын болон яллах ажиллагаанд шууд ашиглагдах боломжгүй.

Энэ төрлийн сүлжээ нь мөн хөрөнгө буцаах салбарт бусад орны хэрэгжүүлж байгаа туршлагын талаархи ойлголтой болох, улмаар мөрдөн байцааж байгаа болон яллаж байгаа хэргийн стратегийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг. Практикийн ажилтнууд тухайн сүлжээний чухам ямар хүмүүстэй холбогдохоо мэдэхгүй байгаа тохиолдолд нарийн бичгийн дарга нараас нь тодруулах шаардлагатай.

4.7. Харилцаа холбоо

Хүсэлт гаргагч тал нь мөрдөн шалгах ажиллагааны холбогдох элементүүд, хууль зүйн стратеги, хэргийн тойм болон субъектын мэдээлэл зэргийг хүсэлтийг хүлээн авах талтай шуурхай хэлэлцэх хэрэгтэй.

Хэргийн талаархи товч мэдээлэл болон холбогдсон этгээдийн талаар эртнээс холбогдон хэлэлцэж байх нь харилцаж буй талууд хүсэлт тавигч талын хэрэгцээг ойлгох бололцоог өгч, мөрдөн шалгах ажиллагаа болон хөрөнгө буцаах ажиллагаанд дэмжлэг болох, олон улсын хамтын ажиллагааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд түлхэц болох тийм хандлагыг бий болгоно.

Сайн дураар харилцаж буй талуудын холбогдох мөрдөн шалгах ажиллагааны элемент болон хууль зүйн стратегийн талаар мэдээлэл солилцох нь хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч талуудын аль нэгний харьяаллын хүрээнд тухайн стратегийг хэрэгжүүлэхэд үр дүнд нь саад учруулж болох хүндрэл бэрхшээлийг тогтоож, тэдгээрийг шийдвэрлэх арга замуудыг олж тогтоох бололцоо олгодог. Энэ нь мөн нэн чухал итгэлцэл үүсгэх нөхцөл гэж ойлгоно.

Харилцаж буй талууд нь хариуцан ажиллаж буй ажилтныг томилж холбоо барих мэдээллийг хамтран ажиллаж буй бүх талд мэдэгдэх хэрэгтэй.

Холбоо барихаар томилогдсон хүн нь хүсэлт гаргагч тал болон хүсэлт хүлээн авагч талуудыг үр дүнтэйгээр холбох үүрэгтэй байна. Энэ нь холбогдох эрх бүхий байгууллагуудын хооронд зохицуулалт хийхэд дэмжлэг үзүүлэх харилцаа холбооны эхний цэг байна. Холбоо барих хүн байхгүй байснаар талуудын хоорондын хамтын ажиллагаа болон зохицуулалтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд саад учруулах, эсхүл маш хязгаарлагдмал болгоно. Холбоо барих хүн тодорхой бус байснаар талуудын хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж, удаашрал гацалт үүсгэхэд хүргэнэ.

Холбоо барих хүнийг тогтоосноор талуудын хооронд тодорхой болон үр дүнтэй харилцаа холбоо үүсгэнэ. Холбоо барих хүнийг тогтоосноор процессын эхнээс хөрөнгө буцаах ажиллагааны тулгуур суурь болох шууд харилцаа холбоо байгуулах ажлыг бүрдүүлнэ. Харилцаж буй талууд нь хоорондоо болон өөрсдийн дотоодын байгууллагуудад боломжит богино хугацаанд тэдгээрийн хэргийн талаар холбоо барих хүний талаар мэдээлж, тэдгээрийн боломжит сувгуудыг ашиглах зөвшөөрлийг авна.

Тогтоосон холбоо барих хүн нь тухайн хэргийн ахлах мөрдөгч, эсхүл

прокурор байвал илүү зохимжтой. Хэрэв боломжгүй тохиолдолд гадаад хэлэндээ сайн биш гэх зэрэг шалтгаан байвал эрх зүйн туслалцааны хүсэлтийг хариуцсан ажилтан нь холбоо барих хүн нь болж ажиллах хэрэгтэй.

Алхам-1. Харилцаж буй талууд харилцаа холбоо тогтоож, мөрдөн шалгах ажиллагааны зорилго, ач холбогдлын эрэмбүүдийг тодорхой болгох

Харилцаа холбоо тогтоож, мөрдөн шалгах ажиллагааны зорилго, ач холбогдлын эрэмбүүдийг тодорхой болгох. Хүсэлт хүлээн авагч тал нь энэ зорилгыг хэрэгжүүлэхэд тохиромжтой хууль зүйн хэрэгсэл байгаа эсэхийг тодорхойлно.

Хамтын ажиллагааны эхэн үед ихэнхи тохиолдолд талуудад үйл явцын талаархи мэдээлэл шаардлагатай байдаг. Хүсэлт тавьж буй тал нь холбогдох мөрдөн шалгах ажиллагааны элементүүд, хууль зүйн стратегийг хүсэлт хүлээн авсан талд танилцуулж, ямар үр дүн, зорилгод хүрэхийг эрмэлзэж байгаа, мөн тэдгээр үр дүнд хүргэх боломжтой хууль зүйн арга замуудыг тайлбарлан ойлгуулах боломжтой юм.

Хүсэлт гаргагч тал мөрдөн шалгах ажиллагааны болон хууль зүйн стратегийг нарийвчлан боловсруулсан байх нь бусад талуудтай хуваалцах шаардлагатай мэдээлэлд чухал ач холбогдолтой байдаг. Ямар хууль зүйн арга хэрэгсэл ашиглах талаархи мэдээлэл тодорхой болмогц, тухайн тавьж буй хүсэлтээс болон хэргийн хувьд ямар нөхцөл байдлыг нотлох шаардлагатайгаас хамааран бусад шаардлагатай мэдээллийг талууд харилцан солилцоно. Мөрдөн шалгах ажиллагааг зэрэгцэн явуулж байгаа бол мөрдөн байцаалтын болон хууль зүйн стратегийн талаар харилцан мэдээлэх нь зүйтэй.

Үүний үр дүнд хүсэлт тавигч тал хэргийн талаархи товч мэдээллийг танилцуулах хэрэгтэй. Үүнд:

1. Хэрэгт холбогдуулан шалгагдаж байгаа этгээдийн талаар,
2. Үйлдэгдсэн байж болзошгүй гэж үзэж буй гэмт хэргийн талаар,
3. Тухайн гэмт хэрэг хаана үйлдэгдсэн талаар,
4. Тухайн гэмт хэрэг хэзээ гарсан талаар,
5. Субъект яагаад тухайн гэмт хэргийг үйлдсэн болох ,
6. Тухайн гэмт хэргийг хэрхэн үйлдэгдсэн болох,

Холбогдуулан шалгаж буй субъектын талаарх мэдээлэл нь хуулийн этгээдийн талаар мэдээллийг танилцуулах /холбоо, компани, нөхөрлөл г.м/ болон хувь хүний талаар мөн мөрдөн шалгагдаж байгаа гэмт үйлдлийн талаар

байна. Тухайлбал: гэмт хэргийн субъекттэй холбоотой хөрөнгө, санхүүгийн мэдээлэл, эцсийн өмчлөгийн талаар боломжтой мэдээлэл, санхүүгийн болон харьяаллын мэдээллүүдийг бэлтгэх хэрэгтэй. Мөрдөн шалгах ажиллагааны болон хууль зүйн стратегийн холбогдох хэсгийг тодруулах мөн хөрөнгө буцаах ач холбогдлын эрэмбийг тайлбарлах шаардлагатай юм.

Тухайн гэмт хэргүүдийн хоорондын холбоо, олж авсан хөрөнгө болон хүсэлт хүлээн авах талуудыг тодорхойлох, хүсэлт илгээж байгаа талын хууль тогтоомжийн дагуу мөрдөн шалгах ажиллагааны үед эдлэх эрх болон хууль зүйн арга хэрэгслийг /хөрөнгийг битүүмжлэх, царцаах механизмын талаар г.м/ тодорхойлох хэрэгтэй. Энэ мэдээлэл нь хүсэлт хүлээн авагч талд тодорхой хэрэгт /хүсэлтийн дагуу/ хамгийн тохиромжтой мөрдөн шалгах ажиллагаа болон хууль зүйн арга хэрэгслийг хэрэглэх боломж олгодог байна.

Түүнчлэн нэг хүсэлтийн талаар хэд хэдэн талууд хамтран ажиллаж байгаа тохиодолд хүсэлт илгээгч тал нь талуудын аль нэгэнтэй нь, эсхүл бүгдэнтэй нь нэгэн зэрэг, эсхүл тус тусад нь харилцаа холбоо тогтоох эсэх талаар шийдвэр гаргана.

Эцэст нь хамтын ажиллагааны процесс маш чухал бөгөөд байнга шинэчилж байх шаардлагатай. Хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч талууд шинэ алхмууд хэрэгжүүлэхийн хамт шинэ мэдээллүүдийг харилцагч талуудтай холбоо барьж мэдэгдэх шаардлагатай.

Алхам-2: Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлтийг гүйцэтгэхэд нөлөөлж болох холбогдох бүхий л мэдээллээр хангагдсан байх ёстой. /нууцлал, хугацаа болон бусад процессын асуудлууд г.м/ Хүсэлт хүлээн авагч болон хүсэлт илгээгч талууд нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг бүрэн гүйцэтгэхэд шаардлагатай бүхий л тодорхой мэдээллүүдийн талаар хоорондоо харилцан холбогдож хууль зүйн болон мөрдөн шалгах ажиллагааны стратегид сөргөөр нөлөөлөх зүйл байгаа эсэхийг шалгана.

Энэ утгаараа нууцлалын асуудал онцгой чухлаар тавигддаг. Тухайлбал, эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүлээн авагч тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэгдэж байгаа талаар тухайн хэргийн субъект болон шүүгдэгчдэд мэдэгдэх шаардлагатай байж болох ба хүсэлт илгээгч тал хүсэлтийг гүйцэтгэхэд шаардагдах тодорхой хугацааг харгалзан үзэхийг хүсч болно.

Мөрдөн шалгах ажиллагааны гол зорилгод хүрэхэд цаг хугацааны хүчин зүйл шууд хамааралтай. Ингэхдээ эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд

хугацаа болон хэр яаралтай байгаа эсэх нь мөрдөн шалгах ажиллагааны стратегид чухал ач холбогдолтой. Түүнчлэн, процессын асуудлууд нь магадгүй нотлох баримтыг үнэлэхэд нөлөөлөх эсэх асуудлыг харилцаж буй талуудын хооронд харилцаа холбоо тогтоож тодорхой болгох хэрэгтэй .

4.8. Зэрэгцсэн мөрдөн шалгах ажиллагаа

Хүсэлт хүлээн авагч тал нь хөрөнгө, түүнийг тойрсон фактууд нь тухайн улсын хууль тогтоомжийг ямар нэг байдлаар зөрчсөн эсэхийг тогтоох зорилгоор зэрэгцсэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах асуудлыг анхааран үзэх ёстой.

Зэрэгцсэн, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа, эсхүл мөрдөн шалгах ажиллагааг нэг цаг хугацаанд зэрэгцэн явуулах гэдэг нь тухайн факт нь талуудын хууль тогтоомжийг зөрчсөн гэмт хэргийн шинжтэй эсэхийг тогтоох зорилгоор 2 тал нэг цаг хугацаанд явуулж байгаа ажиллагаа байдаг. Тийм учраас 2 ба түүнээс дээш улсын нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн ээдрээ төвөгтэй, зохион байгуулалттай /комплекс/ хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагааны явцад талуудын мөрдөх байгууллагууд үйл ажиллагаагаа холбон зэрэгцэн мөрдөн шалгах боломжтой байдаг.

Ялангуяа мөнгө угаах болон мөн түүний суурь гэмт хэрэг болдог авлигын гэмт хэргүүд зэрэг санхүүгийн комплекс хэргүүд нь улс дамнан үйлдэгдэгддэг онцлогтой байдаг тул зэрэгцэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь илүү үр дүнтэй байдаг.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа тал нь нөгөө талд хамааралтай байж болохуйц мэдээллийг цаг тухайд нь хуваалцаж ажиллах нь чухал юм. Хүсэлтийг илгээсэн болон хүлээн авсан талууд аль аль нь тухайн болсон факт нь аль талынх нь хуулийг зөрчсөн үйлдэл болохыг тогтоох зорилгоор зэрэгцсэн эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай эсэхийг авч үзэж байх хэрэгтэй.

Түүнээс гадна мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа талд хүсэлтийг гүйцэтгэж байгаа талын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байж болох хэргийн талаар мэдээлэл байгаа бол нэн даруй мэдээлэх ёстой.

Хүсэлтийг илгээгч болон хүлээн авагч талууд зэрэгцэн ажиллагаа явуулж байх үед мэдээллийг цаг алдалгүй боломжтой хэлбэрээр солилцон, үндэслэл бүхий хүсэлтийг яаралтай илгээх шаардлагатай.

Ихэнхи гэмт хэргүүд улс дамнан үйлдэгдэж байгаа онцлогтой холбоотойгоор

нөгөө талд явагдаж байгаа мөрдөн шалгах ажиллагаатай уялдуулан тагнан мөшгих замаар мэдээлэл цуглуулах шаардлага үүсдэг. Зэрэгцэн мэдээлэл цуглуулж, харилцан солилцох нь талууд мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх, эсхүл тухайн мэдээллийг нотлох баримт болгон бэхжүүлэх эсэх асуудалтай холбогддог байна.

Энэ нь тодорхой материалыг шүүх хуралдааны үед нотлох баримтын зорилгоор ашиглахаас өөр буюу гүйцэтгэх ажлын мэдээллийг солилцох процесс нь зөвхөн мөрдөн шалгах ажиллагааны өмнөх шатанд хийгднэ. Нэмэлт мэдээллийг байнга солилцон ажиллах нь эцсийн дүндээ эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээх, хүлээн авч гүйцэтгэх талууд үргэлжлүүлэн мэдээлэл солилцох үндэслэл болно.

Энэхүү албан бус сувгаар мэдээллийг солилцсоноор өөрийн орны хууль тогтоомж зөрчигдсөн эсэхийг хүсэлтийг хүлээн авагч тал шалгах ажлыг эхлүүлж зайлшгүй алхмуудыг хурдан хугацаанд авах асуудлыг шийдвэрлэх боломжтой байдаг тул тийнхүү мэдээлэл солилцохдоо аль болох өргөн хүрээнд солилцож ажиллах нь чухал ач холбогдолтой юм.

Эгмонт болон бусад практик ажилтнуудын нэгдсэн сүлжээ зэрэг албан бус сувгаар мэдээлэл солилцох явдал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх ажиллагааны үр дүнд ч эерэгээр нөлөөлж байна.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг шуурхай гүйцэтгэхдээ мөрдөн байцаалтын болон нотолгооны зорилгоор ашиглаж болох тийм материалыг дамжуулах явдал чухал юм. Эрх зүйн туслалцааны хүсэлтээр дамжуулан илгээхийг хүссэн материалыг яаралтай шилжүүлснээр хүсэлт илгээсэн талын эрх бүхий байгууллага мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээ тогтоох, (өөрөөр хэлбэл, хөрөнгийн мөрөөр мөшгих цаашдын алхмаа илэрхий болгох) хөрөнгийн байршлыг тогтоох боломжийг нэмэгдүүлэх, хөрөнгийг битүүмжлэх шийдвэрийг гаргуулах улмаар шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцүүлэхэд бэлтгэх зэрэгт ихээхэн нэмэр тус болно.

Хүсэлтийг илгээсэн болон хүлээн авсан талууд явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд харилцан оролцох эрхтэй байна.Зарим орнуудын хувьд, мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд хохирсон тал тогтоогдмогц гэмт хэргийн улмаас хохирол амссан тал нь иргэний нэхэмжлэгч болж эрүүгийн хэрэгт оролцохыг зөвшөөрдөг. Энэ тохиолдолд мөрдөн шалгах болон яллах ажиллагааны зорилгоор хохирсон талд хэргийн холбогдох материал, нотлох баримтыг илгээх боломжтой.

Иргэний нэхэмжлэгчээр тооцогдохоос өмнө хүсэлтийг илгээгч талын зүгээс энэ асуудлын үр дагавар, иргэний нэхэмжлэгчийн хувьд өгөх боломжтой нотлох баримтуудын талаар хүсэлт хүлээн авагч талтай хэлэлцэх хэрэгтэй. Иргэний нэхэмжлэгчээр тооцогдсон байгаа нь хоёр тал эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд саад болохгүй, харин ч мэдээллийг шуурхай солилцоход улам нэмэртэй болж өгнө.

Талууд мөн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаатэй зэрэгцүүлэн иргэний нэхэмжлэлийн механизмыг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар анхааран үзэх хэрэгтэй.

Хүсэлтийг илгээсэн болон хүлээн авсан талууд мөрдөн шалгах ажиллагааг зэрэгцэн болон хамтарсан хэлбэрээр явуулах эсэхээ тодорхойлох шаардлагатай болно.

Мөрдөн шалгах стратегийн хувьд нийтлэг зорилготой байгаа тохиолдолд талууд эрх бүхий байгууллагуудыг оролцуулан мөрдөн шалгах ажиллагааг хамтарсан хэлбэрээр явуулах баг байгуулж, тус тусын нутаг дэвсгэрт холбогдох асуудлыг хариуцан ажиллаж болно. Хэрэв ийнхүү хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар тохиролцсон бол хийх ажлаа давхцуулахаас зайлсхийж, нэг зорилготой байж, байнга харилцан мэдээлэл солилцож ажиллана.

Хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь талуудаас илүү үр ашигтайгаар хамтран ажиллахыг шаарддаг. Талуудын практик ажилтнууд юуны түрүүнд тийнхүү хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэл, хүрээ хязгаараа судлах нь зүйтэй. Жишээлбэл: Нотлох баримтын хэмжээнд үнэлэх эсэх асуудалтай холбогдон АНУ-ын хувьд хамтарсан мөрдөн байцаалтыг тийм тохиромжтой арга гэж үздэггүй. Европын холбооны хувьд хамтарсан мөрдөн байцаалтын асуудлыг Европын холбооны 2002 оны 06 сарын 13-ны 2002/465ША дугаартай шийдвэрээр зохицуулж өгсөн байна.

Алхам-1. Аль болох эртнээс, тогтмол холбоотой ажиллахыг эрмэлзэх

Давхар шийтгэхээс зайлсхийх, хөрөнгийг тараах, бусниулахаас сэргийлэх зорилгоор аль болох эртнээс, тогтмол холбоотой байж хамтран ажиллахыг эрмэлзэх нь зүйтэй. Талууд мөрдөн шалгах ажиллагаа болон хууль зүйн стратеги харилцан нэгтгэж, өөр өөрийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн фактууд гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгаж тогтооно. (өөрөөр хэлбэл, мөнгө угаах болон суурь гэмт хэргийн хувьд).

Аль болох эртнээс, тогтмол холбогдож хамтран ажиллах нь нэг хэрэгт зэрэг

шийтгэл оногдуулахаас зайлсхийх боломжоор хангаж байдаг. Түүнээс гадна эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа доголдоход хамтарсан мөрдөн байцаалтанд холбогдуулан шалгаж байгаа гэмт этгээдийн хувьд ашигтайгаар эргэх, хөрөнгийг тараах, бусниулах эрсдэлийг дагуулж болно. Тиймээс талуудын эрх бүхий байгууллагууд нягт уялдаа холбоотой байж, мөрдөн шалгах ажиллагаа болон хууль зүйн стратегийн талаар харилцан зөвлөлдөж байх хэрэгтэй.

Алхам-2. Нотлох баримтыг цуглуулах болон мөрдөн шалгах ажиллагааны гол алхмуудаа урьдчилан хэлэлцэх

Хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны үед сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлсээс зайлсхийхийн тулд нотлох баримтуудыг цуглуулах болон мөрдөн шалгах ажиллагааны гол алхмуудыг (үзлэг хийх зэрэг) урьдчилан хэлэлцэх шаардлагатай.

Дээр дурдсанчлан хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа үед мөрдөн байцаалтын стратеги, нотлох баримтуудыг цуглуулах зорилгоор хийгдэх алхмуудыг тодорхойлж, тогтмол мэдээлэл солилцож хамтран ажиллах нь нэг хэрэгт хоёр тал ял шийтгэл давхардуулан оногдуулахаас зайлсхийх ач холбогдолтой. Гол нь мөрдөн байцаалтын ямар арга хэмжээг хэзээ авах гэж байгаа талаархи мэдээллийг цаг хугацаанд нь солилцож, зөвлөлдөж байх нь чухал байна.

Алхам-3. Хэргийн мэдээллийг задруулахгүй байх, нотлох баримтын талаарх бусад дүрэм, журмыг баримтлах

Хамтарсан болон зэрэгцсэн мөрдөн шалгах ажиллагааны үед хэргийн мэдээллийг задруулахгүй байх, нотлох баримтын талаарх бусад дүрэм, журмыг баримтлах шаардлагатай. Талууд хамтарсан болон зэрэгцсэн мөрдөн шалгах ажиллагааны хууль зүйн болон практик үр нөлөөг тооцоолж, хэргийн мэдээллийг хамгаалах, нотлохбаримтын талаар баримтлах бусад дүрэм, журмыг авч үзэх хэрэгтэй.

Цаашилбал хэрэв хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар тохиролцсон бол талууд хамтарсан мөрдөх багийн ерөнхий зорилго, зорилт, чиглэлийг урьдчилан тохиролцоно. (Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж болно). Мөрдөн шалгах ажиллагааны гол алхмуудыг хамтран гүйцэтгэнэ. Зэрэгцсэн мөрдөн шалгах ажиллагааны үед ч мөн адил дээрх асуудлууд хөндөгдөх бөгөөд талуудын байнгын холбоотой ажиллагааг шаардаж байдаг.

Эцэст нь талууд хангалттай эх сурвалж, холбогдох сургалт, мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ, итгэлцэлтэй байх нь хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны баг гарган ажиллахаас өмнө хийгдсэн байх шаардлагатай байдаг.

4.9. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөл

Хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч талуудын хооронд эрх зүйн туслалцааны хүсэлтийг төсөл хэлбэрээр солилцон бүхий л шаардлагууд хангагдсан эсэхийг шалгана.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх ажиллагаа нь хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч талын аль алины дотоодын хууль тогтоомжинд нийцсэн байна. Олон улсын конвенцуудээр ихэнхдээ эрх зүйн туслалцааны хүсэлтэд тавигдах стандарт шаардлагуудыг зохицуулсан байдаг бол тодорхой процесс болон хууль зүйн элементүүд нь улс орнуудын хувьд харилцан адилгүй байдаг байна.

Мөн эрх зүйн туслалцааны хүсэлтийн хэл, агуулга, хэлбэр, мөн нотолгооны стандартууд улс бүрт ялгаатай байдаг. Эцэст нь нэг оронд гарсан гэмт хэрэг өөр оронд гэмт хэрэгт тооцогддоггүй нь хүндрэл үүсгэж байдаг бөгөөд харилцан гэмт хэрэгт тооцсон байх шаардлага нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх гол нөхцөл болно.

Харилцаж буй талууд эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөл боловсруулахдаа дээрх мэдээллээс гадна шаардлагатай тохиолдолд ямар нэг удирдамж, тусгайлсан мэдээллийн талаар ойлголттой байх хэрэгтэй.

Харилцаж буй талууд хоорондоо эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнө холбоо барьж нөгөө талын стандарт болон тохиромжтой шаардлагыг шалгаж, тодорхой түвшинд харилцан итгэлцэл болон ойлголцол бий болгож, эрх зүйн туслалцааны болон хөрөнгө буцаах процессын үр дүнг бүхэлд нь нэмэгдүүлэх хэрэгтэй. Урьдчилж холбоо барьснаар ихэнхдээ авах арга хэмжээг хамгийн сайн тодорхойлдог ба тодорхой хэргүүд дээр эрх зүйн туслалцааны хүсэлтийг албан ёсны сувгаар хүргүүлэхээс өмнө төслийг нь хоорондоо ярилцах хэрэгтэй.

Урьдчилж холбоо барих нь илүү сайн стратегийг боловсруулах бололцоог олгоно. Хүсэлт авагч тал нь хүсэлт илгээгч талд эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхэд гарч болох хүндрэл болон бэрхшээлийн талаар сэрэмжлүүлж болох ба хөрөнгө буцаах ажлыг гүйцэтгэхэд илүү сайн туслалцаа үзүүпнэ.

Урьдчилж холбоо барих нь хүсэлт хүлээн авагч талд хүсэлт илгээгч талын эрүүгийн хэрэгт явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагааны онцлог байдлыг мэдэрч, ойлгох бололцоо олгодог ба тухайн хүсэлтийн ач холбогдол болон яаралтай эсэх, албан ёсоор хүргүүлэхээс өмнө урьдчилж хүсэлтийг хянуулах хугацаа байгаа эсэх зэргийг тодорхойлно.

Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны онцлог байдлыг тодорхойлоход, тухайн хэргийн ноцтой байдал, хөрөнгийн үнэ цэнэ, мөрдөн шалгах ажиллагааны үе шат болон нийтийн ашиг сонирхлыг анхаарах хэрэгтэй.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг хүсэлт хүлээн авагч тал урьдчилж хянаснаар үнэт цаг хугацаа болон нөөц бололцоог хэмнэж, хүсэлт илгээгч талд эрх зүйн туслалцааны хүсэлтийг эрүүгийн хэргийг үргэлжлүүлэн шалгахад үр дүнтэй стратегийн хэрэгсэл болгон ашиглах бололцоог олгоно.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг хүсэлт хүлээн авагч тал шалгах шаардлагагүй тохиолдолд, хүсэлт илгээгч талын эрх бүхий төв байгууллага нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг хянана. Хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч талууд нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн гүйцэтгэлийг яаралтай хангуулахын тулд үе дотооддоо гарч байгаа процессын ажиллагааны талаар үе шат бүрт зөвлөлдөж ажиллах хэрэгтэй.

Холбогдох талууд нь хоорондоо хөрөнгө буцаах ажиллагааны бүхий л үе шатанд байнга холбогдож хамтран ажиллах хэрэгтэй бөгөөд эрх зүйн туслалцааны хүсэлтийг албан ёсоор илгээж хүсэлтийг хүлээн авч зөвшөөрсний дараа ч мөн холбоотой ажиллах нь чухал юм. Хүсэлт илгээгч тал нь ихэнхдээ хэргийг шуурхай шийдвэрлэх шаардлагатай холбоотойгоор нэлээд дарамттай байдаг ба хүсэлт хүлээн авагч талтай тогтмол холбоотой байснаар хүсэлтийг гүйцэтгэх хугацааны талаар бодитой ойлголт авна. Энэ үе шатанд байнга холбоотой байснаар холбогдох талуудад ажиллагааны явцад саад үүсэхээс урьдчилан сэргийлэх боломжийг олгоно. Холбогдох талуудын хоорондын үргэлжилсэн харилцаа холбоо нь хүсэлтийг хэрэгжүүлэхэд дараагийн үйл ажиллагааг урьдчилж төлөвлөх бололцоог олгож байдаг. Тухайлбал: Нэмэлт эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг боловсруулах г.м.

Алхам-1. Эрхзүйн туслалцааны хүсэлтийг илгээх сувгийг тодорхойлох

Хүсэлтийн хүлээн авах талыг тодорхойлох. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг боловсруулахад бэлэн загвар, удирдамж гэх мэт боломжит хэрэгслийг ашиглах хэрэгтэй. Боломжтой тохиолдолд, эрх зүйн туслалцааны хүсэлтийн

төслийг эхний шатанд дотоодын эрх бүхий төв байгууллагад хянуулна.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг илгээхээс өмнө хүсэлт илгээж буй тал нь хүсэлт хүлээн авах талын эрх бүхий төв байгууллага, эсхүл холбоо барих хүнтэй холбогдож, хүсэлт хүлээн авах талын хууль зүйн болон процессын шаардлагуудыг ойлгох хэрэгтэй. Урьдчилсан харилцаа холбоо нь хүсэлт хүлээн авах талын шаардлагуудыг ойлголцохоос гадна, эрх бүхий байгууллагад цаашид холбоо барих үүрэг бүхий хүнийг тогтоох давуу талтай.

Хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий байгууллагатай /холбоо барих цэг/ эрх зүйн туслалцааны хүсэлтийг хянаж, дэмжлэг үзүүлэх боломжтой эсэхийг хэлэлцэнэ. Боломжгүй тохиолдолд, эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг хүсэлт хүлээн авагч талын гаргасан заавар, удирдамжийн дагуу боловсруулна.

Хүсэлт хүлээн авагч талын боловсруулсан эрх зүйн туслалцааны хүсэлтийн заавар, холбоо барих цэгийн өгсөн мэдээллийг судлана. Энэ нь хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч талуудад эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх хугацаанд тохиолдож болох бодит бэрхшээлийг тодорхойлох, тэдгээрийг багасгаж гацалт үүсэх шалтгааныг багасгах бололцоог олгоно.

Харилцагч талуудын хооронд харилцаа холбоо үүсгэх оролдлого амжилтгүй болсон тохиолдолд, тэд бусад арга замаар харилцаа холбоо тогтоох талаар судлах хэрэгтэй, тэдгээр талуудын өмнө нь аль хэдийнээ ажил хэргийн холбоо тогтоосон гуравдагч талууд, удирдамж 6-д дурдсан гадаадын талууд дамжуулан холбоо тогтоож болно.

Алхам-2. Хүсэлт хүлээн авагч талтай эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийн талаар зөвлөлдөх

Хүсэлтийг яаралтай гүйцэтгэх шаардлага, орчуулгын шаардлагууд, мэдээллийг хуваалцах, ашиглах журам зэрэг хязгаарлалтыг тооцоолох хэрэгтэй. Хүсэлт хүлээн авагч талын зөвлөгөө нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүргүүлэхэд хуулийн заалтууд болон хүсэлтийг зайлшгүй илгээхэд тохиромжтой байдлын талаар байна.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөл боловсруулах үе шатанд хүсэлт хүлээн авагч талын хууль зүй болон практикийн талаар ойлголттой болсон байх, эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхээс өмнө холбоо барих хүнээс аливаа асуух, тодруулах зүйлээ мэдэж авах хэрэгтэй.

Хүсэлт илгээгч тал нь хүлээн авсан мэдээлэлдээ, эсхүл агуулга /талуудад гэмт хэрэгт тооцдог эсэх асуудал/, хэл, хэлбэр, нотолгооны стандарт зэрэг нээлттэй мэдээлэлд тулгуурлан эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг

боловсруулна. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөлд нэмэлтээр тухайн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны хязгаарлалтууд, мөн сэжигтэн цагдан хоригдож байгаа эсэхийг тодорхой болгох хэрэгтэй. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг хянуулахдаа аливаа хэлбэрээр албан ёсны хүсэлт илгээхийн өмнө байх хэрэгтэй.

Хүсэлт хүлээн авагч тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөлд шуурхай дүгнэлт хийж, хүсэлт илгээгч талд бичгэн хэлбэрээр санал, дүгнэлт хүргүүлэх, эсхүл эрх зүйн туслалцааны хүсэлтийг өөрчлөх, засварлахад шаардлагатай нэмэлт мэдээлэл яагаад шаардагдаж байгааг тайлбарлана. Эдгээр санал, дүгнэлтүүд ерөнхий, эсхүл онолын хувьд гаргаж байгаа бус харин тодорхой эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг хянаж, дүгнэлт хийсэн гэдэг утгаараа чухал ач холбогдолтой.

Алхам-3. Бүхий л холбоотой мэдээллийг багтаах

Хүсэлт илгээгч болон хүсэлт хүлээн авагч эрх бүхий байгууллага, хүсэлтийн зорилго, хуулийн зүйл заалт /шийтгэлийн дээд хэмжээг бичих/ зэргийн талаарх нарийн мэдээлэл багтана. Гэмт үйлдэл болон тухайн хөрөнгийн хоорондын холбооны талаарх үйл баримт, нарийн мэдээллүүд, шалтгаант холбоо зэргийг, мөн хүсч байгаа туслалцааны төрлийг бичнэ. Бүхий л нууцлалын шаардлагыг анхаарах. Яаралтай гүйцэтгэх шаардлагатай байгаа шалтгааныг зааж өгөх/ шүүхийн тов болон тодорхой хязгаарлалтууд гэх мэт/.

Хүсэлт илгээгч тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөлд дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:

1. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн эрх зүйн үндэслэл,
2. Хүсэлт илгээж буй эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал, холбоо барих мэдээлэл, холбогдож болох хэл,
3. Хүсэлтийг биелүүлэхтэй холбоотой хуулийн заалт, зөвлөмж,
4. Мөрдөн шалгах ажиллагаанд байгаа гэмт хэргийн талаарх хуулийн заалт,
5. Хэрэгт холбогдуулан шалгаж байгаа хүмүүсийн нэр болон хувийн байдал,
6. Хэргийн факт, үйл баримтуудыг дурдах,
7. Хүсч буй туслалцааны талаар,
8. Дагаж мөрдөх процессууд,

Мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэргийг анхаарч, хүсэлт тавьж буй эрх бүхий байгууллага нь холбоо барих хүнтэй энэхүү үйлдлийг нь 2 талд гэмт хэрэгт тооцдог эсэхийг нь тодорхойлсноор хүсэлт хүлээн авагч тал нь тухайн хүсэлтийг гүйцэтгэх боломжтой болно.

Эрх зүйн туслалцааны хүсэлтэд хэргийн факт, үйл баримтын талаарх хураангуй мэдээллүүдийг дурдахдаа тэдгээр нь хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүмүүс, үйлдэгдсэн байж болох гэмт хэрэг болон хүсэлтийг хүлээн авч гүйцэтгэж байгаа талын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгө, эсхүл нотлох баримтуудтай ямар холбоотой болохыг тайлбарлаж өгөх шаардлагатай.

Эрх зүйн туслалцааны хүсэлтээр хүсч буй туслалцааны хувьд хүсэлт нь маш тодорхой, нарийвчилсан байх шаардлагатай. Хүсэлт илгээгч эрх бүхий байгууллага нь хүсэлт хүлээн авч байгаа талтай холбоо барьж, эрэлхийлж байгаа туслалцааг хэрхэн зөв илэрхийлэх талаар судлах хэрэгтэй.

Хүсэлт илгээгч талын эрх бүхий байгууллага нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн төсөлд хүсэлт хүлээн авагч талаас ирүүлсэн процессын болон бусад хууль зүйн шаардлагын талаарх дүгнэлтийн дагуу шуурхай өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Асуудлуудыг хэвээр нь үлдээх, эсхүл хүсэлт илгээгч тал нь хүсэлт хүлээн авагч талын төслийг хянаж гаргасан дүгнэлтийн дагуу тодорхой бэрхшээлүүдийн талаар утсаар холбогдох, төслөө дахин солилцох зэргээр албан бусаархэлэлцэх хэрэгтэй. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн төслийг нь шаардлагатай стандартыг хангах хүртэл солилцох хэрэгтэй.

Алхам-4. Хүсэлт авсны дараах харилцаа холбоо

Хүсэлтийг хүлээн авч байгаа тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүлээн авсны дараа энэ талаар шуурхай мэдэгдэх бөгөөд аливаа асуудал болон нэмэлт мэдээлэл шаардлагатай бол даруй мэдээлнэ. Боломжтой бол холбогдох эрх бүхий байгууллагууд хоорондоо шууд харилцаа холбоо тогтоож болно. Хүсэлт илгээгч тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах үед тогтмол мэдээлэл өгч ажилладаг бол хүсэлт хүлээн авагч тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн гүйцэтгэлийн явц байдлын талаар мэдэгдэж ажиллах хэрэгтэй байдаг.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг хянаж хүлээн авсны дараа, хүсэлт илгээгч талд эрх зүйн туслалцааны хүсэлтийн явц байдлын талаар мэдээлэл өгөх асуудлыг хүсэлт хүлээн авсан тал хариуцна. Хүсэлт илгээгч тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх хүнтэй холбогдох нь хүсэлтэнд дурдсан нэр томъёо, орчуулгын асуудлыг тодруулах бололцоо олгоно. Холбогдох талууд нь эрх зүйн туслалцааны хүсэлтийн гүйцэтгэлийн талаар бүхий л явц байдлыг байнга мэдэгдэх нь чухал ач холбогдолтой, энэ нь тухайн хүсэлтийг хэрэгжүүлэхэд үүсэх саадыг урьдчилж харах бололцоог олгоно.

Хэрэв боломжтой бол хүсэлт хүлээн авсан тал нь хүсэлтийн гүйцэтгэлийн

материалыг бүрэн хэмжээгээр, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэсэн гүйцэтгэлийг аль болох богино хугацаанд хүсэлтийг илгээсэн талд шилжүүлэн өгөх хэрэгтэй. Хүсэлтийн зарим хэсгийг нь болон бүрэн гүйцэтгэлийн талаар талууд хоорондоо байнга харилцах хэрэгтэй. Ялангуяа, хүсэлт илгээсэн тал нь тухайн гүйцэтгэж илгээсэн материалын чанарын талаар мэдэгдэх хэрэгтэй. Талуудын хооронд харилцаа холбоо хэр хүчтэй байна, тэр хэрээр хамтран ажиллахад амар байж, цаашид шаардлагагүй, эсхүл хамааралгүй хүсэлтүүд гарах тохиолдолд үр дүнтэйгээр шийдвэрлэж хамтран ажиллахад дөхөмтэй байдаг.

4.10. Эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэх

Хүсэлтийг хүлээн авсан тал нь хүсэлтийг яаралтай гүйцэтгэх зорилгоор хүсэлтийг төслөөр хянан үзсэний дараа илгээхийг зөвшөөрч байгаа талаар хүсэлт хүлээн авагч тал мэдэгдсэний дараа, хүсэлтийг илгээгч тал нь эрх зүйн туслалцааны хүсэлтийг нэн даруй илгээн хүргүүлнэ.

Хүсэлтийг хүлээн авагч тал нь хүсэлтийг хүлээн авмагц гүйцэтгэх асуудлыг яаралтай эхлүүлнэ. Мөн хүсэлтийг илгээсэн талд хүсэлтийн гүйцэтгэл ямар шатандаа явж байгаа талаарх мэдээллийг байнга өгч байна.

Хүсэлтийг гүйцэтгэх явцад тухайн улсад хамааралгүй буюу өөр улсад хийгдэх ажиллагаа байна гэж үзвэл хийгдэх ажиллагааны хүрээг хязгаарлаж энэ талаар хүсэлтийг илгээгч талд мэдээлнэ

Хүсэлтийг илгээгч болон хүлээн авагч талууд нэг хэрэг дээр өөр өөрсдийн нүгэг дэвсгэрт дотоодын хууль тогтоомжийн дагуу зэрэгцэн ажиллагаа хийж болно. Ийм ажиллагааны үр дүн нь талуудын гүйцэтгэх үйл ажиллагааны хүрээг тодорхойлоход нөлөөлөх боломжтой. Тиймээс талууд харилцан мэдээллийг тогтмол солилцон нэгдсэн дүгнэлттэй ажиллах нь чухал. Нэг талд гаргасан үр дүн, дүгнэлт нь нөгөө талын хувьд чухал бөгөөд дараагийн сөрөг үр дүн гарахаас сэргийлэх нөхцөл болж болно.

Ялангуяа заавал шүүхийн шийтгэх тогтоолын дагуу шийтгэл оногдуулахыг шаардахгүй хэргийн хувьд хөрөнгө буцаах ажиллагааг ямар арга замаар хийх вэ гэдэг аргуудыг сүүлийн жилүүдэд улс орнууд эрэлхийлж байна. Тухайлбал: ял наймаалцах, эсхүл яллах ажиллагааг хойшлуулах болон шүүхийн өмнөх шатанд хураан авах ажиллагаа хийх гэх мэт.

Эдгээр аргуудыг сэжигтэн этгээд тухайн хураан авах хөрөнгөтэй холбоотой болох нь тогтоогдож, буруугаа хүлээсэн тохиолдолд нууцлалын түвшинд

тохиролцсоны үндсэнд хийгдэх боломжтой. Гэхдээ хөрөнгийг буцаан олгож байгаа талын хувьд энэ нь нэлээд хүндрэлтэй байдаг. Харилцан тохиролцсоны дагуу тухайн аль нэг талд эрх зүйн туслалцаа хүсэх маягаар, эсхүл мэдээлэл болон нотлох баримтаар хангах зэргээр туслалцаа үзүүлэх боломжтой.

Мөн түүнчлэн, шүүхийн өмнөх шатанд хураан авах ажиллагааны талаар улс орнууд харилцан адилгүй бодлого баримтлан ажиллаж байна. Зарим оронд мөрдөн шалгах ажиллагааны үед энэ ажиллагааг дэмждэг байхад нөгөө оронд үүнийг хязгаарладаг байна. Хэдийгээр хоёр орон хоёулаа шүүхийн өмнөх шатанд хөрөнгө хураан авах талаар хуулиар зохицуулсан зохицуулалттай байсан ч нотлогооны шаардлагын хувьд өөр өөр байж болно. Энэ нь мөн шүүхээс шийдвэр гаргах процесст ч хамааралтай байна. Мөн шүүхийн өмнөх шатанд хөрөнгө хураах талаар шийдвэр гарсан байлаа гэж бодоход түүнийг өөр улсад хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг нь бас өөр асуудалд болж хувирдаг.

Алхам-1. Хүсэлтийг яаралтай гүйцэтгэх арга хэмжээ авах

Хүсэлт илгээсэн талын урьдчилан мэдэгдсэний дагуу хүсэлтийг хэсэгчлэн гүйцэтгэх боломжтой бөгөөд хүсэлтийг бүрэн гүйцэтгэхийн тулд боломжит бүх арга хэмжээг яаралтай авах нь хүсэлт хүлээн авагч талын үүрэг байдаг.

Эрх зүйн туслалцааны хүсэлтийг төслийн шатанд нь хянан үзэж, тайлбар авсны дараа хүсэлт хүлээн авагч талд илгээх нь зүйтэй. Эдгээр ажиллагааг хийснээр цаг хугацаа хэмнэгдэх, хүсэлтийг албан ёсоор хүлээн авмагц яаралтай гүйцэтгүүлэх боломжийг ихэсгэдэг бөгөөд боловсруулахаас эхлэн илгээх хүртэл холбогдон ажиллах нь чухал юм.

Хүсэлтийг гүйцэтгэхтэй холбоотой шаардлагуудыг эрх зүйн туслалцааны хүсэлт нь хангаагүй тохиолдолд хүсэлтийг хүлээн авсан тал нь ямар саад бэрхшээл үүссэн, мэдээлэл дутуу байгаа (жишээлбэл, давхар шийтгэхгүй байх талаар) талаар нөгөө талдаа нэн даруй илэрхийлэх ёстой.

Хүсэлттэй холбогдуулан тодруулах явдал нь хүсэлтийг гүйцэтгэхээс татгалзаж байгаа хэрэг биш, харин хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж, түүний хүрээг өргөсгөж байгаа хэлбэр байдаг.

Хүсэлтийг гүйцэтгэхэд саад болохуйц (эсхүл хүсэлтийг огт гүйцэтгэх боломжгүй) зүйлүүдийн талаар хүсэлтийг илгээсэн талд даруй мэдэгдэж, талууд хамтран ажиллах шаардлагатай байдаг.

Эрх зүйн туслалцааны хүсэлт нь аль болох тодорхой бичигдсэн, хүсч байгаа туслалцаа нь эрэмбэлэгдсэн байх хэрэгтэй. Тухайлбал: шилжүүлгийн талаар тодруулахаас өмнө эхлээд банкны хуулгыг сар сараар нь авах гэх мэт.

Хүсэлтийг хүлээн авсан тал нь хүсэлтийг гүйцэтгэх явцад цугларсан баримтыг хэсэгчлэн илгээж болно. Энэ нь тухайн хүсэлтийг илгээсэн талд хийгдэж байгаа процесс ажиллагаанд дэмжлэг болж байдаг.

Хүсэлтийг хэсэгчлэн, яаралтай гүйцэтгэх шаардлага хэрэгцээтэй байгаа талаар эрх зүйн туслалцааны хүсэлтэд тодорхой дурдсан байх шаардлагатай ба энэ талаар мөн холбооны бүх хэрэгслийг ашиглан нөгөө талдаа мэдэгдэнэ.

Цаг хугацааны хязгаар яаралтай хийж гүйцэтгэх ямар хэрэгцээ шаардлага үүсээд байгаа, эсхүл ямар арга хэмжээг нэн тэргүүнд авах гэх мэт шаардсан ажиллагаануудыг хүсэлт илгээж гүйцэтгүүлэхээс өмнө сайтар тооцоолсон байна. Мөн зардал гарах ажиллагаанууд болон хүсэлтийн хууль зүйн үндэслэлийг сайтар тодорхойлсон байна.

Алхам-2. Удааширсан ажиллагааны үед авах стратеги

Хүсэлтийг түргэн хугацаанд гүйцэтгэхэд учирч болох саадын талаар хүсэлт хүлээн авагч талтай хэлэлцэж, байнгын холбоотой байх нь чухал ба хэд хэдэн ижил төрлийн хэрэгт нэг хүсэлтээр хэд хэдэн туслалцаа хүсч байгаа тохиолдолд стратегийн талаар талууд хэргийн нөхцөл байдал, түүнд гарах өөрчлөлтийн талаар нэлээд нухацтайгаар хэлэлцэх хэрэгтэй.

Хүсэлт хүлээн авсан тал нь тухайн хүсэлтийг гүйцэтгэхэд удаашралтай байгаа талаар хүсэлт илгээгч талд нэн даруй мэдээлэх ёстой бөгөөд удаашруулж байгаа шалтгааныг арилгах талаар талууд хэлэлцэн, түүнийг арилгах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох учиртай. Хүсэлт илгээж байгаа болон хүлээн авч байгаа талууд тухайн хэрэгтэй холбогдуулан нэн тэргүүнд тавигдах шалгууруудыг тогтоож өгөх нь зүйтэй. Тухайлбал: Сэжигтнээр баривчлах, хөрөнгө, орлого үрэгдэх эрсдэл, цаг хугацааны хязгаар өөрөөр хэлбэл хуулиар тогтоосон хугацааны талаар эрх зүйн туслалцааны хүсэлтээр тавигдаж байгаа асуудлууд зэрэг.

Алхам - 3. Зөвлөлдөх асуудлаа тодорхойлох

Талууд хэргийн талаар хүрч байгаа дүгнэлт, гэм буруугийн асуудал зэргийн талаар шуурхай мэдээлэл солилцож ажиллана.

Эрх зүйн туслалцааны хүсэлттэй холбоотой бүх үеийг оролцуулан мөрдөн шалгах ажиллагааны бүх үе шатанд талууд харилцан уулзалт зохион байгуулах, холбогдож байх хэрэгтэй. Энэ нь нөхцөл байдлыг тухай бүр үнэлж, стратегийг шинэчлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоход ач холбогдолтой байна.

Дотоодын хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа ажиллагааг зогсоохоор

шийдвэрлэж байгаа тохиолдолд харилцаа, холбооны тодорхой сувгийг ашиглан талууд харилцан зөвшилцөж болно. Энэ тохиолдолд талууд гаргах шийдвэрийн үр дагаварыг сайтар ойлгож, энэ нь хөрөнгө буцаан олгох ажиллагааг хийх гэж байгаа талын үйл ажиллагаанд саад болохооргүй байхыг тооцоолсон байх хэрэгтэй. Хэрэв тийнхүү саад болохуй шинжтэй бол аль болох уян хатан шийдвэрлэх боломжтой гарцыг судлах шаардлагатай. Боломжтой бол тухайн хэрэгт холбогдуулан шалгаж байгаа хүнтэй тохиролцох гэрээ байгуулах маягаар ажиллаж болно.

Тухайн ижил фактын талаар хэд хэдэн улсад мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа бөгөөд аль нэг улсад тухайн хэргийг яллах боломжтой байгаа тохиодолд нөгөө улсад явагдаж байгаа мөрдөн шалгах ажиллагааг зогсоож болох юм. Тиймээс хэд хэдэн улсад зэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа бол аль болох эртнээс дээрх шийдвэрийг аль улсад гаргахыг шийдвэрлэх нь зүйтэй.

Харилцан тохиролцсоны дагуу мөрдөн шалгах ажиллагааг зогсоохын өмнө хөрөнгө буцаах ажиллагаанд ямар нэг саад учруулахгүйгээр шийдвэрлэх, ялангуяа шүүхийн өмнөх шатанд хөрөнгө хураах ажиллагааг аль болох хөндөхгүйгээр шийдэхийн тулд бусад улсуудтайгаа заавал зөвшилцөх ёстой.

Шүүхийн өмнөх шатанд хөрөнгө хураах ажиллагаа хийхдээ зарим оронд нөгөө улстай хоёр талт гэрээ, хэлэлцээр байгуулах замаар системийн ялгаанаас болж гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэх үед учирч болох саадыг арилгаж, хамтран ажилласан байна.

ТАВ: ХАВСРАЛТ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУШААЛ

2019 оны 02 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар А/16

Улаанбаатар
хот

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар батлах тухай

Монгол Улсын Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.6, 48.1.8, 48.1.13 дахь хэсгийн заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны аргачилсан заавар”-ыг нэгдүгээр, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрүүдийн жагсаалт, загвар”-ыг хоёрдугаар, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийн бүтэц, загвар”-ыг гуравдугаар, “Монгол Улсаас эрх зүйн туслалцаа үзүүлэхэд өгөх зөвлөмж”-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал мөрдөгдөх өдрөөс эхлэн Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/96 дугаар тушаалаар баталсан “Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”-ын хорьдугаар бүлгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тушаалаар баталсан заавар, эрх зүйн хэлбэрийн загварыг прокурорын хяналтын болон мөрдөн шалгах ажилд нэг мөр хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэс (О.Алтангэрэл), зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжийн удирдлага, Аймаг, Нийслэл, Тээвэр, Дүүргийн прокурорын газрын болон Сум

дундын Ерөнхий прокурор нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Улсын Ерөнхий прокурорын орлогч (Б.Амгаланбаатар)-д даалгасугай.

5. Энэ тушаалыг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ

М.ЭНХ-АМГАЛАН

Улсын Ерөнхий прокурорын
2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн
А/16 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА
ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ, ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БОЛОН
ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХҮНИЙГ ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ, АВАХ
АЖИЛЛАГААНЫ АРГАЧИЛСАН ЗААВАР**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА**

1.1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1. Энэ аргачилсан зааврын зорилго нь эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн өгөх, авах ажиллагааг зохицуулахад оршино.

2. Прокурорын байгууллага нь эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд эрүүгийн хэргийн талаар дараах эрх зүйн туслалцааг харилцан үзүүлнэ:

2.1. гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргах;

2.2. мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг биелүүлэх;

2.3. хавтаст хэргийн материалыг гадаад улсын холбогдох байгууллагад хүргүүлэх, шилжүүлж авах;

2.4. гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах, өгөх;

2.5. хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, өгөх.

3. Прокурор энэхүү аргачилсан зааврын заалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэгжүүлээгүй зөрчсөн нь хариуцлага тооцох үндэслэл болно.

1.2 дугаар зүйл. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаанд баримтлах эх сурвалж

1. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа нь Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай

хууль, олон улсын гэрээ болон Прокурорын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасан харилцан адил байх олон улсын эрх зүйн зарчимд тус тус үндэслэнэ.

2. Харилцан адил байх зарчим гэж тухайн харилцааг зохицуулсан олон улсын гэрээгүй тохиолдолд хүсэлт гаргагч улсаас ижил төрлийн туслалцааг үзүүлэх баталгааг хүсэлт хүлээн авагч талд гаргах дипломат харилцаанд хэрэглэгддэг олон улсын эрх зүйн зарчмыг ойлгоно.

1.3 дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх төв байгууллага

1. Прокурорын тухай хуулийн 26.1 дүгээр зүйлд зааснаар Монгол Улсын Ерөнхий прокурорын газар нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх төв байгууллага болно.

2. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн болон хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх хүсэлтийг хүлээн авч, гүйцэтгүүлэх, биелэлтэд хяналт тавих, холбогдох байгууллагад уламжлах ажиллагааг Улсын Ерөнхий прокурорын газар хариуцна.

3. Улсын Ерөнхий прокурорын газраар дамжуулахгүйгээр гадаад улсын эрх бүхий байгууллага, албан тушаалтан, алба хаагчдад эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрүүгийн хэргээс нотлох баримт өгөхийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ГАДААД УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУХАЙ ХҮСЭЛТ

2.1 дүгээр зүйл. Гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргах

1. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг илгээхээс өмнө шаардлагатай мэдээллийг нээлттэй эх сурвалж, мэдээлэл солилцох албан бус сүлжээ болон ижил түвшний байгууллага хоорондын хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр, санамж бичигт үндэслэж цуглуулсан байна.

2. Эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхээс өмнө тухайн улсын хууль тогтоомж, хүсэлт боловсруулахад тавигдах шаардлагын талаар хүсэлт хүлээн авах улсын эрх бүхий байгууллага, албан тушаалтантай мэдээлэл солилцож болно.

3. Гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах тухай хүсэлтийг хууль, олон улсын гэрээ шаардлагатай тохиолдолд хүсэлт хүлээн авагч улсын хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн үйлдэнэ.

4. Хүсэлтэд дараах зүйлийг тусгана:

- 4.1. хүсэлт гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг;
- 4.2. хүсэлт хүлээн авах улсын эрх бүхий байгууллагын нэр, хаяг;
- 4.3. хэргийн товч утга, учирсан хохирол, хор уршгийн талаарх мэдээлэл;
- 4.4. хүсэлтийн товч агуулга;
- 4.5. эрх зүйн туслалцаа үзүүлэх хууль, эрх зүйн үндэслэл;
- 4.6. эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдийн талаарх мэдээлэл;
- 4.7. хэргийн зүйлчлэл, ял шийтгэлийн мэдээлэл;
- 4.8. мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон нөхцөл байдал, холбогдох баримт;
- 4.9. эрх зүйн туслалцаа авах шаардлага, зорилго;
- 4.10. хүсэлт болгож буй мөрдөн шалгах тодорхой ажиллагаа;
- 4.11. шаардлагатай бол мөрдөн шалгах тодорхой ажиллагааг гүйцэтгэхэд баримтлах хуулийн шаардлага, хүсэлтийг гүйцэтгэх дараалал;
- 4.12. хүсэлтэд заасан хувь хүн, хуулийн этгээдийн мэдээлэл /овог, нэр, нас хүйс, төрсөн огноо, иргэний харьяалал, паспортын дугаар, эрхэлсэн ажил, байнга болон түр оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаар, цахим хаяг, фото зураг, хурууны хээ, хуулийн этгээдийн нэр, хаяг, холбогдох бусад мэдээлэл/;
- 4.13. хүсэлт, түүнд агуулагдаж байгаа мэдээллийг нууцлах шаардлагатай бол энэ тухай үндэслэлээ тайлбарлаж, бусдад задруулахгүй ажиллах тухай санамж;
- 4.14. хууль зүйн баталгаа;
- 4.15. хүсэлтийг шуурхай гүйцэтгэх шаардлагатай бол энэ тухай үндэслэлээ тайлбарлаж, хугацааг заана.

5. Хүсэлтэд Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээллийг тусгах, хавсаргахыг хориглоно.

6. Эрх бүхий албан тушаалтны шийдвэр /мөрдөгч, прокурорын тогтоол, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол/, үүнтэй холбоотой хуулийн зүйл, заалтыг тайлбарлаж хүсэлтэд хавсаргана.

7. Хүсэлт, түүнд хавсаргаж байгаа баримт бичиг, нотлох баримтыг байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулж, хуудсыг үдэж дугаарлан, албан

ёсны орчуулгын хамт битүүмжилнэ.

8. Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь /цаашид “Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс” гэх/ харьяа прокурорын газраар дамжин ирсэн хүсэлтийг хүлээн авч, хянана.

2.2 дугаар зүйл. Хүсэлт боловсруулахад анхаарах асуудал

1. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг боловсруулахад дараах асуудлыг анхаарна:

- 1.1. хууль, олон улсын гэрээ, зааврын шаардлагын дагуу үйлдэх;
- 1.2. хийгдэх ажиллагааг бүрэн тусгах;
- 1.3. хүсэлт болгож буй ажиллагаа нь хэрэгт ач холбогдолтой байх;
- 1.4. утга найруулгын алдаагүй, богино, энгийн ойлгомжтой өгүүлбэр сонгож бичих;
- 1.5. шаардлагатай нотлох баримт, мэдээлэл, бичиг баримтыг бүрэн хавсаргах.

2.3 дугаар зүйл. Прокурор хянавал зохих асуудал

1. Прокурор мөрдөгчөөс ирүүлсэн хүсэлтийг хүлээн аваад энэ зааврын 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан асуудлыг бүрэн тусгасан эсэх, хууль, олон улсын гэрээний шаардлагад нийцсэн эсэхийг хянаж, Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст хүргүүлнэ.

2. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүсэлтийг хүлээн авч, хууль, олон улсын гэрээ, энэ зааврын шаардлагыг хангасан тохиолдолд гадаад улсын эрх бүхий байгууллагад уламжилна. Шаардлага хангаагүй хүсэлтийг харьяа прокурорын газарт буцаана.

3. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь Монгол Улсаас гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлсэн хүсэлтийн биелэлтийг хангуулах талаар хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, гадаад улсын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцож хамтран ажиллана.

4. Хүсэлт илгээсэн хэрэгт хяналт тавьж буй прокурор нь тухайн хэрэгт цаашид эрх зүйн туслалцаа авах шаардлагагүй болсон, эрүүгийн хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн, хэрэг бүртгэлийн хэргийг хаасан, хэргийг

хэрэгсэхгүй болгосон бол Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст даруй мэдэгдэнэ.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ.
МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУХАЙ
ГАДААД УЛСЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН
ХҮСЭЛТИЙГ БИЕЛҮҮЛЭХ**

3.1 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг биелүүлэх

1. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хүлээн авч, дараах асуудлыг хянана:

- 1.1. хууль, олон улсын гэрээний шаардлагад нийцсэн эсэх;
- 1.2. хүсэлтийг биелүүлэхээс татгалзах үндэслэл байгаа эсэх;
- 1.3. хүсэлтийг гүйцэтгэхэд нэмэлт баримт, мэдээлэл шаардлагатай эсэх.

2. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс гадаад улсаас ирүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийг хянаад, дараах шийдвэрийг гаргана.

- 2.1. Хүсэлтийг хүлээн авч, гүйцэтгэх хугацаа тогтоох;
- 2.2. Хүсэлтийг биелүүлэхээс татгалзах;

3. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүсэлтийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэхээр хугацаа тогтоонхүргүүлж, биелэлтэд хяналт тавина.

4. Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулахэрх бүхий байгууллагаас хүсэлтийн дагуу явуулах мөрдөх шалгах ажиллагаанд харьяа прокурорын газраас хяналт тавина.

5. Лавлагаа, мэдээлэл, баримт бичиг гаргуулах зэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагагүй хүсэлтийг Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс гүйцэтгэж болно.

6. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь шаардлагатай тохиолдолд хүсэлтийг гүйцэтгэх хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

7. Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад гадаад улсаас шууд ирүүлсэн хүсэлтийг Улсын Ерөнхий прокурорын газарт даруй шилжүүлнэ.

3.2 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болон гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, эд зүйлийг хураах, битүүмжлэх тухай хүсэлтийг биелүүлэх

1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, орлогыг хураан авах, битүүмжлэх, шилжүүлэх тухай гадаад улсаас ирүүлсэн хүсэлтэд эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлэхийг эрмэлзэнэ.

2. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах, битүүмжлэх тухай гадаад улсаас ирүүлсэн хүсэлтийг биелүүлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хураан авах, бэхжүүлэх, хүлээн авах, хадгалах, хамгаалах, шижлүүлэхтэй холбоотой заавар, журмыг баримтлахаас гадна дараах асуудлыг анхаарна.

2.1. эд хөрөнгийн эцсийн өмчлөгч тогтоогдсон эсэх;

2.2. хураах, битүүмжлэх ажиллагаанд гуравдагч этгээдийн эрх ашиг зөрчигдөж байгаа эсэх;

2.3. тусгай тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтын нөхцөл шаардсан хөрөнгө эсэх.

3. Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн эзэмшлийн талаар гуравдагч этгээд маргаан гаргавал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болтол хадгалж, хүсэлт гаргагч улсад мэдэгдэнэ.

4. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг олж тогтоосон даруй хөрөнгийг бусдад арилжаалах, шилжүүлэх, устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор битүүмжлэх, хураан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, дансны гүйлгээг хязгаарлах арга хэмжээг авна.

5. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлогыг гадаад улсад шилжүүлэх, мөн тухайн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үнэлгээ, тээвэрлэлт, засвар үйлчилгээ болон шилжүүлэхтэй холбогдон гарах зайлшгүй зардал зэргийг хэрхэн шийдвэрлэх талаар хүсэлт илгээсэн улсын болон Монгол Улсын эрх бүхий байгууллагатай хууль, олон улсын гэрээнд заасны дагуу Улсын Ерөнхий прокурорт танилцуулж, хэлэлцэн тохиролцож, шийдвэрлэнэ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.
ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫГ
ҮРГЭЛЖЛҮҮЛЭХЭЭР БАРИМТ, МАТЕРИАЛЫГ
ГАДААД УЛСАД ХҮРГҮҮЛЭХ, ГАДААД УЛСААС ИРҮҮЛСЭН
БАРИМТ, МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАХ**

4.1 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр баримт, материалыг гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх

1. Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр хэргийн материалыг гадаад улсад хүргүүлэх тухай мөрдөгчийн санал гаргаж ирүүлсэн хэргийг хүлээн авч, дараах асуудлыг хянана.

1.1. гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэний байгаа газар нь тогтоогдсон эсэх;

1.2. хийгдвэл зохих хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа бүрэн хийгдсэн эсэх;

1.3. гадаад улсын иргэний үйлдсэн гэмт хэрэг тухайн улсад гэмт хэрэгт тооцогдох эсэх;

1.4. хэрэгт Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд харшлах аливаа мэдээ, баримт авагдсан эсэх;

1.5. гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, хураан авсан битүүмжилсэн эд хөрөнгө, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх;

1.6. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдод хэргийн материалыг танилцуулж, гомдол, хүсэлтийг нь бүрэн шийдвэрлэсэн эсэх;

1.7. бусад.

2. Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэс /цаашид “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах хэлтэс” гэх/ хэрэгт хяналт тавьж байгаа прокурорын газрын саналыг үндэслэн хэргийн материалыг гадаад улсад хүргүүлэх эсэхийг хянаж, шийдвэрлэнэ.

3. Прокурорын газар нь харьяалал тогтоолгох саналаа албан бичгээр ирүүлэх ба албан бичигт дараах зүйлийг тусгана:

3.1. гэмт хэрэг гарсан байдал, түүнийг нотолж буй нотлох баримт;

3.2. хэрэг бүртгэлт нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолын он, сар, өдөр, хуулийн зүйл, хэсэг;

3.3. хэрэгт холбогдсон хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

3.4. хэргийг гадаад улсад хүргүүлэх үндэслэл, санал;

3.5. хэрэгт хураасан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйл, эд мөрийн баримт;

3.6. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын гомдол гаргах эрхийг хангасан талаар.

4. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр хэргийн материалыг гадаад улсад хүргүүлэхээр шийдвэрлэсэн бол харьяа прокурорын газар нь мөрдөгчөөр хавтаст хэргийн материалыг хуулбарлуулан, хуулбар хувийг нотариатаар гэрчлүүлж, албан ёсны орчуулгын хамт Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст хүргүүлнэ.

5. Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр баримт, материалыг гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх тухай шийдвэрийг цахим бүртгэлд бүртгэж, хэргийн хэргийн эх хувийг архивт шилжүүлнэ.

6. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хэргийг хүлээн авч, хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

7. Гадаад улсын эрх бүхий байгууллагаас тухайн хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар ирүүлсэн баримтыг хэргийн эх хувьд хавсаргана.

4.2 дугаар зүйл. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр гадаад улсад хүргүүлэх хэрэгт хураагдсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шийдвэрлэх

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр хэргийн материалыг гадаад улсад хүргүүлэхдээ төр, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн, өөр гэмт хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой, эсхүл иргэд, байгууллагын өмчлөл, эзэмшилд хамаарах эд мөрийн баримтаас бусад боломжтой гэж үзсэн эд мөрийн баримт, нотлох баримтыг шилжүүлнэ. Харин хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлогыг хэргийн хамт шилжүүлэхдээ энэ журмын 3.2 дугаар зүйлийн 5-д заасныг баримтална.

2. Хэргийг хүлээн авсан гадаад улсын эрх бүхий байгууллагаас төр, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн, өөр гэмт хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой, эсхүл иргэд, байгууллагын өмчлөл, эзэмшилд хамаарах эд мөрийн баримт, бусад нотлох баримтыг буцаан ирүүлэх тухай баталгаа гаргасан тохиолдолд тухайн улсад түр шилжүүлж болно.

3. Хэргийн материалыг гадаад улсад хүргүүлэх тухай прокурорын

шийдвэрт хэрэгт хураасан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, түүнийг хадгалж байгаа газар, банкны нэр, дансны дугаарыг тодорхой зааж, үргэлжлүүлэн хадгална.

4. Гадаад улсад хүргүүлсэн хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн баримт, шийдвэрийг үндэслэн хураасан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

5. Гадаад улсад хүргүүлсэн хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн улсын эрх бүхий байгууллагаас хариу ирээгүй бол Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсээр дамжуулан тус улсын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцсоны дараа хураасан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шийдвэрлэнэ.

4.3 дугаар зүйл.Гадаад улсаас шилжүүлж ирүүлсэн хэргийг хүлээн авч, мөрдөн шалгах ажиллагаа явуулах

1. Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бөгөөд холбогдох хэргийг нь үргэлжлүүлэн шалгуулахаар гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүлээн авч олон улсын гэрээ, хуулийн шаардлагад нийцсэн эсэхийг хянана.

2. Уг хүсэлт нь олон улсын гэрээ, хуулийн шаардлагад нийцсэн бол хэргийг Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст шилжүүлж, нийцээгүй хүсэлтийг тухайн улсад буцаана.

3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэс угхэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, дугаар олгон, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, түүнд тавих прокурорын хяналтын харьяаллыг тогтооно.

4. Прокурор хэргийг эцэслэн шийдвэрлэсэн даруй Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст мэдэгдэж, шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

5. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь хэргийн шийдвэрлэлтийн талаар тухайн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ.
ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХҮНИЙГ ШИЛЖҮҮЛЭН
ӨГӨХ, АВАХ АЖИЛЛАГАА

5.1 дүгээр зүйл. Улсын Ерөнхий прокурорын шийдвэрээр хийгдэх ажиллагаа

1. Улсын Ерөнхий прокурор өөрийн санаачилгаар, эсхүл холбогдох байгууллагын саналыг үндэслэн дараах асуудлыг шийдвэрлэнэ.

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа гадаад улсад гарсан хүнийг эрэн сурвалжлах;

1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэн гадаад улсад гарсан Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах;

1.3. гэмт хэрэг үйлдсэн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх, шилжүүлэн өгөхөөс татгалзах;

1.4. гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх ажиллагааг хойшлуулах.

5.2 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шилжүүлэн авах зорилгоор байгаа газрыг тогтоолгохоор гадаад улсад эрэн сурвалжлах

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа гадаад улсад гарсан сэжигтэн, яллагдагчийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шилжүүлэн авах зорилгоор байгаа газрыг нь тогтоолгоогоор гадаад улсад эрэн сурвалжлах тухай мөрдөгчийн саналыг хэрэгт хяналт тавьж буй прокурор хүлээн авч хянаад, хэргийн танилцуулга, холбогдох бусад баримтын хамт Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст ирүүлнэ.

2. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь саналын үндэслэлийг хянаж, Улсын Ерөнхий прокурорт даруй танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3. Энэ зүйлд заасан журмыг зөрчиж эрэн сурвалжлах ажиллагаа явуулсан болох нь тогтоогдвол Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс эрэн сурвалжлах ажиллагааг зогсоох арга хэмжээ авна.

5.3 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах

1. Прокурор гадаад улсын нутаг дэвсгэрт эрэн сурвалжлагдаж, хаяг байршил нь тогтоогдсон Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийг хууль, олон гэрээ, хэлэлцээрт заасны дагуу үйлдэн, тухайн хүнийг баривчлах, цагдан

хорих тухай шүүхийн шийдвэр, холбогдох бусад баримт, материал, тэдгээрийн албан ёсны орчуулгын хамт Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст ирүүлнэ.

2. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэнийг гадаад улсаас шилжүүлж авах тухай Улсын Ерөнхий прокурорын шийдвэрийг үндэслэж хүсэлтийг тухайн улсын эрх бүхий байгууллагад уламжилна.

3. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь гадаад улсын эрх бүхий байгууллагаас гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэнийг шилжүүлэн өгөхийг зөвшөөрч, хариу ирүүлсэн тохиолдолд шилжүүлж авах газар, цаг хугацаа, хүлээлцэн авах албан тушаалтнуудын талаар харилцан мэдээлэл солилцоно.

4. Гэмт хэрэг үйлдсэн Монгол Улсын иргэнийг хүлээн авсан албан тушаалтан шилжүүлэн авах ажиллагааны тэмдэглэл үйлдэж, хавтаст хэргийн материалд хавсаргана.

5.4 дүгээр зүйл. Гадаад улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг биелүүлэх

1. Гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүлээн авч дараах асуудлыг хянан, Улсын Ерөнхий прокурорт танилцуулна.

1.1. эрх бүхий байгууллага, албан тушаалтан уламжилсан эсэх;

1.2. Монгол Улсын хууль, олон улсын гэрээний шаардлагад нийцсэн эсэх;

1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа болох нь тогтоогдсон эсэх;

1.4. шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэл байгаа эсэх;

1.5. шилжүүлэн өгөхийг хойшуулах үндэслэл байгаа эсэх.

2. Улсын Ерөнхий прокурор гадаад улсын иргэнийг шилжүүлж өгөх, өгөхөөс татгалзах, шилжүүлэн өгөхийг хойшлуулах эсэхийг шийдвэрлэж, Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс энэ тухай хүсэлт гаргасан улсад мэдэгдэнэ.

3. Улсын Ерөнхий прокурор гадаад улсын иргэнийг шилжүүлэн өгөхөөр шийдвэрлэсэн тохиолдолд Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүсэлтийг гүйцэтгүүлэхээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий

байгууллагад хүргүүлж, биелүүлэх ажиллагаанд хяналт тавина.

4. Шаардлагатай тохиолдолд хүсэлтийг гүйцэтгэж байгаа мөрдөн шалгах ажиллагаа явуулахэрх бүхий байгууллагын харьяа прокурорын газраас ажиллагаанд нь хяналт тавина.

5. Шилжүүлэн өгөх хүний байгаа газрыг олж тогтоосон даруйд түүнийг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу шилжүүлж өгөх хүртэл цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

6. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь хүсэлт гаргасан улсын эрх бүхий байгууллагад гэмт хэрэг үйлдсэн хүнийг цагдан хорьсон тухай болон шилжүүлэн өгөх газар, цаг хугацааг даруй мэдэгдэнэ.

7. Хүсэлт гаргасан улсын эрх бүхий байгууллага заасан хугацаанд тухайн хүнийг шилжүүлж аваагүйгээс шүүхийн шийдвэрээр сулласан бол энэ тухай Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь тус улсад даруй мэдэгдэнэ.

8. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг гадаад улсад шилжүүлэн өгөхдөө түүний гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг болон бусад зүйлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 43.6 дугаар зүйлд заасан журмын дагуу шилжүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.

ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХҮНИЙГ ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ, АВАХ, МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРЭЭР ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

6.1 дүгээр зүйл. Хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэн өгөх

1. Улсын Ерөнхий прокурорын газрын Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст /цаашид “Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс” гэх/ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн Монгол Улсад хорих ял эдэлж байгаа гадаад улсын харьяат иргэний эх орондоо ялаа үргэлжлүүлэн эдлэх тухай бичгээр гаргасан хүсэлтийг Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст уламжлахдаа дараах бичиг баримтыг хавсарган ирүүлнэ.

1.1. хорих ял шийтгүүлсэн хүний хувийн бичиг баримтын баталгаажуулсан хуулбар;

- 1.2. шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоол;
- 1.3. эрүүл мэндийн байдлын талаарх эмчийн тодорхойлолт;
- 1.4. хорих ялын хугацаа, ял шийтгэлийн эдэлж эхэлсэн болон дуусах хугацаа, ялын тооцоо;
- 1.5. зан байдлын болон засрал хүмүүжлийн талаарх хорих ангийн даргын тодорхойлолт;
- 1.6. бусад

2. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хорих ял шийтгүүлсэн хүний хүсэлт, холбогдох материалыг хүлээн авч, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 44.2 дугаар зүйлд заасан шилжлүүлэн өгөхөөс татгалзах үндэслэл байгаа эсэхийг хянаж Улсын Ерөнхий прокурорт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3. Улсын Ерөнхий прокурорын хорих ял шийтгүүлсэн хүнийг харъяат улсад нь шилжүүлэн өгөх шийдвэрийг Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс тухайн хорих ял шийтгүүлсэн хүний харъяалах улсад тус тус мэдэгдэж, хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх өдөр, цаг хугацаа, газрыг тохиролцоно.

4. Шилжүүлэн өгөх ажиллагаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан прокурор байлцаж, хорих ял шийтгүүлсэн хүнийг холбогдох бичиг баримтын хамт хүлээлгэж өгч, тэмдэглэл хөтөлнө.

6.2 дугаар зүйл. Гадаад улсад хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэний ялыг үргэлжлүүлэн эдлүүлэхээр шилжүүлэн авах

1. Гадаад улсад хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо ялаа үргэлжлүүлэн эдлэх тухай хүсэлтийг Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүлээн авч, Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу гүйцэтгэнэ.

2. Улсын Ерөнхий прокурор гадаад улсад хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо ялаа үргэлжлүүлэн эдлэх тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бол энэ тухай шийдвэр, холбогдох бичиг баримтыг Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст шилжүүлнэ.

3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс нь олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах тухай Улсын Ерөнхий прокурорын саналыг

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хүргүүлнэ.

4. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн прокурор хорих ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн ялыг Монгол Улсад үргэлжлүүлэн эдлүүлэх талаарх дүгнэлтээ шүүхэд гаргана.

5. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс нь хорих ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн ялыг Монгол Улсад үргэлжлүүлэн эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр, холбогдох бусад бичиг баримтыг гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлж, уг этгээдийг шилжүүлэн авах цаг хугацаа, газар, уг ажиллагаанд оролцох бүрэлдэхүүний талаар тохиролцож, Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс нь шилжүүлэн авах ажиллагааг зохион байгуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даалгана.

6. Шилжүүлэн өгөх ажиллагаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан прокурор байлцаж, хорих ял шийтгүүлсэн хүнийг холбогдох бичиг баримтын хамт хүлээн авч, тэмдэглэл хөтөлнө.

6.3 дугаар зүйл. Хорих ял шийтгүүлсэн хүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх ажиллагаа

1. Хорих ял шийтгүүлсэн хүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хүлээн авч, Улсын Ерөнхий прокурорт танилцуулна.

2. Улсын Ерөнхий прокурор хорих ял шийтгүүлсэн хүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл олгоно.

3. Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс хорих ял шийтгүүлсэн хүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх тухай Улсын Ерөнхий прокурорын зөвшөөрлийг хүсэлт тавьсан улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэж, Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс уг ажиллагаагааг зохион байгуулах арга хэмжээ авна.

----- оОо -----

Улсын Ерөнхий прокурорын
2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн
А/16 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН
ХЭЛБЭРИЙН ЖАГСААЛТ, ЗАГВАР**

**НЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ХЭЛБЭРИЙН ЖАГСААЛТ**

1. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг хүлээн авч, гүйцэтгэх хугацаа тогтоох тухай /ЭЗТ-1/;
2. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг гүйцэтгэх хугацааг сунгах тухай /ЭЗТ-2/;
3. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг биелүүлэхээс татгалзах тухай /ЭЗТ-3/
4. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад эрэн сурвалжлах тухай /ЭЗТ-4/;
5. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөхөөс татгалзах тухай /ЭЗТ-5/;
6. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай /ЭЗТ-6/;
7. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөх тухай /ЭЗТ-7/;
8. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөхийг хойшлуулах тухай /ЭЗТ-8/
9. Хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэх тухай /ЭЗТ-9/;
10. Хорих ял шийтгүүлсэн хүнийг харъяат улсад нь шилжүүлэн өгөхөөс татгалзах тухай /ЭЗТ-10/;
11. Хорих ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн авах тухай /ЭЗТ-11/;
12. Хорих ял шийтгүүлсэн хүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх тухай /ЭЗТ-12/;
13. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр хавтаст хэргийн материалыг хүргүүлэх тухай /ЭЗТ-13/

----- оОо -----

**ХОЁР. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ХЭЛБЭРИЙН ЗАГВАР**

ЭЗТ-1

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа
харилцан үзүүлэх хүсэлтийг хүлээн авч,
гүйцэтгэх хугацаа тогтоох тухай

..... прокурорын газрын прокурор
би,-ээс
ирүүлсэн эрүүгийн хэргийн талаар эрх зүйн
туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авч танилцаад ОЛСОН нь:
..... /хэргийн утга / хэрэгт зэрэг
ажиллагаа хийлгүүлэхээр хүсэлт болгосон ба хуульд заасан татгалзах үндэслэл
тогтоогдоогүй тул Прокурорын тухай хуулийн 28.4 дүгээр зүйлийг удирдлага
болгон ТОГТООХ нь:

1. улсаас дугаартай хэрэгт ирүүлсэн эрх зүйн
туслалцааны хүсэлтийг хүлээн авч, гүйцэтгэхээр тогтсугай.

2. Хүсэлтийг гүйцэтгэхийг цагдаагийн
байгууллагад даалгасугай.

3. Хүсэлтийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг.....
прокурорын газарт даалгасугай.

4. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтэд
заасан ажиллагааг оны сарын-ны өдрийн дотор хийж гүйцэтгэж
ирүүлсүгэй.

.....ПРОКУРОР (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн
туслалцаа харилцанүзүүлэх хүсэлтийг
гүйцэтгэх хугацааг сунгах тухай

..... прокурорын газрын прокурор
би, мөрдөгч /прокурор/-ээсулсаас
дугаартай эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа авахаар ирүүлсэн хүсэлтийг
гүйцэтгэх хугацааг сунгуулах тухай санал ирүүлснийг оны сарын ... өдөр
хүлээн авч танилцаад ОЛСОН нь:

..... Улсын /байгууллагаас/ /хэргийн
утга/ хэрэгт
..... ажиллагаа хийлгүүлэхээр хүсэлт болгосон ба хүсэлтэд заасан
ажиллагаануудаас
..... хийж
гүйцэтгэсэн, цаашид

.....ажиллагаа явуулах шаардлагатай байх тул Прокурорын тухай хуулийн
28.4 дүгээр зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлтийг
гүйцэтгэх хугацааг оны сарын-ны өдрөөс оны сарын өдрийг
хүртэл хоногоор тогтоосугай.

2. Хүсэлтийг тогтоолд заасан хугацаанд гүйцэтгэж ирүүлэхийг
..... /байгууллага/-ын /албан тушаалтан/-д
даалгасугай.

.....ПРОКУРОР (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа
харилцан үзүүлэх хүсэлтийг биелүүлэхээс
татгалзах тухай

..... прокурорын газрын прокурор
би,
ээс ирүүлсэн эрүүгийн хэргийн талаар
эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авч танилцаад
ОЛСОН нь:

..... /хэргийн утга/ хэрэгт зэрэг
ажиллагаа хийлгүүлэхээр хүсэлт болгосон бахуулийн.....
заасан үндэслэлээр хүсэлтийг биелүүлэх боломжгүй байх тул Эрүүгийн хэрэг
хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.4 дүгээр зүйлийн 4, Прокурорын тухай
хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т дүгээр зүйлийг удирдлага болгон ТОГТООХ
нь:

1. улсаас дугаартай хэрэгт ирүүлсэн эрх зүйн
туслалцааны хүсэлтийг биелүүлэхээс татгалзсугай.
2. Энэ тухай хүсэлтийг ирүүлсэн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдсүгэй.

.....ПРОКУРОР (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг гадаад улсад
эрэн сурвалжлах тухай

Улсын Ерөнхий прокурор би, оны сарын-ны өдөр Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн дугаар зүйлийн дэх хэсгээр хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн /эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан/ дугаартай хэрэгт Монгол улсын иргэн.....овогтой-ыг гадаад улсын нутаг дэвсгэрт эрэн сурвалжлах тухай мөрдөгчийн гаргасан саналтай танилцаад ОЛСОН нь:

..... овогтой нь /хэргийн утга/ гэмт хэрэг үйлдэж өдөр Монгол Улсын хилээр гарсан ба / Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-1.2 дахь заалтын аль тохирохыг бичих/ үндэслэл тогтоогдон, түүнийг олон улсад эрэн сурвалжлах шаардлагатай байх тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.4 дүгээр зүйл 2, Прокурорын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол улсын иргэн.....овогтой-ыг оны сарын-ны өдрөөс олон улсад эрэн сурвалжлахыг зөвшөөрсүгэй.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн өгөхөөс
татгалзах тухай

Улсын Ерөнхий прокурор би, Улсын
..... /гадаад улсын эрх бүхий байгууллага/-аас эрүүгийн
дугаартай хэрэгт улсын иргэн овогтой -ыг
Монгол Улсаас шилжүүлэн авах тухай хүсэлт ирүүлснийг хянаад ОЛСОН нь:

..... улсын иргэн-ыг
..... гэмт хэрэг үйлдсэн
үндэслэлээр шилжүүлэн авахыг хүсэлт болгосон боловч

..... Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.4 дүгээр зүйлийн
4 дахь хэсгийн 4.1-4.3, 43.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-1.7 дахь заалтын
аль тохирохыг бичих/ үндэслэл тогтоогдож байх тул Прокурорын тухай хуулийн
48 дугаар зүйлийн 48.1.3 дахь хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1..... улсын иргэн, овогтой –ыг шилжүүлэн
өгөхөөс татгалзсугай.

2. Энэ шийдвэрийн талаар хүсэлтийг илгээсэн улсын эрх бүхий байгууллагад
мэдэгдэхийг Улсын Ерөнхий прокурорын газрын гадаад харилцаа, эрх зүйн
туслалцааны хэлтэст даалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай

Улсын Ерөнхий прокурор би, оны сарын-ны өдөр Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн дугаар зүйлийн дэх хэсгээр хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн /эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан/ дугаартай хэрэгт Монгол улсын иргэн..... овогтой-ыгулсаас шилжүүлэн авах тухай хүсэлттэй танилцаад ОЛСОН нь:

Монгол улсын иргэн овогтой нь
..... гэмт хэрэг үйлдэж улсын нутаг дэвсгэрт байгаа болох нь тогтоогдож, шилжүүлэн авах үндэслэлтэй байх тул Прокурорын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол улсын иргэн.....овогтой-ыг улсаас шилжүүлэн авахыг зөвшөөрсүгэй.
2. Шилжүүлэн авах ажиллагааг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу зохион байгуулахыг Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэст даалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн
өгөх тухай

Улсын Ерөнхий прокурор би,улсын
..... байгууллагаас эрүүгийн дугаартай
гэмт хэрэгт тус улсын иргэн.....-ыг шилжүүлэн авах тухай хүсэлт
ирүүлснийг хүлээн авч танилцаад ОЛСОН нь:

.....улсын иргэн.....нь
.....

..... гэмт хэрэг үйлдэж Монгол Улсад орж ирсэн /Монгол Улсад орж
ирсэн огноо, оршин сууж байгаа газар/ ба түүнийг шилжүүлэхээс татгалзах
үндэслэл тогтоогдоогүй, шилжүүлэн өгөх үндэслэлтэй байх тул Прокурорын
тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон
ТОГТООХ нь:

1..... улсын иргэн.....-ыг улсад
шилжүүлэн өгөхийг зөвшөөрсүгэй.

2. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийг биелүүлэхийг
..... цагдаагийн газарт даалгасугай.

3. Хүсэлтийн биелэлтэлд хяналт тавихыг прокурорын газарт
даалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шилжүүлэн
өгөхийг хойшлуулах тухай

Улсын Ерөнхий прокурор би,улсын
..... байгууллагаас эрүүгийн дугаартай
гэмт хэрэгт тус улсын иргэн.....-ыг шилжүүлэн авах тухай хүсэлттэй
танилцаад ОЛСОН нь:

.....улсын иргэн.....нь
өдөргэмт хэрэг үйлдсэний дараа Монгол Улсад орж ирсэн ба
түүнийг шилжүүлэхээс татгалзах үндэслэл тогтоогдоогүй, шилжүүлэн өгөх
үндэслэл тогтоогдож байгаа боловч тэрээр / Эрүүгийн хэрэг
хянан шийдвэрлэх тухай хуулийн 43.2 дугаар зүйлийн 2, Прокурорын тухай
хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан үндэслэлийн аль тохирохыг бичих/
нөхцөл байдал тогтоогдож байх тул Прокурорын тухай хуулийн 29 дүгээр
зүйлийн 29.4 дахь хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.....улсын иргэн.....-ыг шилжүүлэн өгөхийг
хойшлуулсугай.

2. Шилжүүлэн өгөхийг хойшлуулсан үндэслэл арилмагц шилжүүлэн
өгөх ажиллагааг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу зохион
байгуулахыг Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн
туслалцааны хэлтэст даалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар

.....
хот, сум

Хорих ял шийтгүүлсэн хүнийг
шилжүүлэх тухай

Улсын Ерөнхий прокурор би, шүүхийн
шийдвэрээр гэмт хэрэгт жилийн хорих ял шийгүүлж
..... хорих ангид ял эдэлж байгааулсын иргэн
.....-нээс хорих ялаа эх орондоо үргэлжлүүлэн эдлэх тухай
гаргасан хүсэлттэй танилцаад ОЛСОН нь:

.....улсын иргэнНь /
хэзээ, аль шүүхийн шийдвэрээр, ямар ял шийтгэгдсэн, ял эдэлсэн хугацаа,
үлдсэн ял шийтгэлийн хугацааг бичих/ ба хууль, олон улсын гэрээнд заасан
шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэл тогтоогдоогүй тул Прокурорын тухай
хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай
хуулийн 44.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ
нь:

1.улсын иргэн..... –ий ялаас эдлээгүй үлдсэн
хорих ялыг үргэлжлүүлэн эдлүүлэхээр улсад шилжүүлэн
өгөхийг зөвшөөрсүгэй.

2. Шилжүүлэн өгөх ажиллагааг олон улсын гэрээ, эрүүгийн хэрэг хянан
шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг Улсын
Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс,
Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст тус тус даалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,

ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН

ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)

(гарын үсэг)

(нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Хорих ял шийтгүүлсэн хүнийг харъяат улсад нь
шилжүүлэн өгөхөөс татгалзах тухай

Улсын Ерөнхий прокурор би, шүүхийн
шийдвэрээр гэмт хэрэгт жилийн хорих ял шийгүүлж
..... хорих ангид ял эдэлж байгааулсын иргэн
.....-нээс ялаа эх орондоо үргэлжлүүлэн эдлэх тухай гаргасан
хүсэлттэй танилцаад ОЛСОН нь:

.....улсын иргэнНь /
хэзээ, аль шүүхийн шийдвэрээр, ямар ял шийтгэгдсэн, ял эдэлсэн хугацаа,
үлдсэн ял шийтгэлийн хугацааг бичих/ ба /Эрүүгийн
хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 44.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн
1.1-1.6 дахь заалтын аль тохирохыг бичих/ шилжүүлэн өгөхөөс татгалзах
үндэслэл тогтоогдож байх тул Прокурорын тухай хуулийн 30 дугаар зүйлийн
30.1, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 44.1 дүгээр зүйлийн 2
дахь хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

- 1.....улсын иргэннээс эх орондоо ялаа үргэлжлүүлэн
эдлэх тухай хүсэлтийг хүлээн авахаас татгалзсугай.
2. Энэ шийдвэрийг хүсэлт гаргасан этгээдэд танилцуулсугай.
3. Шийдвэрт гомдол гаргах эрхгүй болохыг дурдсугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Хорих ял шийтгүүлсэн хүнийг
шилжүүлэн авах тухай

Улсын Ерөнхий прокурор би,улсад хорих ял
эдэлж байгаа, Монгол Улсын иргэн,.....овогтой-нээс эх
орондоо ялаа үргэлжлүүлэн эдлэх тухай хүсэлт гаргасныг хүлээн авч танилцаад
ОЛСОН нь:

Монгол Улсын иргэн овогтой /биеийн
байцаалт бичих/
..... /хэргийн утга бичих/ гэх хэрэгт.....
улсын.....шүүхийн оны сарын-ны өдрийндугаартай шийтгэх
тогтоолоор /шийтгэх тогтоолоор оногдуулсан ял шийтгэлийн талаар бичих/
ял шийтгүүлж, /эдэлсэн ял шийтгэлийн талаар
бичих/..... эдэлсэн байна.

...../шилжүүлэн авах үндэслэлийг бичих/ үндэслэл тогтоогдож байх
тул Прокурорын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, Эрүүгийн хэрэг хянан
шийдвэрлэх тухай хуулийн 44.3 дугаар зүйлийн 2-т заасныг удирдлага болгон
ТОГТООХ нь:

- 1.Монгол Улсын иргэнийн эдлээгүй үлдсэн хорих ялыг
эдлүүлэхээр Монгол Улсад шилжүүлэн авахыг зөвшөөрсүгэй.
- 2.Шилжүүлэн авах ажиллагааг олон улсын гэрээ, эрүүгийн хэрэг хянан
шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг Улсын
Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс,
Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст тус тус даалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)
(гарын үсэг) (нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Хорих ял шийтгүүлсэн хүнийг Монгол Улсын
нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх тухай

Улсын Ерөнхий прокурор би, улсаас
улсын шүүхийн шийдвэрээр ял эдэлж байгаа улсын харъяат
иргэнийг шижлүүлэн авах ажиллагааг зохион байгуулахад Монгол Улсын нутаг
дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх тухай хүсэлт ирүүлснийг хянаад ОЛСОН нь:
.....улсын-ыг оны сарын....-ны
өдрөөсоны ...сарын ...-ны өдрийн хоорондулсаасулсын нутаг
дэвсгэрт
...../хорих ял
шийтгүүлсэн хүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх
зорилгыг бичих/ байх тул түүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр /агаарын
тээврийн хэрэгслээр, газраар дамжуулан өнгөрүүлэх үндэслэлтэй байна.

Иймд Прокурорын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дахь хэсэгт
заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.улсын иргэн.....-ыг оны сарын....-ны
өдрөөсоны ...сарын ...-ны өдрийн хооронд Монгол Улсын нутаг дэвсгэрээр
дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хорих ял шийтгүүлсэн хүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан
өнгөрүүлэх ажиллагааг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу
зохион байгуулахыг Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа,
эрх зүйн туслалцааны хэлтэс, Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих
хэлтэст тус тусдаалгасугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,

ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН

ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ (.....)

(гарын үсэг)

(нэр)

ПРОКУРОРЫН ТОГТООЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр Дугаар хот, сум

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг
үргэлжлүүлэхээр хавтаст хэргийн материалыг
гадаад улсад шилжүүлэх тухай

Улсын Ерөнхий прокурорын газрын.....прокурорын газрын
хяналтын прокурор би, мөрдөгч –ээс эрүүгийн
..... дугаартай хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг
улсад үргэлжлүүлэн шалгуулах санал гаргаж ирүүлснийг хянаад ОЛСОН нь:

.....улсын иргэннь Монгол Улсад /хэргийн
утга/ гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлох баримтуудаар тогтоогдож
байх ба тэрээр оны сарын....-ны өдөр Монгол Улсын хилээр
гарсан, улсад амьдарч байгаа болох нь тогтоогдсон
байна.

Эрүүгийн хэрэгт хийгдвэл зохих ажиллагааг бүрэн явуулсан.....
байх тул түүнд холбогдох эрүүгийн хэргийн материалыг шилжүүлэх үндэслэлтэй
байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.5 дугаар зүйлд
заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн..... дугаартай хэргийг улсын мөрдөн
шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад шилжүүлсүгэй.
2. Энэ тухай хохирогч, иргэний нэхэмжлэгч нарт мэдэгдсүгэй.
3. Хэрэгт хураан авсан, битүүмжилсэн..... эд зүйлийг
шийдвэрлэсүгэй.
4. Хэргийн хувийг архивт шилжүүлсүгэй.

ХЯНАЛТЫН ПРОКУРОР (.....)
(гарын үсэг) (нэр)

Улсын Ерөнхий прокурорын
2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн
А/16 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ЭРХ ЗҮЙН
ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ
ТУХАЙ ХҮСЭЛТ**

ХААНА: Хүсэлт хүлээн авах улсын эрх бүхий байгууллагын нэр, хаягийн мэдээлэл

ХААНААС: Хүсэлт гаргаж байгаа улсын эрх бүхий байгууллагын нэр, хаягийн мэдээлэл

ХЭРГИЙН ТОВЧ УТГА:

Хэнд холбогдуулан ямар гэмт үйлдлийг шалгаж тогтоохоор мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа талаар болон хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолын огноо, дугаарыг бичнэ.

ХҮСЭЛТИЙН ТОВЧ АГУУЛГА:

Эрүүгийн хэргийн талаар тогтоолгохыг хүсэж байгаа мөрдөн шалгах ажиллагааны товч агуулгыг бичнэ.

ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ:

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хоёр талт гэрээ болон Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэслэл болгох зүйл, заалтыг бичнэ.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээгүй тохиолдолд тухайлсан харилцааг зохицуулсан олон улсын гэрээ, конвенци болон харилцан адил байх зарчмыг үндэслэж эрх зүйн туслалцаа хүсэж болно.

ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ БИЕИЙН БАЙЦААЛТ:

Овог нэр:

Төрсөн он, сар, өдөр:

Иргэний харъяалал:

Оршин суугаа хаяг:

Шаардлагатай бусад баримтууд:

ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛ, ЯЛ ШИЙТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэгт заасан гэмт хэргийг

шалгаж байгаа талаар болон тухайн гэмт хэргийн ял шийтгэлийн төрөл, хэмжээ б хөөн хэлэлцэх хугацааны талаар бичнэ.

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААГААР ТОГТООГДСОН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар болон гадаад улсад явуулах мөрдөн шалгах ажиллагаатай холбоотойгоор эрүүгийн хэрэгт тогтоогдсон нөхцөл байдал, нотлох баримтын талаар бичнэ.

ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ШААРДЛАГА:

Гадаад улсад мөрдөн шалгах ажиллагаа явуулах болсон шаардлага, хүсэлт болгож байгаа мөрдөн шалгах ажиллагаа нь эрүүгийн хэрэгт ямар ач холбогдолтой болохыг бичнэ.

ХҮСЭЛТ БОЛГОЖ БҮЙ МӨРДӨН ШАЛГАХ ТОДОРХОЙ АЖИЛЛАГАА:

Хүсэлт болгож байгаа эрх зүйн туслалцаа, тухайн улсын нутаг дэвсгэрт хийгдэх мөрдөн шалгах тодорхой ажиллагааны талаар бичнэ. Авах туслалцааны төрлөөс хамаарч хүсэлтэд шаардлагатай мэдээллийг тусгана. Тухайлбал:

